

ГҮНЗГИЙ МЭД

MONGOLIAN ECONOMY

2015 оны 05 сар. №12 (091)

www.mongolianeconomy.mn

ӨР

Ди Мауро: Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч
өртөмтгий байна


УУЛ УУРХАЙ

Эргүүлэг

ЭДИЙН ЗАСАГ

Хоолтой хонох хяслан

ДАШИЙН ШОГ



Шог зургийг А.Амарсайхан



БИЗНЕСИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ 2015

2015 ОНЫ 6 ДУГААР САРЫН 18-20, ИХ ТЭНГЭР ЦОГЦОЛБОР, УЛААНБААТАР

“Бизнесийн дээд хэмжээний уулзалт”-ын гол зорилго нь дотоодын компаниуд болон бусад бизнесийн боломжуудыг гадны хөрөнгө оруулагчдад танилцуулах, түншлэл тогтоох явдал юм.

Хөтөлбөрт:

- ✓ Бизнесийн зохицуулалт
- ✓ Дэд бүтцийн төслүүд
- ✓ Хөрөнгийн зах зээл
- ✓ Салбаруудын мэдээлэл

Бусад боломж:

- ✓ 400 гаруй удирдах төвшний мэргэжилтнүүд
- ✓ 20+ төслүүдийн танилцуулга
- ✓ Танилцах аяллууд



Цахим бүртгэл: <http://bizsummit.mn/registration/>



Нартай
Тэрэлтэй
Ирээдүй!

Luci® Lux



Luci® Original



Luci® Aura



“MPOWERD” компанийн албан ёсны борлуулагч:

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг Ерөнхий сайд Амарын гудамж 2,
Өнгөт хэвлэл компаны байр 2-р давхар

Утас: 9910-5664

Ногоон хөгжлийн төлөө

**MONGOLIAN
ECONOMY**

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:

Д.БЭХБАЯР / 9999-4248

Үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

Сэтгүүлийн редактор:

Б.ҮҮРИЙНТУЯА

Англи хэлний редактор:

О.ТҮВШИН

Вэб редактор:

Б.ЭНХЦЭЦЭГ

Сэтгүүлчид:

А.БҮРЭНЖАРГАЛ

Г.ОРХОН

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Дизайнер:

С.ЭРДЭНЭЦОГ

Маркетингийн менежер:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904

Ч.ҮҮРИЙНТУЯА / 9409 2905

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

I хороо, Энхтайвны өргөн чөлөө.

Экспресс тауэр. 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

Утас/Факс: 976 - 7011 5476

"Улаанбаатар Принт" ХХК-д хэвлэв

WWW.UBPRINT.MN

Борлуулах цэгүүд:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетин бүх салбар

"Макс" супермаркетин бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"GRAND PLAZA"

"METRO MALL"

"SKY" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр

"Max mall" дэх салбарууд

ЗАХИАЛГЫН ҮНЭ:

НЭГ ДУГААР

15,000₮

УЛИРАЛ /6 ДУГААР/

90,000₮

ХАГАС ЖИЛ /12 ДУГААР/


180,000₮

ЖИЛ /24 ДУГААР/

360,000₮

БОРЛУУЛАЛТЫН ҮНЭ:

180,000₮



Дэлхийн хаанаас ч онлайн
сэтгүүлдээ 50% хямдарлтайгаар
унших боломжтой боллоо
sub@mongolianeconomy.mn
marketing@mongolianeconomy.mn

50%



**MONGOLIAN
ECONOMY**

Их уншааг
Илүүг хэмнэ!

Сэтгүүл захиалга	Дугаарын тоо	ам.доллар	50% Хямдарсан үнэ
1 удаа	1 дугаар	\$ 6	Х
Улирлаар	6 дугаар	\$ 36	\$21.99
Хагас жилээр	12 дугаар	\$ 72	\$39.99
Бүтэн жилээр	24 дугаар	\$ 144	\$65.99





MONCON

MONGOLIAN CONSTRUCTION GROUP

Барилга угсралт

Дэд бүтэц, зам гүүрийн инженерийн байгууламж

Барилгын зураг төсөл, интерьер дизайн

Инженерингийн зөвлөх үйлчилгээ

Хот дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч

Үл хөдлөх хөрөнгийн удирдлага

Бидний Зүтгэл Хөгжлийн тулгуур

V Блок 14-р давхар, UNION BUILDING
Нарны зам-62, 1-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 75752161 Вэб: www.moncon.mn

ЭДИЙН ЗАСАГ

- 10 МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ ДАШИЙН ШОГ
- 11 MONGOLIAN ECONOMY СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ
- 14 ДИ МАУРО: МОНГОЛ ДАРААГИЙН ГРЕК ГЭЖ ХЭЛЭХГҮЙ Ч ӨРТӨМТГИЙ БАЙНА
- 19 Д.ЦЭРЭНДОРЖ: УЛС ТӨРИЙН ТОВЧОО НЭГ Л ӨДӨР НУРААД УНАСАН ШҮҮ
- 22 ХООЛТОЙ ХОНОХ ХЯСЛАН

УУЛ УУРХАЙ

- 26 ЭРГҮҮЛЭГ

ЕРТӨНЦ

- 30 БҮХ ЦАГ ҮЕИЙН ХАМГИЙН ХҮЧИРХЭГ ЭДИЙН ЗАСАГТАЙ ГҮРНҮҮД

БАНК, САНХҮҮ

- 32 БАНКЫН САЛБАРААР ДАМЖУУЛАН ГАДААД ХӨРӨНГИЙН УРСГАЛ ТАТАХ БОЛОМЖУУД

НИЙГЭМ

- 44 БИРДҮҮДЭЭС ЯАЖ САЛНА ДАА



...Монголын тухайд гэвэл, Грек шиг өрийн хямралд өртсөн нөхцлүүдтэй нүүр тулж байгаа нь үнэн. Жишээлбэл, санхүүгийн салбарын сул хөгжил, ашигт малтмалд суурилсан эдийн засагтай гэх мэт. Үүн дээр нэмээд мөнгөн валютын хямралд өртөх эрсдэлтэй...



...Ажил хийгээд ч нэмэр алга. Цалин цагтаа бүүхгүй, бэлэн мөнгөний эргэлт хаа хаанаа зогчихсон байна. Арга ядахдаа цалин бүүхаар авна гэж бодоод монетан гинжээ ломбарданд тавьчихаад хоногийн хоолоо залгуулах санаатай явж байна. Хоолтой хонох ийм хяслантай болж дээ. Өмнө нь асуудал тулгарсан ч хоол хүнсэн дээрээ гацаж байгаагүй юм даа” хэмээсэн юм...



ПОЛЬШ



Польшийн Эдийн засгийн яамнаас боловсруулсан “Зах зээлийн экспортын сэргэлт” сурталчлан дэмжих хөтөлбөрийг тус улсын сурталчилгааны “М” агентлаг хэрэгжүүлж байгаа билээ. Уг хөтөлбөрийн хүрээнд Польш улсын хүнс, хөнгөн үйлдвэр болон уул уурхайн салбарынхан манай улсын бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байна. Хоёр улсын бизнес эрхлэгчид Польш улсын Варшав хотод бизнес уулзалт хийж буй. Уг уулзалтад оролцохоор манай улсаас “Эрдэнэс Монгол” ХХК, “Шивээ овоо” ХК, “Макс” групп тэргүүтэй зургаан аж ахуйн нэгжийн төлөөлөл 13-ны өдөр Польш улсыг зорьсон.

Бизнес эрхлэгчид тус хөтөлбөрийн хүрээнд зургаан өдрийн турш бизнес аялалд оролцож, Польшийн бизнес эрхлэгчидтэй уулзалт хийх бөгөөд тус улсын уул уурхайн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн төлөөлөл бүхий гурван компанийн төв байранд зочлох юм. Зохион байгуулагчдын зүгээс Монголын бизнес эрхлэгчид Польшийн эдийн засгийн тусгай бүсийн талаар ойлголттой болох боломжийг түлхүү онцолж харж байгаа аж.

Польш улс эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд тус улсын зүгээс 11 оронд худалдаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх санал тавьжээ.

ЗЭС



Лондонгийн металлын бирж дээр

нэг тонн зэсийн ханш өнгөрсөн сарын 7-нд 6050 ам.доллар байсан бол энэ сарын 7-ны хаалтын ханшаар 6437 ам.долларт хүрчээ. Энэ нь тус таваарын ханш 380 гаруй ам.доллараар өссөн дүн юм. Өнөөдрийн байдлаар уг бирж дээрх нэг тонн зэсийг бэлнээр худалдаалах үнэ 6395.5 ам.доллар байна.

Ханшийн өсөлтөд БНХАУ-ын зэсийн эрэлт нэмэгдэх таамаг, нөгөө талаас томоохон үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэл буурах болсон нь нөлөөлжээ. Учир нь урд хөрш дэлхийн зах зээл дээрх зэсийн нийт нийлүүлэлтийн 40 гаруй хувийг дангаараа эзэлдэг бөгөөд тус улсын Засгаас барьж буй эдийн засгаа эрчимжүүлэх бодлого ханшийн өсөлтөд нөлөөлж буйг шинжээчид цохон тэмдэглэж байна.

Манай улсын хувьд энэ сард нэг тонн зэсийг 6024.97 ам.доллараар экспортод гаргахаар үнээ тооцжээ.

ВЬЕТНАМ



Вьетнамын Хүнс, хөдөө аж ахуйн яамны мал эмнэлгийн газрын төлөөлөгчид энэ сарын 20-30-ны хооронд манай улсад ирж, мал нядлах болон мах боловсруулах 20 үйлдвэрт хянан магадлагаа хийх аж. Ингэхдээ хонь, ямааны мах экспортох гэрээний үндсэн дээр магадлагаа гаргана.

Вьетнамын тал мал нядлах үйлдвэрт малын гарал үүслийг хэрхэн хянаж байгаа, үйлдвэрт дотоод болон хөндлөнгийн хяналт хэр байгааг шалгана. Харин боловсруулах үйлдвэрүүдийг технологийн талаас нь хянана гэжээ. Төрийн байгууллагуудыг хооронд нь хөндөнгийн хяналт хийлгэж хянана. Мөн мах, махан бүтээгдэхүүнээ хилийн боомтоор нэвтрүүлэх системтэй нь танилцаж, дээрх хяналт шалгалтын үндсэн дээр шийдвэрээ гаргах аж.

Монгол Улс 54 сая малтай. Үүнээс өнгөрсөн онд 10.3 сая мал нядалж мах бэлтгэсэн бол энэ онд 11.8 саяг

нядалжээ. Эндээс бид дотоодынхоо махны хэрэгцээг бүрэн хангаж, уг бүтээгдэхүүнийг экспортод гаргах нөөц бийг харж болох. Түүнчлэн бид жилдээ 6.4 мянган тонн тэмээний мах, 60 мянган тонн үхрийн мах, адууных 38 мянга, хониных 38 мянга, ямааны мах 132 мянган тонныг зөвхөн идшинд бэлтгэх бололцоотой гэх судалгаа бий.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



“Азия пасифик пропертис” ХК, “Монгол мах экспо” ХК болон “Бишрэлт индустриал” ХК-иас гаргасан компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болж үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд өгчээ. Хүсэлтийг үндэслэн 2015 оны тавдугаар сарын 14-ний өдрөөс дээрх компанийн арилжааг зогсоохыг Санхүүгийн зохицуулах хорооноос мэдэгдсэн байна.

ГАДААД ХУДАЛДАА



2015 оны дөрөвдүгээр сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 511.8 сая ам.доллараар буурснаар 418.0 сая ам.долларын ашигтай гарчээ. Энэ нь экспорт 1.4 хувиар өсч, импорт 32.2 хувиар буурсантай холбоотой байна.

Тайлант хугацааны эцэст гадаад худалдааны эргэлт 2486.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16 хувиар буюу 472.1 сая ам.доллараар буурсан. Үүнд экспорт 19.8 сая ам.доллараар өссөн ч импорт 491.9 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. ■

ДЭЛХИЙД

НЭГ БАРРЕЛЬ ГАЗРЫН ТОСНЫ ҮНЭ 60 АМ.ДОЛЛАРТ ХҮРЛЭЭ



Энэ жилийн турш уналттай байсан түүхий газрын тосны үнэ анх удаагаа нэг баррель нь 60 ам.долларт хүрлээ. Нэг баррель тосны үнэ 2008 онд хамгийн өндөр буюу 147 ам.долларт хүрснээс хойш буурч эхэлсэн. Хятад болон Европын эдийн засгийн өсөлт удааширч буйтай холбоотойгоор газрын тосны эрэлт буурсан. Хятадын эдийн засаг бусад оронтой харьцуулахад илүү хурдан өссөн хэвээр байгаа ч өсөлтийн хувь хэмжээ хоёр оронтой тоонд хүрэхгүй байгаа юм. Өнгөрсөн жил АНУ дотоодын занарын чулуулаг ордоос газрын тос гаргаж эхэлснээр дэлхийн хамгийн том газрын тос үйлдвэрлэгч болсон нь Саудын Арабыг давсан үзүүлэлт болсон. Энэ утгаараа АНУ-ын газрын тос болон байгалийн хийн нөөц өссөнөөр гаднаас авах газрын тосны эрэлт хэрэгцээ ч мөн тодорхой хэмжээгээр буурсан юм. 2014 оны арваннэгдүгээр сард Вена хотод болсон ОПЕК-ийн хагас жилийн уулзалтын үеэр 12 гишүүн орны дийлэнх нь үйлдвэрлэлийг буруулж үнийг нэмэхийг дэмжсэн ч Саудын Арабын газрын тосны сайд Али Аль-Наими үүнийг эсэргүүцсэн юм.

НЭГДСЭН ВАНТ УЛСЫН СОНГУУЛЬ 2015



Нэгдсэн Вант улсын 2015 оны парламентын сонгууль тавдугаар сарын долоонд болж өндөрлөсөн. Сүүлийн жилүүдэд болоогүй өрсөлдөөнтэй

сонгууль болох таамаг байсан ч Дэвид Камерон Ерөнхий сайдын албаа хадгалж чадлаа. Урьдчилсан санал асуулгаар парламентад аль ч нам дийлэнх болохгүй гэж байсан бол санал асуулга таамгийг няцаасан юм. Хөдөлмөрийн нам болон Либерал Ардчилсан нам бүрэн ялагдал хүлээж Консерватив нам 1992 оноос хойш анх удаа парламентад дийлэнх болж засгийн газраа байгуулах боллоо. Уг сонгуулиар Шотландын Үндэсний нам өрсөлдсөн 59 тойргоос 56 тойрогт ялалт байгуулсан нь гэнэтийн мэдээ болсон. Сонгуулийн өмнө парламентад 56 суудалтай байсан Либерал ардчилсан нам ердөө найман суудалтай үлдсэнээр Шотланд дахь нөлөө нь үгүй болсон. Хөдөлмөрийн намын тэргүүн Эд Миллибанд, Либерал Ардчилсан намын тэргүүн Ник Клегг, Их Британийн тусгаар тогтнолын намын тэргүүн Найжел Фараж нар сонгуульд бүрэн ялагдал хүлээсний дараагаар албан тушаалаа орхих болсоноо зарлалаа.

БНХАУ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭГЭЭ БУУРУУЛЛАА



Удааширч эхэлсэн эдийн засгийн өсөлтөө дэмжихийн тулд Хятадын Төвбанк хагас жилийн дотор гурав дахь удаагаа бодлогын хүүгээ буурууллаа. Бодлого ирэх саруудад ч үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд ирэх жил БНХАУ-ын эдийн засгийн өсөлт долоон хувьд хүрч сүүлийн 20 жилд тохиогоогүй хүнд жил болох магадлалтай аж. Нэг жилийн зээлийн хүү 5.35 хувиас 5.1 хувь болж буурчээ. Мөн тус банк тогтоосон нөөцийн хэмжээгээ багасгасан бөгөөд цаашид ч буулгах төлөвтэй байна. Зээл олголт буурч, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь Хятадын банкуудад хүнд тусч байгаа аж. Гэсэн ч мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Хятадын Засгийн газар болон Төвбанкны авсан арга

хэмжээ үр дүнгээ өгч Хятадын эдийн засаг аажмаар тогтворжино гэж үзэж байгаа аж.

АНУ-ЫН ИНФЛЯЦИ БУУРЧ АЖЛЫН БАЙР НЭМЭГДЛЭЭ

Дөрөвдүгээр сард АНУ-ын ажил олгогчид 223 мянган шинэ ажлын байр бий болгож, улмаар инфляцийн түвшин 5.4 хувь болж буурлаа. Хэдий тийм боловч Обамагийн консерватив шүүмжлэгчид энэхүү сэргэлтийн жинхэнэ үр дүн цалин нэмэгдээгүй цагт мэдрэгдэхгүй гэв. Бага цалинтай ажлын байр болох жижиглэн худалдаа болон үйлчилгээний салбараас илүүтэй өндөр цалинтай барилга болон бизнесийн салбарт ажлын байр нэмэгджээ. Харин дөрөвдүгээр сард эрчим хүчний салбарт 10 мянган ажлын байрыг цомхотгосон нь газрын тосны үнэ буурсантай холбоотой аж. Ажил хайхаа зогсоосон хүмүүсийг ажилгүйчүүдийн тоонд авч үздэггүй бөгөөд үүнийг тооцвол хөдөлмөр эрхлэлтийн түвшин сүүлийн арван жилийн доод түвшинд хүрэхээр байгаа аж. Эдийн засагчид АНУ-ын Төв банкны хүүгээ нэмэх эсэхийг ажиглаж байна. Тус банкны хүү 2008 оноос хойш тэг орчим хувьтай байсан юм.

Томоохон банкууд буруутай

АНУ-ын Хууль зүйн департамент шалгалт хийсний эцэст томоохон таван банк гадаад валютын зах зээл дээр хуйвалдаан хийсэн нь тогтоогдож гэм буруутай гэж үзэж байна. "JPMorgan Chase & CO", "Citigroup", Шотландын Эзэн Хааны банк, "Barclays" болон Швейцарын "UBS" банк тус хэрэгт шалгагдаж байгаа аж. Урд өмнө ийм хэргүүд гарч байсан ч сүүлийн жилүүдэд толгой компани гэм буруутайд тогтоогдсон явдал гарч байгаагүй. "Энрон" компани 2002 онд гэм буруутай нь тогтоогдож ял хүлээсний улмаас олон мянган ажилтан цомхотголд орсон үүнээс хойш АНУ-ын эрх баригчид томоохон компаниудтай холбоотой эрүүгийн хэрэгт оролцохоос татгалзаж байжээ. Өмнө нь "HSBC" банк Мексикийн гэмт хэргийн бүлэглэлтэй хамтарч ажилласан хэргээр шалгагдаж байсан. Мөн "JPMorgan" луйварийн хэрэг хийсэн Берни Меддофын талаар мэдээлэл өгөөгүй хэрэгт сэжиглэгдэж байсан. ■

Монголын эдийн засаг дашийн шог

Д.Бэхбаяр

Монголчууд эртнээс аливаа зүйл бүтэлгүйтэж, дампуурч унахыг дашийн шог гэж ярьж ирсэн билээ. Энэ утгаар авч үзвэл Монголын эдийн засаг дашийн шог боллоо. Хөгжлийг, өсөлтийг илэрхийлдэг бүх үзүүлэлт доошиллоо. Ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулалт бүр хасах дүнтэй гарч байна. 4-5 жилийн өмнө жилдээ 4,6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орж ирж байсан бол энэ оны эхний улирлын дүнгээр хасах 100 сая доллартай сууж байна. Өнгөрсөн жил УИХ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн бичиг баримтыг батлахдаа эдийн засгийн өсөлтийг долоон хувь гэж төсөөлж байсан бол энэ төсөөлөл өнөөдөр дөрвөн хувь хүрэхтэй үгүйтэй. Жилийн эцэс гэхэд гурван хувь, байдал өөрчлөгдөхгүй бол нэг ч хувь хүрэхгүй нь.

Иргэдийн амьдрал ийм байна

Иргэдийн амьдрал ямар буйгаар л улс орны хөгжлийг тодорхойлдог. Мөн төр, засгийг хэр удирдаж байгааг гэрчилнэ. Тэгвэл ард түмний амьдрал өнөөдөр улам л дордож байна. Хотын захын хорооллын иргэд нэг бөөрөнхий талхыг тав хувааж идэж байна. Нэг зуун грамм наранцэцгийн тосоор долоо хонохыг хичээж байна. Дунд түвшний амьдралтай өрхийн эзэгтэй нар алт, монетан ээмэг, бөгжөө ломбардад тавиад дуусаж байна. Тэд хүүний мөнгөө ч төлөх чадваргүй болж, үнэт эдлэлээ алдаж эхэлжээ. Банкинд зээлтэй иргэд гэрийнхээ үнэт эдлэл, цахилгаан барааг зарж борлуулж, нэг сарын зээлээ арайхийн төлөх замаар өдөр хоногийг аргацааж байна.

Хувийн хэвшлийнхний хувьд хаалгаа

баригсдын тоо нэмэгдэж, ажилтнуудаа ч явуулах нь ихэсч ирлээ. Тэд татвараа өгч чадахгүйд хүрч байгаа болохоор тэднээс угжиж амьдардаг төрийн байгууллагууд цалингаа тавьж чадахгүй, банкнаас зээлэх болжээ.

Банк, санхүүгийн байгууллагууд үндсэндээ зогслоо. Тэд Монголбанк, Засгийн газрын бондыг авахыг илүүтэйд үзэж, баталгаатай хэдхэн түншүүддээ зээл өгч байна. Дэлгүүр, хоршоо, баар хоосорлоо. Иргэд яаж өдрийн хоолтойгоо хэд хоног тэсэх үү гэсэн тооцоонд орж эхэлжээ. Эдийн засгийн идэвхжил зогсож, эдийн засаг элгээрээ хэвтэж байгаа нь үнэн төрх боллоо.

Улстөрчдийн амьдрал ийм байна

Харин улстөрчдийн амьдрал буцалж байна. Эдийн засгийн хямрал, иргэдийн амьжиргаа буурч, ядуурал, ажилгүйдэл ихэсч, иргэд гар дээрээ бэлэн мөнгөгүй болж байгаа нь тэдэнд хамаагүй аж. Тэд зөвхөн өөрсдийн эрх ашгийг бодож, эрх мэдлийн суудлаасаа үлдсэн хугацаанд яаж, ямар арга замаар улсын мөнгийг хэнтэй нийлж авах талаар л бодож байна. Тэд телевизийн камерийн өмнө иргэдээ, улс орноо бодсон хуурамч царай гаргачихаад хөшигний цаана хөнжилдөө орон хэлхэлдэж байна. Тэд энэ хямралыг далимдуулан яаж улстөр хийхээ ярилцаж, нэгнийхээ өрөө өрөөгөөр орж гаран инээлдэн явна.

Эрх баригчид хүнд байдалд байна. Тэд өөрсдийн алдаатай бодлогоо ухамсарлаж бас урагш явж ч чадахгүй, хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага шиг болжээ. Засгийн газрын тэргүүн Ч.Сайханбилэг хэдийгээр том төслүүдээ явуулах л хямралаас гарах хамгийн зөв арга зам гэж зүтгэж



байгаа ч УИХ-даа атгуулчихсан дуугүй хүн явах. УИХ гэж 76 томчуул. Асуудлыг ул суурьтай авч үзэж, анхаарч, эх орноо, иргэнээ төлөөлж ярина гэж гарч ирсэн хэдэн хүн өнөөдөр хэнтэй, хэний намтай эвлэрч нэгдвэл хэдэн төгрөг хожих бол гэсэн хоноцын сэтгэлгээтэй хүмүүс болжээ. Тэд улс орныг хөгжүүлэхэд ямар үүрэг гүйцэтгээд байна вэ. Хуулийн төслүүд ороод ирүүт өөрсдийн нам, бүлэг, эрх ашигтаа нийцүүлж, батлахын төлөө, заалт бүр дээр ажиллаж суудаг л хүмүүс. Гаргасан хууль тогтоомждоо хяналт тавьж, шударга, хүчтэй ажиллаж байгаа парламентчид гэж хэлэхэд хэцүү нэртэнгүүд. Дээр нь засгийнхаа ажлыг явуулдаггүй, нураах, гацаах, улстөржүүлэхийн төлөө байдаг нь бас үнэн юм.

Ардын намынхан гэж нэг л дотроо баярласан хүмүүс байх. 2016 оны УИХ-ын сонгуулийн ялалтын тугийг өргөчихсөн, хэдэн яамны сайд, агентлагийн даргын албыг бараг л хуваарилж аваад түүндээ итгэчихсэн яваа сурагтай. Тэд хямралыг, ард түмний сэтгэхгүйг өөрийн намд ашигтайгаар эргүүлэхийг бодож, улс төр хийж буй нь хөөрхийлөлтэй.

За дараа нь хэдэн жижиг намынхан бас л хүндрэлийг далимдуулан бялуу хүртчих санаатай байгаа.

Одоо тэгээд яах вэ?

Нэгдүгээрт, Зардлаа боломжит хэмжээнд хэмнэх. Хоёрдугаарт, эдийн засгийг тэлж, хөрөнгө оруулалт татах. Гуравдугаарт, том төслүүдээ хөдөлгөх. Уг нь хямралаас гарах арга замыг эдийн засагчид ингэж тодорхойлоод байгаа ч хэрэгжихэд хүндрэлтэй, өөрөөр хэлбэл асуудлыг улам улстөржүүлж, явуулахгүйд хүргэж байна. Энэ нь улстөрчдөд

ашигтай учраас тэр. УИХ-ын гишүүд бүгд л Оюутолгой,Тавантолгойг явуулах ёстой хэмээн камерийн өмнө иргэдээс оноо авахын тулд хэлнэ. Өрөөндөө ороод л өөрт ашигтай байх талд ажиллаж эхэлдэг. Энэ хоёр толгойг хөдөлгөөгүй цагт гаднын хөрөнгө оруулалт орж ирэхгүй нь ойлгомжтой.

Уг нь бол хилийн чанадад Монголыг чиглэсэн, сонирхсон хөрөнгө оруулагчид байна гэдэг. Гэвч тэд 2016 оны сонгууль хүртэл Монгол руу хөрөнгө хийх бодолгүй байгаа гэнэ. Дотоодын бизнесийнхэн ч хүлээлтийн байдалд орж, ажилтнуудынхаа цалинг тавьж л өдөр хоногийг өнгөрөөж буй тухай ярих.

Гадаад,дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд бүгд л ирэх сонгуулийг хүлээх байдалд байгаа бол улстөрчид нь сонгуулийн ажил руугаа орчихсон

явна. Тэгвэл эдийн засаг ийм муу үзүүлэлтэйгээр цааш явбал 2016 оныг хүрэх үү гэдэг асуудал босч ирж байна.

Төрийн ордонд хоёр асуудал яригдаж эхэлжээ. Нэгдүгээрт, Ч.Сайханбилэгийн Засгийн газрыг унагаж, дахин шинэ засаг гаргах. Дахиад л мэргэжлийн, авралын, хариуцлагатай Засгийн газар гаргаж ирэх тухай ярьж байна. Үнэхээрийн авралын Засгийн газар гарч ирлээ гэхэд тэдэнд ажиллах хугацаа хэр байна вэ?

Мөн тэд улстөрчдийн, УИХ-ын гарт орохгүйгээр ажиллаж чадах уу гэдэг бас л асуудал.

Хоёр дахь нь УИХ-ыг хугацаанаас нь өмнө тараах. Харин энэ хувилбарыг олон нийт ч яриад эхэлсэн байна. Ард түмнээ, эх орноо боддоггүй ийм Их хурлаар, засгаар яах юм бэ. 2016 оны

зургадугаар сар хүртэл ийм хүмүүсээр төрөө удирдуулаад яах юм бэ, төрөө гартаа авья гэсэн яриа ард түмний дунд түгж эхэлжээ. Олон ч хүн дэмжиж байгаа аж.

Нөгөө талдаа хариуцлагын системгүй байгаа нь хямралыг улам гүнзгийрүүлж байна. Өнөөгийн Засгийн газар уналаа, УИХ тарлаа гэхэд улс орныг ийм байдалд хүргэсэн буруутан хэн юм, тэдэнд ямар хариуцлага хүлээлгэх талаар тодорхой зүйл заалт, хариуцлагын систем манайд байхгүй. Бусад улсад сайн удирдлаа гээд шагнадаг, мөн муу удирдлаа гээд хариуцлага тооцдог системтэйг бид хардаг шүү дээ. Манайд хариуцлагын ямар систем байна аа. Улс орныг, эдийн засгийг дордуулсны хариуцлагыг хэн үүрэн юм, хэнтэй хэн хариуцлага тооцох вэ. ■

СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

-Таны бодлоор хямралаас гарах ямар гарц байна вэ?

-Засгийн газрыг унагах, УИХ-ыг хугацаанаас өмнө тараах тухай яригдах болжээ. Таны бодол?

Р.Амаржаргал: /УИХ-ын гишүүн/



-Төрийн ажил назгайраад юу ч биш боллоо. Хүмүүс төрийн ажилд хоноцын сэтгэлгээгээр хандаж байна. Хариуцлагын систем байх ёстой. Хариуцлага тооцох асуудал байхгүйгээс төрийн ажил ийм байдалд хүрлээ. Ирэх оны өсөлт таван хувь гэж ярилтгүй боллоо. Гол гарц бол том төслүүдээ явуулах нь зөв өө. Гэхдээ явуулахын тулд явуулж болохгүй. Монгол Улсын бодлого байх ёстой. Ер нь Монголын эдийн засгийг зөвхөн Оюутолгой, Тавантолгойгоор харахаа болих хэрэгтэй. Хөгжлийн өөр тухайлбал, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбартаа анхаарал хандуулж хөгжүүлэх дорвитой бодлого явуулах шаардлагатай байна.

Ч.Хүрэлбаатар: /УИХ-ын гишүүн/



-Эхний алдаа бол Засгийн газар өнгөрсөн хоёр жил төсвийн орлогыг худлаа тооцож оруулж ирсэн. 2013, 2014 оны төсвийн орлого нийлээд хоёр их наядар тасарсан. Энэхүү орлогыг Засгийн газар үнэт цаас гарган санхүүжүүлсэн. Хоёр дахь нь хөрөнгө оруулагчдад хэтэрхий хатуу хандсан. Хөрөнгө оруулалт өнөөдөр манай улсаас дайжиж байна. Ийм үед өсөлтийн тухай яриад ч хэрэггүй.

Улсын төсвөөс санхүүжүүлдэг хөрөнгө оруулалт таг зогссон, зөвхөн цалин тэтгэврийг л тавьж байна. Гэхдээ банкнаас зээлж шүү. Тэгэхээр зардлаа хэмнэж, эдийн засгийг татахын тулд хөрөнгө оруулалт татаж, том төслүүдийг хөдөлгөх хэрэгтэй. Тавантолгой, Оюутолгойг явуулж, төмөр зам, ТЭЦ-5-аа барих нь зөв. Өөр сонголт алга.



С.Дэмбэрэл: / УИХ-ын гишүүн/

-Монголын улс төр, эдийн засаг дампуу байна. 2008, 2009 оны хямралаар манай гол салбарууд бие биенээ чирээд авраад явж байсан бол өнөөдөр бүгд доошилж байна. Хөдөлмөрийн багтаамж ихтэй, ажиллах хүч олноор шаардагддаг уул уурхайн бус жижиг, дунд болон хүнсний үйлдвэрүүдэд улс төр, эдийн засгийн дампуурлын нөлөө их тусаж байна. Гарц, шийдлийн хувьд хамгийн эхлээд дотоод хүч бололцоогоо дээд зэргээр шавхаж ажиллах. Хоёрдугаарт, мөнгөний нийлүүлэлтээ нэмэгдүүлж, бодлогын хүүг бууруулах цаг болсон байх. Энэ үед л Монголбанк бодлогын хүүгээ идэвжүүлэх ёстой. Гуравдугаарт, уул уурхайн бус салбараа дэмжмээр байна. Зардлаа дээд цэгт хэмнээд байгаа мөнгөө зөв хуваарилаад л явах хэрэгтэй. Том төслүүдийг бүр байхгүй гээд бодоход ийм л арга хэмжээг богино хугацаанд авах шаардлагатай.

Д.Энхбат /Нээлтэй мэдлэг боловсролын сангийн захирал/


-Эдийн засаг хүнд байгаа нь бодит амьдрал дээр мэдрэгдэж байна. Ялангуяа, барилгын салбар болон компаниудын үйл ажиллагаа дээр илүү ажиглагдаж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ярьж буй тоо баримт үнэн бол Засгийн газар энэ гуравдугаар улиралд багтаан яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй.

-Ажил муу байхад заавал буруутныг хайдаг. Хэдэн жилийн өмнө дэлхийд эдийн засгийн хамгийн өндөр өсөлт үзүүлж байсан орон өнөөдөр ОУВС-ын "Стэнд бай" хөтөлбөрийг авах тухай ярих боллоо. Энэ хөтөлбөрийг авна гэдэг нь бид эдийн засаг, санхүүгийн удирдлага бусдад өгнө гэсэн үг. Энэ бол Засгийн газар, УИХ хоёулаа үүргээ биелүүлээгүйн илрэл. Гурав, дөрөвдүгээр улиралд байдал их хүнд болохоор байна. Тэгвэл Засгийн газар ч, УИХ ч огцрох нь гарцаагүй. Одоо яригдаж буй асуудал бол ирэх сонгуулийн чимээнээр хийж буй хоосон улстөр. Өнөөдөр Засгийн газар юм уу, УИХ огцорсноор асуудал шийдэгдэхгүй тул "яах вэ" гэдгийг одоо ярих хэрэгтэй.

Ч.Хашчулуун /Эдийн засагч, доктор/

-Эдийн засгийн өсөлтийг санхүүгийн хямралаас зааглах ёстой. Эдийн засгийн өсөлтийн гол шалтгаан нь Оюутолгойн үйлдвэр ашиглалтад орсонтой холбоотой. Төгрөгийн ханш суларсан, төсөв их алдагдалдалтай байна. Хүмүүсийн худалдан авах чадвар буурч, олон хүн ажлаасаа халагдаж байна.

-Их хурлын хувьд өөрийн үндсэн ажлаа хийхгүй байна. УИХ-ын үндсэн үүрэг нь сайн бодлого боловсруулах, сайн хууль батлах ёстой. Түүнээс биш аж ахуйн ажил хийгээд, төсвийн асуудалд орооцолдоод байх бололцоогүй. 76 гишүүн бүрт таалагдсан хөрөнгө оруулалтын төсөл, гэрээ байх боломжгүй. Тиймээс Засгийн газартаа дэмжлэг үзүүлээд том төслүүдээ явуулах л ёстой. Дараа нь харин үр дүн гарсан уу, үгүй юу гэдгийг тооцох ёстой. Их хурал үндсэн ажилдаа төвлөрч сонгуулийн өмнө үндсэн хууль, эрх зүйн асуудлуудаа шийдсэний дараа тарахад болохгүй юмгүй. Засгийн газрын хувьд, анх байгуулсан шалтгаан нь том төслүүдийг явуулах байсан. Төслүүдийг явуулах санал оруулсан ч УИХ алийг нь ч явуулаагүй байна. Тиймээс ажлыг нь хийлгэхгүй байж хариуцлага тооцно гэдэг утгагүй асуудал.

Д.Баасандорж /Трумэнс ХХК-ийн захирал/

-Иргэд гар дээрээ ямар ч мөнгөгүй, болсон. Хямрал хүн бүрт мэдрэгдэж байгаа. Өмнөд Солонгос улсын хөгжлийн гарцыг Монголд хэрэгжүүлж болох юм шиг санагддаг. Магадгүй Ким Ү Жүн шиг удирдагч Монголд хэрэгтэй байх.

-Засгийн газрыг унагах хэрэгтэй гэж бодохгүй байна. Унагалаа гэж бодоход оронд нь хэн гарах вэ, тэр хүн нь энэ хугацаанд юу хийж чадах вэ, хэдий хүртэл тогтвортой Засгийн газрыг тэргүүлэх вэ гэдэг маш бүрхэг. Харин УИХ-ын асуудал олон нийтийн ухамсраас шалтгаална.

Ж.Энхбаяр /УИХ-ын гишүүн/

-Монгол үндэстэнд томоохон сорилт даван туулах шаардлага үүслээ. Хэдэн тоо хэлье. Гадаад өр 20 тэрбум ам.доллар давсан, Засгийн газрын дотоод өр дөрвөн их наяд төгрөг буюу Монгол Улсад эргэлдэж байгаа зээлийн гуравны нэгийг Засгийн газар ашиглачихаад байна. Аж ахуй нэгжүүдэд буюу бодит салбарт мөнгөний нийлүүлэлт үндсэндээ зогслоо. Гадаадын хөрөнгө оруулалт тэгтэй тэнцсэн. Тэтгэвэр, цалингаа тавихад хүндрэл үүслээ. Шийдвэр гаргах түвшинд улстөр, эдийн засгийн бүлэглэлийн хэдэн толгой тойрсон хэрүүл л болж байна.

-Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг хийж ирээдүйн шинэ дүрмийг гаргаж өгөөд УИХ яаралтай тарах хэрэгтэй. Харин нийгмийг талцуулсан асуудлыг шинэ УИХ шийдэх ёстой. УИХ ард түмний дэмжлэгийг үндсэндээ алдаад дуусч байна. Засаг удирдах чадвараа алдахаар УИХ ард түмнийг төлөөлөх чадамжаа давхар алдаж байгаа юм. Шулуухан хэлэхэд, өнөөдрийн эдийн засгийн уналт УИХ-тай салшгүй холбоотой.

Э.Энхчимэг /Төрийн албан хаагч/

-Хямрал байна уу гэвэл байна. Бүр ч элгээрээ хэвтэл нөлөөлсөн юм алга. Ер нь ажиглаад байхад нийгмийн ихэнхид хямрал нөлөөлж байх шиг. Санхүүгийн ямар ч баталгаа алга. Залуучуудын ихэнх цалингийн зээлтэй. Гэтэл нэг өдөр гэнэтхэн цомхотгочих жишээний. Цалин нэмэх сургаар л юмны үнэ нэмэгддэг. Бодит байдал дээр төрийн үйлчилгээний ажилтнуудынхаас илүү төрийн захиргааны ажилтнуудын цалин нэмэгдсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор төрийн үйлчилгээний ажилтнууд эдийн засгийн хямралд хамгийн их өртдөг нь гэж бодож байна. Иргэдийг эдийн засгийн дарамтад оруулахгүйгээр татварын ачааллыг багасгаж, мөн жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжиж ажиллах нь хямралаас гарах нэг гарц байж болох юм.

-Хэрэггүй гэж бодож байна. Нэгэнт өөрсдийнх нь эхлүүлсэн ажлыг хугацаанд нь дуусгасан нь дээр. Хямралын үед ард иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүрэхгүй, аргацаасан мэдээллээр халхалж байгаа нь буруу байх. Ийм үед гарч болзошгүй олон эрсдэлийг төр засаг урьдчилан харж, бодит арга хэмжээ авах шаардлагатай. ■



**УИХ-ын дарга аа,
Ерөнхий сайд аа,**


Хэн хариуцлага хүлээх вэ ?

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




“ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ 2015 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЭЦЭСТ **587.8** ТЭРБҮМ ТӨГ БОЛЖ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХЭЭС **288.8** ТЭРБҮМ ТӨГ БУЮУ ХОЁР ДАХИН ӨСЧЭЭ.

2015 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР



2015 оны эхний дөрөвдүгээр сард эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.9 ихнадд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 244.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 139.2 тэрбум төгрөгөөр өсчээ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД



ВАЛЮТ	2014 IV	2015 IV
\$ АМ. ДОЛЛАР Жилийн өөрчлөлт	1 784.11₮ 25.9%	1 975.83₮ 10.7 %
€ ЕВРО Жилийн өөрчлөлт	2 464.69₮ 33.7%	2 132.42₮ - 13.5%
¥ ЮАНЬ Жилийн өөрчлөлт	286.64₮ 25.1%	318.62₮ 11.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Биатрис Ди Мауро: Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч өртөмтгий байна

Б. Үүрийнтуяа



Биатрис Вэдер Ди Мауро 2001 оноос хойш Майнцын Иоханс Гутенбергийн их сургуулийн Олон улсын макроэдийн засгийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. Тэрбээр 2004-2012 онд Германы эдийн засгийн шинжээчдийн хорооны гишүүнээр, 2002-2004 онд Швейцарийн эдийн засгийн зөвлөхүүдийн хороонд ажиллаж байсан бөгөөд Австри улсын Дэд Канцлерын зөвлөх хийж байсан. Түүнчлэн 1994-1996 онд Олон улсын валютын санд эдийн засагч, тус байгууллагын судалгааны хэлтэст эрдэм шинжилгээний ажилтнаар уригдаж байсан удаатай.

Тэрбээр манай улсад дөрвөн өдөр саатсан бөгөөд "UB Impulse: Чанартай өсөлт" цуврал лекцид уригдан "Улсын өрийн зохицуулалт: Европын холбооны туршлага" сэдвээр илтгэсэн. Энэ хүрээнд манай сэтгүүл түүнтэй Монгол Улсын өрийн асуудлаар ярилцсан юм.

-Монголын талаарх сэтгэгдлээсээ хуваалцахгүй юү?

-Би Монголд 20 жилийн өмнө ирж байсан. Улаанбаатар хотод танил зүйл үлдээгүй мэт эрс өөрчлөгдсөн байна.

Тухайн үед Улаанбаатар хот голдоо нэг том гандантай тосгон шиг л санагдаж байлаа. Харин одоо бол томоохон хот болж, их ч зүйл өөрчлөгдөж, хөгжсөн байна.

-Сайн талаараа юү? Эсвэл?

-Богино хугацаанд үсрэнгүй хөгжилд хүрч буй орнуудыг харах үргэлж гайхширмаар байдаг. Эргэн тойронд сүндэрлэж буй барилгуудаас харахад Монгол хөгжлийн ид үедээ явж буй нь илт байна. Гэхдээ энэ их бүтээн байгуулалтын үед үргэлж сэрэмжтэй байх хэрэгтэй. Учир нь ийм үед шаардлагагүй зүйлд ихээхэн хөрөнгө оруулалт хийчихсэн байх эрсдэлтэй байдаг. Энэ утгаараа миний харснаар Монголын зарим салбарт хөгжил эрсдэл дагуулаад эхэлчихсэн байна. Үүний нэг илрэл нь удааширсаар буй өсөлт.

-Евро бүсийн өрийн хямрал ямар түвшинд байна вэ?

-Грек улсын хувьд байдал бусад оронтой харьцуулахад таагүй байна. Тус улсын ДНБ-тэй харьцах өрийн хэмжээ, түүнээс гарах арга зам эрэлхийлэх тал дээр асуудалтай хэвээр байгаа. Засгийн газрынх нь хувьд асуудлыг

хэлэлцээрийн зарчмаар шийднэ гэдгээ хэлсэн. Грек тун эрсдэлтэй нөхцөл байдалтай тулгараад буй. Дампуурлаа зарлахгүй байх үүднээс зээлдэгчидтэйгээ сайтар ойлголцох хэрэгтэй байгаа ч цаг давчуу байна. Хэдийгээр тус улс евро бүсээс гарахгүй байхыг хичээж байгаа ч өнгөрсөн хугацаанд ахиц гарсангүй. Харин бусад оронд байдал арай гэгээлэг болж байна. Гэхдээ өрийн хэмжээ дорвитой буураагүй, инфляци дифляци болох магадлал өндөр байгаа үед өрийн эргэн төлөлт бүр ч ярвигтай болж байна. Одоогийн баримталж буй хүүгийн хэмжээгээр бол өрийг тогтоон барихад хүнд болно. Иймд өрийн дарамт үүсэх эрсдэл нэмэгдэж байгаа юм. Ингэснээр өсөлт, хөрөнгө оруулалт хязгаарлагдмал болж байна.

-Аргентинийн өрийн асуудлыг та хэрхэн харж байна?

-Аргентин улсын хувьд байдал тэс өөр. Тус улс хэд хэдэн удаа дампуурлаа зарлаж байсан түүхтэй. Ингэхдээ мөнгөн тэмдэгтийн бодлогоо удаа дараа өөрчилж байлаа. Аргентинийг цуврал дампуурагч гэж нэрлэх нь ч бий. Сүүлийн арван жилийн турш зээлдэгч

нарагтай үүхүүхийг дайнд сэрлэвэрлэхэд бийн байна. Юунаас үзвэл гэвч эерэвч доройндаруулах үүрэгсдэд элгийгүл тоож ирсэнтэй холбоотой.

-Дээрх хоёр орныг дэлхийн эдийн засгийн “нүдэнд орсон шороо” нь гэх болсон. Монгол Улсыг ч мөн дээрх орнуудтай харьцуулах болж. Та үүнтэй санал нэгдэх үү?

-Монгол Улсын хувьд өрийн хэмжээгээ бууруулж чадахгүй байгаа нь сэтгэл зовних нэг үндэслэл яах аргагүй мөн. Гэвч өрийн хэмжээг Грек тэргүүтэй орнуудтай харьцуулах юм бол тийм ч өндөр санагдахгүй байна. Гэхдээ Монгол евро бүсийн улс биш. Ийм учраас Монголын ард, Грекийн адил Европын Төвбанк зогсохгүй. Европын Төвбанк Грекийн арыг дааж байгаагүй бол өнөөдөр тэд тэр хэмжээний өрөнд дарагдахгүй байсан. Тэгэхээр, дангаараа гэж болох Монгол шиг орнууд өр дааж давашгүй хэмжээнд асар хурдан хүрэх магадлалтай. Учир нь зээлдэгчид ажиглалтын байдалд шилжсэнээр зээлийн хүү өсөх аюултай. Иймд Монгол Улс өрийн хэмжээгээ бууруулахад анхаарах шаардлагатай. Үүнтэй холбоотой хууль, дүрмүүд байна. Гэхдээ хэрэгжүүлэх хэрэгтэй.

-Өрийн хэмжээг аль болох бага хэмжээнд барих хэрэгтэй гэлээ. Тэгвэл Монгол Улсын Засгийн газар өрийн асуудалдаа хэрхэн хандах ёстой юм бол?

-Өрийг бууруулах хэдхэн арга байдаг. Хэрэв инфляци бага, өсөлт бодит бол өрөөс мултрах арай хялбар болно. Хоёрдугаарт, бүтцийн өөрчлөлт. Гэхдээ улс орнууд бүтцийн өөрчлөлт хийх хүсэлгүй байдаг нь зээлдэгчдэд энэ нь таалагддаггүйтэй холбоотой. Гуравдугаарт, евро бүсийн орнуудын хэрэгжүүлж буй төсвийн таналт. Ингэснээр төр мөнгөний бодогоо чангалж, өрийн хэмжээгээ бууруулах боломж бүрдэнэ. Олон улсын валютын сангийн сүүлийн мэдээллээс харахад Монгол Улс бодлогоо чангатгаж, алхам алхамаар өрийн хэмжээгээ бууруулахыг зөвлөсөн байсан.

-Монгол Улсын Засгийн газар олон улсын зах зээл дээр бонд гаргасан. Харамсалтай нь, босгосон мөнгөө үрэн таран хийчихлээ гэсэн шүүмжлэлд нэлээдгүй өртөж байгаа. Харин одоо өмнөх бондын өрийг дарахын тулд



ахин бонд гаргах тухай ярьж эхэлсэн нь ухаалаг алхам байж болох үү?

-Тийм ч оновчтой арга гэж хэлэхгүй. Хэрэв инфляци болон өр өссөөр байвал түүнийг санхүүжүүлэх хүндрэлтэй болно. Иймд мөнгөний хатуу бодлого барих хэрэгтэй. Ийм зүйлс байгалийн баялагт суурилсан эдийн засагтай орнуудад түгээмэл тохиолддог. Газар доорх баялагаа барьцаалах хэлбэрээр зээл аваад байдаг. Ингэх нь газар дор байгаа хөрөнгөө баялаг болохоос нь өмнө үрчихэж байгаа гэсэн үг.

Өрийг өрөөр дарна гэдэг ухаалаг алхам биш. Яг ийм замаар Грек явсан. Өр, зээл асуудал дэгдээх хэмжээнд хүрч эхэлмэгц бууруулах арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай. Урд хормойгоороо хойд хормойгоо нөхөх замаар улам их өр тавиад байж болохгүй.

Гадаад өр, валютын өр зэрэг нь ахархан хугацаанд асар өндөр болж орхидог. Тийм учраас тухайн улс ийм төрлийн хямралд өртөхгүй байх асуудалд тун няхуртай хандаж байх хэрэгтэй. Монголын санхүүгийн үзүүлэлтүүдээс анзаарахад байдал тун муу харагдаж байгаа юм. Хямрал тохиохын өмнө эдийн засгийн үзүүлэлтүүд гэрэл, гэгээтэй харагдаж болох ч тэдгээрийн цаана оршиж буй бодит байдал хүндэрсэн болохыг хожуу олж харах нь түгээмэл байдаг.

-Тоонд хууртаж байна гэсэн үг байх нь?

-Тийм. Тухайлбал, Европын хямралын өмнөхөн банкуудын мөнгөн хөрөнгийн

дүн боломжийн харагдаж байлаа. Гэвч мөнгөн хөрөнгө болоод эрсдэлийн тонн үзүүлэлт буруу болох нь батлагдсан шүү дээ. Аюул дэгдсэний дараа “ийм юм болно гэж мэдсэн юм” гэж хэлэх амархан байдаг. Харамсалтай нь, өмнө нь бүгд хэтэрхий тайван байсаар алдаж орхидог.

-Тэгвэл манай улсын хувьд бид өрийн дарамтад орохгүйн тулд юу хийх ёстой вэ?

-Тун энгийн. Хуримтлал үүсгэх хэрэгтэй. Тэгж байж төсвийн алдагдлыг бууруулж, өрөөс мултарна.

-Монгол Улс Олон улсын валютын сангийн Стэнд бай хөтөлбөрийг авах тухай цөөнгүй удаа яригдсан. Харин тус хөтөлбөрийг эдийн засгийн бие даасан байдлаа алдаж буй хэрэг гэж зарим хүн үзэж байгаа. Тэдний хэлж буй хэр үнэний ортой юм вэ?

-Тэр утгаар хүлээж авах нь бий. Тийм байх болов уу ч гэж улс орнууд эмээдэг. Яг ийм байдлаар явсаар тэдгээр орны дийлэнх нь хэтэрхий оройтож Олон улсын валютын санд ханддаг. Хэдийгээр тэд эрсдэлээс зайлсхийхийг оролддог боловч аюул хэдийнэ нүүрэлсний дараагаар тус хөтөлбөрийг авах тухай ярьдаг. Гэвч хэр их цаг алдсан байна тэр хэмжээгээр бүсээ чангалах шаардлагатай болно. Магадгүй тэр утгаараа улс орны хувьд хатуу шалгууруудтай тулах хэрэгтэй болдог байх.

-Тэгвэл Монголд тус хөтөлбөр хэрэгтэй юу?

-Хэрэв төлбөрийн тэнцэлд дарамт

үүссэн, өөрсдийн хүчээр тэрхүү асуудлаа шийдэж чадахгүй байгаа бол тусламж авахад илүүдэхгүй.

-Стэнд бай авах шаардлагатай гэж ойлгож болох нь ээ?

-Мэдээж сайтар бодох хэрэгтэй. Тухайн улсад ямар боломжууд байгааг авч үзэх нь чухал. Богино хугацаатай, өндөр хүүтэй зээл авах нь асуудлыг улам дэвэрэх нөхцөл болно. Зээл авлаа гэх ямар нэг хөтөлбөргүй бол эсвэл хөтөлбөр байлаа гээд зээл байхгүй бол бас л асуудал үүсгэнэ.

-Хуримтлал бий болгох үүднээс аль нэг салбарт хөрөнгө оруулалт хийнэ гэвэл таны бодлоор манай улс юунаас эхлэх хэрэгтэй вэ?

-Голланд өвчний нэг асуудал энэ. Орж ирж буй бүх орлогыг өсөлт өндөртэй байгаа нэг салбартаа оруулчихдаг. Тус салбарт өсөлт үүрд үргэлжлэхгүй учир уналтад орох нь цаг хугацааных. Ийм үе ирэхэд бусад салбартаа хөрөнгө оруулсан, тэдгээр нь тодорхой хэмжээнд хөл дээрээ зогссон байх нь чухал.

Дээрх нөхцөл байдалтай нүүр тулах хэд хэдэн арга байдаг. Тухайлбал, зөвхөн хөрөнгө оруулалт яриад зогсохгүй хуримтлал бас бүрдүүлэх хэрэгтэй. Ингэж байж ирээдүйдээ хөрөнгө оруулах боломжтой болно. Жишээлбэл, боловсролын салбар ирээдүйдээ чиглэсэн хөрөнгө оруулалт хийх хамгийн үр дүнтэй салбар. Энэ утгаар нь авч үзвэл Дубай үлгэр жишээ орон. Учир нь тус улсын газрын тосны нөөц дууссан. Харин тэд цаг алдалгүй бусад аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт хийж байснаар эдийн засгийн хүчирхэг статусаа алдахгүй явж ирсэн.

-Монголын Засгийн газар өрийн таазаа ДНБ-ий 58 хувиас хэтрэхгүй байхаар тогтсон. Үүн дээр таны бодол?

-Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн өнгөрсөн оны тогтвортой байдлын судалгаагаар Монгол Улсын өрийн эрсдлийг "тогтвортой, өрийн хэмжээ өсөх эрсдэл өндөр" гэсэн байсан. Энэ нь Монгол өрийн хямралд орох магадлалтай гэсэн үг. Дээрх судалгаанд тухайн улсын засаглалын, тухайлбал, улс төрийн, татварын болон хүнд суртлын зэрэг тогтвортой байдалтай хамаарах зүйлсийг харгалзан үздэг. Харин Монгол

засаглалын хувьд тийм ч тогтвортой биш байна. Тэгэхээр Монгол Улс хямралд өртөх бүсэд нэвтэрсэн гэж үзвэл өссөөр буй өрийн хэмжээгээ сайтар хянаж хэрэгтэй.

-Өнөөгийн өрийн хэмжээг авч үзвэл манай улс хяналт тогтоож чадах болов уу. Эсвэл Монгол Улс Грек, Аргентинийн араас орж мэдэхээр байна уу?

-Грек, Аргентинийн араас шууд орохгүй байх л даа. Хэдий тийм ч цаг алдах тусам байдал улам хүндрэх нь ойлгомжтой. Хасах динамик руу орсон л бол түүнийг залруулах хэцүү болно. Засгийн газрууд хэтэрхий удаан хүлээгээд байдаг. Тэд асуудлыг огоорч явсаар байдал хэтэрхий хүндэрсний дараа арга хэмжээ авч эхэлдэг. Зах зээл үймээд ирвэл итгэлээ алдана. Тийм ч учраас эрсдэлийн зэрэг тогтоох хэрэгтэй.

Монгол Улсын хувьд дампуурлаа зарлах хэмжээнд очих эсвэл тэр зүгт явах хүсэлгүй байгаа нь мэдээж. Тэгэхээр хөрөнгө оруулагчдын итгэлийг олох хууль, дүрэм бий болгох хэрэгтэй. Гэхдээ хамгийн чухал нь тэдгээр хуулиа чандлан мөрдөх. Ингэж байж хөрөнгө оруулагчдын итгэлийг алхам алхмаар олж авна. Хууль байгаад хэрэгжихгүй бол нэмэргүй. Нэр хүндийг асар их хөдөлмөрийн үр дүнд олж авдаг ч алдахаа хүрвэл тун амархан.

-“UB Impulse: Чанартай өсөлт” лекцийн үеэр таны тавьсан илтгэлд нэгэн жагсаалт байсан. Та жагсаалтын асуултуудын дийлэнхэд “Тийм” гэсэн хариулт өгч байвал танай улс хямралд өртөхөд ойрхон байна гэж ойлгох хэрэгтэй, иймд “эмчид яаралтай ханд” гэж хэлсэн шүү дээ. Монголд эмч хэрэгтэй болжээ. Тэр “эмч” нь хэн байж болох уу?

-Жишээ хэлбэл, Олон улсын валютын сан байж болно. Гэхдээ танай улсын Засгийн газар нь өөрөө байж болно шүү дээ. Хэрэв хэн нэгэн хэтэрхий их жин нэмсэн, хоолны дэглэм барих хэрэгтэй болсон бол үүнийг хэн нэгнээр биш өөрөө хийх бүрэн боломжтой. Гэвч зарим үед тусламж авах нь хялбар байж болох.

Асуудлын гол нь ирээдүгээ барьцаалж зээл олохдоо биш, нөхцөл байдалд тааруулж хэрхэн зөв хөдлөх тухай юм. Үүнийг чухалчлах хэрэгтэй.

Лекцийн үеэр надаас “Монгол Улс өрийн таазтай боллоо. Энэ хангалттай юу” гэж асуусан. Энэ хангалттай эсэх нь тухайн хууль хэр мөрдөгдөж байгаагаас л шалтгаална. Явах замаа зөв тодорхойлоод түүнээсээ гажихгүй байх нь чухал. Ингэж байж өрийн дарамтад өртөлгүй урагшлах боломж бий болно. Мэдээж энэ бүх зүйл богино хугацаанд хэрэгжих боломжгүй. Цаг хугацаа хэрэгтэй. Харин биелүүлж чадахгүй хоосон амлалт өгч болохгүй гэдгийг л санах хэрэгтэй.

-Монголын Засгийн газар хаа хүрээд аюул нүүрлэлээ, буцах хэрэгтэй гэх ёстой юм бол?

-Одоогийн замналаасаа буцах цаг хэдийнэ ирчихсэн байна. Валютын нөөц багассан, өрийн эргэн төлөлт ойртсон, мөнгөн тэмдэгтийн ханш суларч байгаа нь валютын өрөө эргэн төлөхөд хүндрэл учруулна. Тэгэхээр төсөв, мөнгөний бодлогоо чангаруулах хэрэгтэй болж байна. Үүний зэрэгцээ илүүдэл зардлаа танах шаардлагатай. Түүнчлэн үүсээд буй нөхцөл байдалд хэнээс, хаанаас тусламж авах боломжтой тухайгаа бодох хэрэгтэй.


-Грек евро бүсийн нэг хэсэг биш гэж бодъё. Ийм өнцөгөөс авч үзвэл Монгол дараагийн Грек үү?

-Грект бүсийн нэг орон гэдэг утгаараа олон давуу тал байсан. Тэр хэмжээгээрээ ч өрийн ийм өндөр үзүүлэлттэй болсон. Тус улс Европын холбооны орон байгаагүй байсан бол тэр их хэмжээний өр хуримтлуулахгүй байсан шүү дээ. Монголын тухайд гэвэл, Грек шиг өрийн хямралд өртсөн нөхцлүүдтэй нүүр тулж байгаа нь үнэн. Жишээлбэл, санхүүгийн салбарын сул хөгжил, ашигт малтмалд суурилсан эдийн засагтай гэх мэт. Үүн дээр нэмээд мөнгөн валютын хямралд өртөх эрсдэлтэй.

Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч Грекийн адил өртөмтгий байна. Хямрал дангаараа ирдэггүй. Нэг нь нөгөөгөө бий болгож байдаг. Яг л нэг тийшээ харж байхад нөгөө талаас цохих мэт. Банкны салбар хамгийн хүнд байна гээд бодож байхад валютын эсвэл өрийн хямрал угтаж байх жишээтэй.

Иймд Грек шиг болохгүйн тулд тэдний алдаанаас харж, суралцах хэрэгтэй. ■

Өрийн хямрал ганцаараа ирдэггүй



Хямрал хэр ойр байна вэ?

- Сүүлийн жилүүдэд өсөлт хэт өндөр байсан
- Хувийн хэвшилд олгосон зээлийн хэмжээ өссөн
- Барилгын салбарын өсөлт эрс нэмэгдсэн
- Урсгал тооцооны алдагдал ихэссэн
- Засгийн газрын өр тогтворгүй болсон
- Гадаад валютын нөөц буурсан
- Төсвийн алдагдал нэмэгдсэн
- Гадаад валютын өрийн эргэн төлөлтөд хүндрэл үүссэн

Тийм	Үгүй
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Эх сурвалж: UB Impulse: Чанартай өсөлт цуврал лекц, "Улсын өрийн зохицуулалт: Европын холбооны туршлага" лекц, илтгэгч Биатрис Ведер Ди Мауро

ЗОЧИН

Д.Цэрэндорж: Улс төрийн товчоо нэг л өдөр нураад унасан шүү

Д. Бэхээ

Монголын менежментийн холбооны тэргүүн, профессор Д. Цэрэндоржтой ярилцлаа.

-Та өнөөдрийн хямралыг засаглалын институцтэй холбож үздэг Эдийн бус засаглалын хямрал болж байна гэж. Засаглалын хямралын талаар ярина уу?

-Хямарлын тухай ярихад нэлээд гүн гүнзгий үе рүүгээ тулж ирж байна. Харин улстөрчид хүндрэл гэж нэрлээд байх шиг. Ер нь хямрана гэдэг чинь эдийн засаг өсөлтгүй болно гэсэн үг. Хямрал гэнэт нэг өдөр гараад ирдэггүй, дохио өгч явсаар өнөөдрийн байдалд ирж байгаа юм. Биднийг үсрэнгүй хөгжиж байна гэж ярих үеэс хямралын суурь тавигдсан. Эдийн засаг 15-16 хувиар өсөхөд Оюутолгой нөлөөлсөн. Гэтэл Оюутолгой хаазаа хасаж, Тавантолгойн нүүрсний асуудал сайнгүй байгаагаас болоод л эдийн засгийн нөхцөл хүндэрсэн. Түүнээс өөр хүндэрсэн зүйлгүй. Гадны хөрөнгө оруулалттай нэг салбарт өндөр ач холбогдол өгч найдлага тавьж байсан нь хийрхэл болсон. Хийрхлийн гайгаар манай эдийн засаг архи их уугаад шартсан хүн шиг овилгогүй байдалтай байна. Бодьтой шалтгаан бол энэ. Үүний цаана өөр маш том шалтгаан бий.

Миний хувьд эдийн засаг бус засаглал хямарсан байна. Эдийг засаглах тогтолцоо хямарчихаж гэж үзэж байгаа. Эдийг засаглах ухаан бол улс орны засаглалтай холбоотой. Засаглалын тогтолцоо нь Үндсэн хуулиараа УИХ нь хэмжээлшгүй

эрхтэй төрийн дээд байгууллага гээд өргөмжилчихсэн. Хууль тогтоох засаглалын нэг л хэлбэрийг ийн өргөмжилж, Засгийн газрыг нэг хавсарга байгууллага болж, шүүх засаглал нь улс төрийн хараат байдалд орчихсон. Ийм засаглал нь олон хүнийг улс төрийн намуудын хуйвалдааны талбар болгосон. Засаглах үйл ажиллагаа нь УИХ-аас үүсч байна. Хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага тул Их хурлын гишүүн хүн эрх мэдлийг гартаа аваад юу ч хийж болно гэсэн эрх мэдлийн хүрээнд загнаж байна. Өөрсдөдөө тохирсон хууль гаргаж байна. Тэдний гаргасан хуульд хяналт тавих механизм байхгүй. Үндсэн цэц нь улс төрөөс хараат байдалтай. Энэ бүхнээс л олон буруу зүйл хамаарч байна.

Эрх мэдлийг хэтрүүлэх нь эргээд алдаагаа засах, алдаандаа хяналт тавих боломж маш бага болдог. Нэгэнтээ эрх мэдэлд очоод суучихсан хүн эрх мэдлийг хэзээ ч сайн дураараа өгөхгүй. Үндсэн хуульд байгаа зүйл заалтууд амьдрал дээр хэрэгжихдээ тааруу. Олон улс яагаад хоёр парламенттай байдаг вэ гэхээр нэг танхимд нь хэлэлцээд, дараагийнхаар нь дахин хэлэлцээд шүүн тунгааж шийдвэрлэдэг. Мэргэжлийн танхимаар асуудлыг боловсруулаад хэлэлцээд гаргаад ирэнгүүт жинхэнэ ард иргэдийн төлөөлөл болсон танхим нь тухайн асуудалд маш анхааралтай хандаж, шийдвэр гаргадаг.

-Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаар багагүй яригдаж байна. Энэ

талаар та ямар байр суурьтай байна вэ?

-Үндсэн хуульд оруулах гол өөрчлөлт бол энэ засаглалыг сайжруулахад чиглэх ёстой. Төрийн эрх барих дээд байгууллага нь гурван салбартай. Ганцхан парламент биш юм аа. УИХ, Засгийн газар, шүүх прокурор. Гэтэл парламентаа дээш нь залахаар хэмжээлшгүй эрхтэй хэдэн хүнтэй болоод хувирчихаж байгаа юм. Энэ гурван байгууллага нэгдэж байж төрийн эрх барих болно. Тэгэхээр парламентийг хууль тогтоох л түвшинд нь харьцдаг, дотроо хоёр танхимтай, нэг нь хууль тогтоодог байнгын байх, нөгөөх нь хуулийг баталгаажуулдаг, иргэдээс сонгогдсон төлөөлөгчдийн танхимтай мөн хяналтын системтэй байхаар тусгаж өөрчилбөл парламент жинхэнэ утгаараа ажилладаг болно. Гэхдээ одоогийн УИХ энэ санааг дэмжихгүй л дээ. Тэд эрх мэдлээ хуваахыг хүсэхгүй. Үүнээс гарах хамгийн зөв арга зам бол ард түмний хүчтэй эсэргүүцэл. Ард түмэн чимээгүй харж байгаад нэг л өдөр үерийн ус шиг босдог юм шүү гэдгийг л харуулах ёстой. Ард иргэдийг турхирч байна гэж бодохгүй байна. Дэлхийн олон улсын туршлага харуулж байна шүү дээ.

-Гаднын улсуудад Засгийн газрын бодлого, арга хэмжээг эсэргүүцэн бослого хөдөлгөөн их болдог. Харин манайхан нам жим, дуугүй л байдаг. Гэхдээ өнөөдөр иргэд ярьж, хэлж, хямралыг мэдэрч ойлгож ирж байх шиг байна?



-Иргэдийн хувьд яг өөр дээр нь тулсан биш болохоор за яахав надад хамаагүй асуудал гээд хаяад байдаг. Харин эдийн засаг улам хямарч, хүндэрч, өөрсдийнх нь авдаг орлого багасаад, гар дээрх мөнгө нь байхгүй болоод ирэхээр хүмүүс өөрсдөдөө тооцоо хийх болдог. Энэ хэний буруу вэ, эдийн засаг гэдэг хий хоосон зүйлийн буруу юмуу, эсвэл эдийг засагладаг, удирддаг хүмүүсийн буруу юмуу гэдгийг аяндаа яриад эхэлнэ. Иргэд, мэдээллийн хэрэгсэл, социал ертөнцөөр яриад ч эхэлсэн шүү дээ. 90-ээд оны хөдөлгөөн олон жилийн турш чимээгүй байж байгаад нэг л өдөр тэсэрч гарч ирсэн. Үүнтэй адилхан улстөрчид байдлыг эртхэн зөв аргаар ухаарч, засч авахгүй бол ийм байдалд хүрэхгүй гэсэн баталгаа байхгүй.

-Эдийн засаг улам л муудлаа. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид 2016 оныг хүлээсэн байдалтай. Мөн заавал 2016 оны зургадугаар сарыг хүргэхгүйгээр наана нь парламентийг тарааж, асуудлыг хурдан шийдэж, болдоггүй юм уу гэх яриа, иргэдийн дунд гарч эхэлсэн байна. Таны хэлдгээр УИХ-ын гишүүд өөрсдөө тарья гэхгүй л дээ?

-Хуучны номонд хэлснээр эксптрацива гэдэг нэг үг байсан юм. Тэр нь хөрөнгийг дээрэмдэж авсан хүмүүсийн хөрөнгийг дээрэмдэж авах гэсэн утгатай үг. Ийм байдлаар алдсан эрх мэдлийг эргүүлэн олж авах тэмцлийг ард түмэн аяндаа хийнэ. Эдийн засаг хүндрээд, ард түмний дийлэнхийнх нь амьдрал сайжрахгүй болоод ирэхээр ард түмэн алдагдсан эрх мэдлээ эргэн авахын төлөө явж, шаардаж, тэмцдэг. Эрх мэдлийг шударга байдлаар хуваарилахыг шаардах болно. Ард түмний аргаа барсан энэ тэмцэл шаардлага өнөө маргааш уу гэдгийг ард иргэд мэднэ.

Бидний нэг буруу ойлголт бол эдийн засгаа уул уурхайгаар төсөөлчихсэн. Уул уурхайгаа түшиглэн алтаа гаргаж аваад баян болно гэсэн сэтгэлгээ. Монголчуудын хөгжлийн түүх нь ерөөсөө л мал аж ахуй. Малчдын ачаар мал сүрэг чамгүй өслөө. 50 саяд хүрсэн. 300 гаруй мянган тонн үр тариа хураагаад авчихаж байна. Бэлэн өсөж, хөгжиж, үржиж байгаа баялгаа тоохгүй, хямдхан аргаар хөгжих бодолтой. Бид малынхаа сэвснээс

бусдыг ашиглаж ирсэн ард түмэн. Технологийг нь л оруулаад ирвэл арьс шир, мах сүүг нь боловсруулаад гаргах асар их хэмжээний экспортын нөөцтэй. Харамсалтай нь, энэ салбарт дорвитой хийж байгаа хөрөнгө оруулалт, засгийн бодлого алга. Яг л морин дээрээ буруу хараад суучихсан хүнтэй ижил. Морь нь урагшаа явах гээд байдаг, хүн нь хойшоо явж байгаа иймэрхүү л засаглалтай байна.

-Таны бодлоор засаглалын хямрал хэр удаан үргэлжлэх вэ?

-Энэ хямрал нэлээд удаашрах байх. Засаглалын хямралын нүүр царайг эл болтол гүнзгийрч байж намжих болов уу. Засаг төрийн эрх мэдлийг барьж буй 76 гишүүн өөрсдийгөө мундаг гэж бодож болохгүй. Цагаа тулахаар энэ бүхэн тийм биш гэдгийг ойлгоно. Бидний хэрэгжүүлж байгаа систем бол Монголын ард түмнийг хохироож буй юм байна гэдгийг аяндаа цаг хугацаа харуулна. Хана хэрэм шиг байсан Улс төрийн товчоо нэг л өдөр нураад уначихсан шүү дээ. 76 гишүүн ингэж дураараа аашилж болохгүй. Өөрсдөө мэдэж хууль гаргадаг, өөрсдөө мэдэж улс орны хөгжлийг буруу замруу оруулдаг энэ байдал нэг л өдөр буруу байсан гэдгийг олон түмэн харуулах өдөр ирнэ.

2017 оноос зээлийнхээ үндсэн өрийг зээлтэйгээ хамт төлж эхэлнэ. Эдийн засаг ийм байвал юугаар төлөх юм. Хятадууд өгсөн зээлийнхээ оронд Тажикстанаас газрын нэг хөндийг нь авчихлаа. Өргөн уудам газар нутагтай монголчууд ийм байдлаар өр зээлээ төлөх үү. Тэгэхээр ийм байдалд хүрэхгүйн тулд эртхэн тодорхой арга хэмжээ авч, Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах хэрэгтэй. Их хурлаа хоёр шатлалтай болгож, аливаа бодлого шийдвэрээ ард түмний оролцоотой, хяналттай гаргадаг байх хэрэгтэй. 76 гишүүнийг гадна, дотныхонтой хуйвалдан ажилладаггүй, шударга тогтолцоог байгуулмаар байна.

-Богино хугацаанд ямар асуудал шийдвэл эдийн засгаа аврах боломжтой вэ?

-Цаг алдахгүй хийх ажлууд байна. Энэ бүхнийг дахиад л удирдлагын түвшнээс эхэлнэ. Монгол Улс 17 яамтай. Яам тус бүр том том байшинд байрладаг. Яамдууд, төрийн захиргаа

томорч, ажиллагсдын тоо өссөөр, цалин хөлс нь нэмэгдээд л байгаа. Гэтэл нийслэлийн дунд сургуулийн сурагчид гурван ээлжээр сурч, цэцэрлэгт нь хүүхдүүд багтахгүй байдалтай. Харин том дарга нар том том байшинд сууж, том том хар тэрэг унаж байна. Энэ байдлыг л өөрчлөх ёстой, ардчилсан нийгэм л юм бол. Ядаж тэр том албан байруудаа сургууль, цэцэрлэг болгохгүй юм гэхэд хувийн хэвшлийнхэнд түрээсэлж мөнгө олох хэрэгтэй. Тэрбайтугай эмнэлгийн зориулалтаар барьсан байшинг түшээдийн ордон болгох гэж байгаа биз дээ. Хууль зүйн өмнөх сайдынх нь хийж байсан бүх тушаал шийдвэр нь өнөөдөр хүчингүй болж байна. Нэгхэн засаг дотор ийм зүйл болж байна. Нэг засгийн хийж байсан ажлаа дараачийн засагт үргэлжлүүлэн хийдэг байх хэрэгтэй. Өмнө ажиллаж байсан хүний хөлс хөдөлмөр, цаг хугацаа бүх зүйл үгүй болох юм байна шүү дээ.

-Сингапурын эцэг гэгддэг Ли Куан Яаогийн "Би өөрийгөө золиосолж эх орноо хөгжүүлсэн" гэдэг алдартай үг бий. Харин манайх эсрэгээрээ эх орноо золиосолж өөрсдөө баяжиж байна гэж твиттер ертөнцөд жиргэж байна?

-Хамгийн гол нь төр түмний төлөө явна гэдэг чинь өөрийгөө золиослох гэсэн үг. Аливаа улсын удирдагчид улс орноо хөгжүүлэхээр явахдаа өөрийнхөө төлөө явсан тохиолдол байдаггүй. Махатма Ганди байна. Дээд зэргийн боловсролтой, сайхан амьдралтай, боломжтой хүн. Гэхдээ нүцгэн шахуу Энэтхэг улсын тусгаар тогтнолын төлөө явсаар зорилгодоо хүрсэн. Үүнтэй адилхан Сингапур орон ямар байдлаас босч ирэв. Харамсалтай нь Монголын эрх мэдэлтнүүд өөрсдөө л баяжиж байвал эх орон нь тэдэнд хамаа байхгүй байна. Монголын говь цөл болох нь тэдний хувьд юу ч биш. Ардчилал нэрийн дор хананы цаана юу болж байгааг бид мэдэхгүй. УИХ-ын бүх зүйл нь харуул хамгаалалтад гишүүд нь хулгай хийгээд худлаа ярьж байхад тоож буй зүйл алга. Үйлдэл дээрээ л баригдаагүй бол хууль үйлчлэхээ байсан байна.

-Үүнтэй холбоотой асуухад намуудын төлөвшлийг та хэрхэн харж байна вэ?

-Нам гэсэн ойлголт байхгүй болчихсон. Харин сонирхлын бүлгүүд

нэгдчихсэн ийм л төлөвшилтэй байна. Монголын намууд ард түмний төлөө гэсэн халхавч үг хэрэглэж илүү их хөрөнгө мөнгөний төлөө л яваад байх шиг байна. Хятадын коммунист намыг бид мэднэ.Тэд нам дотроосоо гарсан авлигачдад хэрхэн сум тулгаж байна вэ. Ямар нэртэй хэдэн нам нь хамаагүй. Хамгийн гол нь хэний,юуны төлөө байна вэ гэдэг л чухал. Тийм учраас ард түмнийхээ төлөө цохилох зүрхтэй,тархи толгой нь сэргэлэн хүмүүс л нам байгуулах хэрэгтэй байна. Нам нь гуравхан үгнээс хамаардаг гэдэг. Оюун ухаан, нэр төр, эрдэм мэдлэг. Энэ бүхэнд тулгуурлаж нэр төрөө хамгаалах оюун ухаанаа зарцуулж ард түмнийхээ төлөө ажиллах ёстой.

-Та бид хоёр 10-аад жилийн өмнө авлига, хээл хахууль, хүнд суртлын талаар ярилцаж билээ. Монгол Улсад өнөөдөр авлига ямар байна,багассан уу, эсвэл ихэссэн болов уу?

-Улс төр,эрх мэдэл,албан тушаалын үнэлэмж мөнгөөр хэмжигдэж эхэлсэн. Мөнгөөр үнэлэгдсэн албан тушаалд очсон хүн зарцуулсан мөнгөө эргүүлж олж авахын тулд авлига авна. Авлигын энэ тогтолцоо өнөөдөр засраагүй,улам нарийн байдалд шилжсэн. Авлигатай тэмцэх ажил дээрээсээ эхэлдэг. Түүнээс дунд түвшний жараахайнуудтай ноцолдоод барахгүй. Гэтэл УИХ-ын гишүүний бүрэн эрхийг халдашгүй гээд заачихсан байдаг. Дээрээсээ бугшчихсан зүйлийг дээрээс нь цэгцлэх хэрэгтэй. Булгийн эх нь булингартай бол тэр чигтээ булингартай гэж үг байдаг. Авлига бол хүнийг хүн биш болгодог зүйл. Тэгэхээр манай улс дээд түвшнээсээ эхэлж авлигатай тэмцэхгүй бол энэ ажил урагш явахгүй л гэж хэлмээр байна.

-Төрийн хар хүн гэж?

-Төрийн төлөө үнэхээр төрсөн юм шиг зүтгэдэг хүн байх ёстой. Манайхан УИХ-д хоёр, гурав дараалаад сонгогдчихоороо дархан болоод явчих юм. Олон дахиад сонгогдвол бурхан болох юм байлгүй. Засаглалын тогтолцоог өөрчилж ард түмний хяналтыг бий болгох хэрэгтэй. УИХ-ын гишүүд ард түмний дунд байх ёстой. Ардчиллын алдагдсан эрхийг буцаан авах хэрэгтэй. 90 оноос дутахааргүй хувьсгал хийж байж л алдагдсан бүхнийгээ буцааж авах болно. Түүнээс

биш зүгээр л бүх зүйлийг сайн тал руу нь эргүүлчих юм биш. Төрийн хар хүн бол нуруутай,буурь суурьтай хандаж чаддаг,буруугаа хүлээж чаддаг, гүдэсхэн,ухаантай,тууштай хүнийг хэлнэ. Өөрийгөө золиослох чадвартай байх ёстой.Түүнээс Америкт их сургууль төгссөнөөрөө,хоёр гурван хэлтэйгээрээ болдоггүй юм.

-Таны бодлоор улсынхаа төлөө харамгүй сэтгэл гаргаж байгаа улстөрч байна уу, манайд?

-76 гишүүнтэй холбож ярьж л даа. Сайд нарын хувьд гурван сарын ч сайд байна. Намтар түүхэндээ хэрэгтэй гэсэн байдлаар сайд нэр зүүгээд өнгөрөх асуудал их байна. Анхнаасаа сайд болохдоо ийм тодорхой гурван асуудал шийднэ гэж хэзээ ч хэлдэггүй. Сайжруулна, анхаарч ажиллана гэсэн зүйл л ярьж гарч ирдэг. Түүнээс биш хөдөө аж ахуйн сайд боллоо гэхэд газар тариаланг усжуулах ажил хийнэ гэх ч юм уу. Ийм л тодорхой зүйл ярих хэрэгтэй байна. Их хурлын гишүүдийн хувьд аваад үзэхэд шударга зүйл ярьж байгаа хүн бий л дээ. Гэхдээ тэгж хэлснээр ард түмний баатар болно гэхээс биш миний ярьж байгаа зүйл хэзээ ч биелэхгүй гэдгийг тэр гишүүн мэддэг. Нөгөө хэд нь ч мэддэг. Ийм л улстөрчид манайд давамгай байна.

-Бизнесийн байгууллагуудын өнөөгийн менежментийг та юу гэж харж байна вэ?

-Манай бизнесийн байгууллагуудад хоёр төрлийн менежмент байна. Нэг хэсэг нь орчин үеийн компанийн менежментийг хэрэгжүүлээд үнэт зүйлтэй,соёлтой болсон газрууд байна. Хаалгаар нь ороод харахад мэдэгддэг. Тухайлбал,"Голомт" банк теллерээсээ авахуулаад харилцаанаас нь мэдэгддэг. Харин MCS гэх мэт бусдаасаа арай өөр мэдлэг чадвартай нь бас байна. Нөгөө хэсэг нь хуучнаараа болгох гэж хэдэн хүнтэй бор зүрхээрээ зүтгэж байгаа нь байна. Эдгээр нь ном уншсан гэхээсээ илүүтэй бор зүрхээрээ яваа хүмүүс.

Би Азийн менежментийн холбооны шугамаар Азийн олон оронд зохион байгуулагдсан хурлуудад суусан хүн. Тус орнуудын том,бага ямар ч компани дээр очсон менежментийн талаар тодорхой мэдлэгтэй байдаг. Бизнес бол хэдэн төгрөг олохдоо гол биш юм.

Өөрсдийгөө байнга хөгжүүлж байх хэрэгтэй. Бизнес эрхлэгчдэд зориулсан эрчимтэй сургалтыг олноор зохион байгуулах хэрэгтэй. Дараа нь бизнесмэн хүн өөрийгөө өдөр тутам цэнэглэж, бизнес улстөрийн хоорондын асуудлыг мэддэг байх ёстой. Манайд улс төрийг бизнес гэж ойлгоод байна. Угтаа хоёр өөр зүйл. Улс төр нь нийгмийн, бизнес нь нийгмийн баялаг бүтээх асуудал. Гэтэл монголчууд бизнес нь тааруу байгаа тохиолдолд улс төрд л орохгүй бол болохгүй нь гэж ойлгодог.

-Итгэлцлийг сэргээх талаар яриад л байгаа. Ард түмэн,хөрөнгө оруулагчдын итгэл сэргэх үү?

-Итгэлцлийг үгээр биш үйлдлээр харуулах хэрэгтэй. Хүндрэл тодорхой хугацааны дараа үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрэх нь байна шүү дээ. Юуны түрүүнд хөдөө аж ахуй, үйлчилгээний салбараа дэмжих ёстой. Эрдэмтдийнхээ үгийг сонсох асуудал олон улсад их чухалд тооцогддог. Зөвлөх бол зөвлөхийн тулд судалсан, уншсан,мэдсэн байх ёстой. Сайдуудын зөвлөхүүд гадаадад их дээд сургуулийн нэртэй профессор,чадвартай судлаачид байдаг. Манайд бол өөр талаар зөвлөж байдаг юм биш үү. Сайдын зөвлөх сайдаасаа илүү салбараа мэддэг байх шаардлагатай. Мөн судалгааны багтай байх хэрэгтэй. Ер нь бидний энэ яриад байгаа зүйлс манай нийгэм тун балчир,ардчилсан үзлээсээ ихэд хазайсныг илтгэж байгаа юм.

Хамгийн сүүлд хэлэхэд эдийн засгийг материаллаг зүйл гэж ойлгоод байна. Эдийн засаг нь хүний толгой дахь оюун санааны зүйл шүү дээ. Өнөөдөр сэтгэл зүйн эдийн засаг гэдэг зүйл бий болсон. Эдийн засаг хямарлаа,эдийн засаг сайнгүй байна гэдэг сэтгэлгээг ард иргэдэд суулгаад байх тусам эдийн засаг улам л хямарна. Сэтгэл зүй, оюуны хүчин зүйл нь эдийн засагт маш чухал. Эдийн засаг муудах нь гэхээсээ илүүтэй өөр бодол агуулж, эдийн засгаа яаж өөд нь татах талаар зөв ойлголт өгөх хэрэгтэй. Хамгийн гол нь итгэл үнэмшил бий болгож,бодитоор үйл хэрэг болгох. Яг тодорхой үйлдлээр үзүүлж, харуулж,төр засаг юм хийх нь гэсэн итгэл төрүүлэхэд ард түмний итгэл сэргэнэ. ■



СЭДЭРСЭН ХЯМРАЛ

Хоолтой хонох хяслан

А.Бүрэнжаргал

Эдийн засаг гэх үг хямрал гэдэг холбоостой багагүй хугацаа өнгөрлөө. Хямрал биш хүндрэл хэмээн аргацаах гэж оролдсон ч бодит байдал эсрэг утгыг илэрхийлэх болжээ. Дундаж болон түүнээс доош амьжиргааны түвшинд аж төрж буй зарим иргэний худалдан авалт зогсож, бэлэн мөнгөний эргэлт буурч байгаа талаар хүнсний захын худалдаачид ярьж байна. Дэм дэмэндээ дээс эрчиндээ гэдэгчлэн худалдаа наймаа нэг, нэгнээсээ салшгүй хамааралтай. Өсөх бус уруудах эрчээ аваад буй эдийн засаг ард түмний амьдралд хэрхэн нөлөөлж байгааг нэг өнцгөөс нь сурвалжлахыг зорьлоо.

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өдөр ирэх тусам өсөж, хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад 30-40 хувиар нэмэгдсэн талаар “Бөмбөгөр” худалдааны төвийн

худалдагч хэлэв. Ийн үнэ өссөн хэдий ч худалдан авагчдын цалин нэмэгдээгүй. Харин ч эсрэгээрээ ажилгүй болох нь болж, цалингийн таналтаар хөдөлмөрийн хөлсөө хасуулаад буй. “Бөмбөгөр” худалдааны төвийн хүнсний тасгийг зорилоо.

Өргөн хэрэглээний бараа худалдах тасгийн нэгэн худалдаачны хэлж буйгаар “Ганц жилийн хугацаанд худалдан авалт 50 хувь буурчихаад байна. Манай лангуу импортын бүтээгдэхүүн худалдаалдаг учир гадаад валютын өсөлтөөс шалтгаалж худалдаа улам дордож байна. Ойрын саруудад ард түмэн иймэрхүү зүйл худалдан авах нь байтугай мах, гурил, талхаа аргалж хоолтой хонохоо л бодож байх шиг байна” гэсэн юм. Мөн тэрбээр “Үйлчлүүлэгчдийн тоо эрс буурсан. Хүнсний салбар ийм байхад бусад

бараа бүтээгдэхүүн, хувцасны лангуу бүр ч орлогогүй байх шиг байна. Бид яахав хүний өдөр тутмын хэрэглээ болохоор арай ч хоосонгүй суух юм. Түүнээс хоёр давхарын хувцас барааны худалдагчид хэдэн өдөр дарааллан ямар ч орлогогүй суух энүүхэнд болоод байна” хэмээн ярьсан.

Ажил хийсэн ч ам тосдохгүй нь

Өнгөрсөн дөрөвдүгээр сарын байдлаар хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 6630 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь 7945 төгрөгийн үнэтэй байсан бол тавдугаар сарын долооны өдөр Бөмбөгөр худалдааны төвд хонины ястай мах 7200, үхрийн ястай мах 8800 төгрөгийн үнэтэй болжээ. Махны үнэ л гэхэд сар гаруйхны хугацаанд 600-

950 төгрөгөөр өсчээ. Энэхүү үнийн өсөлт өдрийн хоолоо аргацааж байгаа ард түмэнд хэрхэн тусаж байгааг худалдан авагч Н.Эрдэнэчимэг хэлэхдээ “Ажил хийгээд ч нэмэр алга. Цалин цагтаа буухгүй, бэлэн мөнгөний эргэлт хаа хаанаа зогчихсон байна. Арга ядахдаа цалин буухаар авна гэж бодоод монетан гинжээ ломбарданд тавьчихаад хоногийн хоолоо залгуулах санаатай явж байна. Хоолтой хонох ийм хяслантай болж дээ. Өмнө нь асуудал тулгарсан ч хоол хүнсэн дээрээ гацаж байгаагүй юм даа” хэмээсэн юм. Мөн тэрбээр хэлэхдээ “Өнөөдөр ингэж аргацааж байгаа ч маргааш ломбарданд тавьсан зүйлээ яаж авах вэ гэж бодогдоод нөхцөл байдал хэцүүхэн байна” хэмээн учирлалаа.

Байдал ийн сайнгүй үед харин барьцаалан зээлдүүлэх төв буюу бидний мэдэхээр ломбардны үйл ажиллагаа идэвхждэг аж. Үйлчилгээний барилга бүрийн буланд үйл ажиллагаа явуулах ломбардуудад алт, монет, үнэт эдлэл, мөнгөн аяга, хөөрөг, эртний эд зүйл, компьютер зэрэг өртөг өндөр, овор хэмжээ бага эд зүйлс авч зээл олгох хандлага түлхүү байдаг аж. Харин сүүлийн үед пүүз, гар утас зэргээр “төрлөө” нэмсэн байна. Өнгөрсөн жилийн байдлаар нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 560 орчим барьцаалан зээлдүүлэх төв Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд бүртгэгдсэн байна.

Өдөр хоногийнхоо хоолыг залгуулахын тулд хамаг байдаг л үнэтэй цайтай зүйлээ барьцаалан сарын 9-14 хувийн хүүтэй мөнгөөр гол зогоох хандлага ихэсчээ. Банкны салбарын зээлийн чирэгдэлд дарлуулж байснаас богино хугацаанд хялбархан зээлэх боломжийг нь ломбардны үйлчилгээ олгодог аж. Ломбард гэж ганцхан цонхтой умгар өрөөнд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн тэртээх он жилүүд түүх болон үлдэж. Өдгөө хэд хэдэн эгнэсэн цонхонд дараалал үүсгэн үйлчлүүлэх ард түмний сонголт ямар л олигтойдоо үүнд хүрэх гэж. “Начин заан” барьцаат зээлийн үйлчилгээний төв гэхэд захын жижиг банкнаас ч олон ажилтантай болжээ. Ломбардаар үйлчлүүлэх иргэд банкнаас зээл хүсэгчдээс ч олон болж. Өмнө нь тэмдэглэлт өдрүүд эсвэл хичээл эхлэхийн өмнө үйл ажиллагаа идэвхждэг



байсан бол одоо үйлчлүүлэх хүмүүсийн тоо ихэссэн гэдгийг “Эрхэс” барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газрын эзэн хэллээ. Түүнчлэн “Ард түмэн цалингаас цалингийн хооронд хоосон хонохгүйн тулд эсвэл бэлэн мөнгөний зайлшгүй шаардлага тулгарсан үед ломбарданд ханддаг. Түүнээс хэн ч өөрийн эд зүйлсээ барьцаалах шаардлага байхгүй шүү дээ. Нөхцөл байдал улам бүр хүндэрч буйг л илтгэж байна” гэсэн юм.

Мөн дундаж амьдралтай иргэдийн ихэнх нь зээлтэй. Тиймээс банкны зээлийн үйлчилгээнд хамрагдах боломжгүйгээс шалтгаалан банк бус санхүүгийн байгууллагууд, барьцаалан зээлдүүлэх төвийг зорих болжээ. Учир нь эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан банк зээлээ хүмийх бодлого баримталснаар иргэд өндөр хүүтэй барьцаат үйлчилгээнд хандахаас өөр зам үлдсэнгүй. Банк бус санхүүгийн байгууллагуудад арилжааны банкны бичиг баримтад асуудал гарсан, чанаргүй зээлд хамрагдсан хүмүүс ихэнхдээ ханддаг талаар тус салбарын нэгэн мэргэжилтэн хэлж байлаа.

Банк бус санхүүгийн байгууллагын хувьд тухайн үл хөдлөх хөрөнгийн 40 хүртэлх хувийн үнийн дүнд хүрэхүйц зээл гаргадаг байна. Харин зээлийн нөхцөлөөсөө хамаарч 3-5 хувийн хүү тооцдог аж. Ийм төрлийн байгууллагууд иргэдийн санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан, хэрэгцээ шаардлагыг

судалсны үндсэн дээр орлогоо нотлох баримтад тулгуурлан үл хөдлөх хөрөнгө барьцаалах буюу санхүүгийн бусад нөхцөлөөр зээл олгодог аж. Энэ жишгээс үзэхэд олон салбарт хямрал нөлөөлж байгаа ч зарим нэг салбарт ашигтай ажиллах боломж бүрддэг байна.



Ард түмний хоолтой хонох хяслан дээр дурдсан байгууллагуудын үйлчилгээгээр биеллээ олж байна. Үүний цаана ломбарданд тавих эд хөрөнгө байтугай өдрийн зургаан зүсэм талхаар голоо зогоож байгаа туйлын ядуу иргэдийн талаарх сурвалжлага манай нэгэн дугаарт гарч байсан. Дээрх нөхцөл байдал юунаас улбаатайг эргэцүүлэн цаашлаад явал сайжрах талаар шийдэлд хүрч ард түмнээ ядуурлаас аварч улс орныхоо хөгжилд хувь нэмэр болох бодлого боловсруулах шаардлага үүсээд байна.

Цадиггүй эрх мэдэлтнүүдийн бодлогогүй шийдвэрт буруу өгөх алба үгүй ч энэ бүгд тэдний шийдвэрээс үүдэлтэй хямралын нэг хэсэг. ■

Өгөөжийг нь хүртээгүй өнө жилийн гэрээ



Ц.Элбэг

Ерөнхий сайд Ч.Сайханбилэг УИХ-ын чуулганаар хэлсэн үгэндээ татварыг нэмэхгүй ч хасахгүй, эрх зүйн орчноо илүү ойлгомжтой болгох ажлыг хийнэ хэмээсэн. Тэгвэл УИХ-ын нэгдсэн чуулган дээр “Нийслэл хотын албан татварын тухай” хэмээх шинэ төрлийн хуулийн төсөл орж ирсэн нь түүний хэлснээс зөрж байна хэмээн УИХ-ын зарим гишүүн үзэж байна.

Татварын бодлогын шинэчлэлийн талаар Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл өмнө нь Сангийн сайд Ж.Эрдэнэбатын олон нийтэд өгснөөс нэг их ялгаагүй байсан. Гэхдээ Ерөнхий сайдын хэлсэн үгнээс анхаарал татаж байгаа нэг зүйл нь “Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж буй гадаадын компаниас татвар авдаг болно” гэдэг өгүүлбэр. Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуульд тусгаснаар “Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон гадаадын аж ахуйн нэгж, тэдгээрийн төлөөний газар”-аас татвар авах ёстой. Тэгвэл өнгөрсөн хугацаанд хуулийн энэ заалт хэрэгжээгүй болж таарах нь. Ерөнхий сайд дээрх өгүүлбэрийн араас үргэлжлүүлэн давхар татварын асуудлыг хөндсөн нь асуултын хариулт болж байж мэдэх.

Монгол Улс өнөөдрийг хүртэл 35 улстай давхар татварын гэрээ байгуулжээ. Үүнээс дөрвийг нь 2012 онд цуцалсан. Учир нь ОУВС-гийн экспертүүд манай улсын байгуулсан гэрээнүүдийг шинжээд Нидерланд, Люксембургийн вант улс, Кувейт болон Арабын Эмират улстай байгуулсан давхар татварын гэрээг хамгийн муу, манай талд алдагдалтай гэж үзэн цуцлах зөвлөгөө өгсөн юм. Хэрэв гэрээг цуцлаагүй бол Канад улсад

бүртгэлтэй “Айванхоу Майнз” ХХК өөрийн Нидерланд улсад бүртгэлтэй охин компанираа дамжуулан Монгол Улсад татвар төлөхгүйгээр “Оюу Толгой” ХХК-аас ногдол ашиг хүртэх нөхцөл байдал үүсээд байв. Учир нь хувь нийлүүлэгчдийн нэг нь “Oyu Tolgoi Netherlands B.V.” компани юм. Түүнчлэн давхар татварын гэрээний хүрээнд Монгол Улсын шилдэг татвар төлөгч компаниудын нэг “Бороо гоулд” ХХК 2011, 2012 онд нийт 99 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлсэн байдаг. Канад улсад төвтэй алт олборлолт, хайгуулын “Сентерра Гоулд” компани Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй “Бороо Гоулд” ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулагч билээ.

Засгийн газрын тэргүүний хэлж буйгаар давхар татварын гэрээнүүдийг шинэчлэх хэрэгтэй байна хэмээсэн. Ихэнх гэрээ 1990-ээд онд байгуулагдсан нь Монгол Улс гадаад харилцаагаа сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгаа хөгжүүлэхийг чухалчилж байсан үе. Тиймээс төрийн өндөр дээд хэмжээний айлчлалын үеэр айлын талаас тавьсан давхар татварын гэрээ зурах саналуудыг хялбар хүлээн авдаг байж. Үүнд манай тал хэлцэл байгуулах туршлага муутай, үр дагаврын талаар сайтар ойлголтгүй байсан нь нөлөөлсөн гэдэг тайлбарыг албаныхан өгдөг юм.

Давхар татварын гэрээнээс үүдэн бий болсон, бидний урьдчилан төсөөлөөгүй үр дагавар бол үндэсний томоохон компаниудад татвараас зайлсхийх хууль ёсны боломж нээж өгсөн явдал. Давхар татварын гэрээгээр Монгол Улс 2010 онд 84.7 тэрбум, 2011 онд 52.1 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт

үзүүлсэн байдаг. Тэдний дотор үүрэн холбооны “Мобиком”, “Юнител”, “Скайтел”, мөн Голомт, Хадгаламж, ХААН, Худалдаа хөгжлийн банк, “Монгол телевиз”, “Сансаркабель”, “Шунхлай”, групп “Петровис”, “М Си Эс”, “Ард даатгал”, “Говь”, “Эрдэнэт үйлдвэр”, МИАТ, “Монголын цахилгаан холбоо” гээд танил нэрүүд эрийтэл үргэлжилнэ.

Өнөөдөр гэрээний алдаа дутагдлыг засч залруулах боломж бий юү гэвэл тийм. Давхар татварын гэрээний “Дуусгавар болох” гэсэн бүлэгт зааснаар гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дараагаас аль ч улс нөгөөгөөсөө зөвшөөрөл авалгүй дангаараа гэрээ цуцлах эрхтэй. Мэдээж хэрэг заавал цуцлалгүйгээр хэлэлцээрийн түвшинд асуудлыг шийдэж болно. Гэхдээ хэлэлцэгч ямар ч улс өөрт ашигтай нөхцлийг тийм ч амар өөрчлөөд байдаггүй аж.

Гэрээ цуцалсан дээрх дөрвөн улсын жишээ мөн л ийм замаар шийдэгдсэн юм. Монгол Улс хамгийн сүүлд 2005 онд Бүгд Найрамдах Сингапур улс, Бүгд Найрамдах ардчилсан Солонгос ард улс, Бүгд Найрамдах Австри улс, Нидерландын вант улстай энэ төрлийн гэрээг байгуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, өнөөдөр хүчинтэй байгаа давхар татварын ямар ч гэрээг манай тал дангаараа цуцлах боломжтой гэсэн үг. Ийм жишиг олон улсад ч бий.

Албан ёсны нэршил нь “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”. Олон улсад гэрээ, конвенц, хэлэлцээр гэх зэргээр өөр, өөр нэрлэдэг ч зарчмын хувьд ялгаагүй энэ гэрээний

ач холбогдол нь юунд оршдог вэ. Угтаа гэрээний зорилго нь татварын давхардлыг арилгах, ялгаварлан гадуурхах байдал гаргуулахгүй байхаас гадна татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх.

Гэвч татвар гэдэг ээдрээтэй сэдэв олон

улсын харилцаа хэмээх адармаатай зохицуулалтад орсноор зорилгоосоо эсрэг үйлчилдэг сул тал бий болжээ.

Гадаадын улс орон давхар татварыг онцгойлон чухалчилж энэ асуудал дээр тусгай мэргэшсэн баг ажиллуулдаг бол манайд ердөө хэдхэн хүн л хариуцдаг

гэнэ. Тиймээс цаашид гэрээ хэлцлийг ашигтайгаар өөрчилж шинэчлэхийн тулд боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах шаардлага ч бас байгаа юм. ■

АСЕМ

Чухалчлах учиртай чухал уулзалт

Г.Түшээ

Ази, Европын орнуудын улс төр, эдийн засаг, нийгэм соёлын тулгамдсан нийтлэг асуудлыг хоёр жил тутамд хэлэлцдэг “Asia-Europe Meeting” /ASEM/ буюу Ази-Европын орнуудын ирэх оны уулзалтыг манай улс даргалах үүрэг бас хариуцлага хүлээгээд буй. Энэ хүрээнд Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу АСЕМ-ийн уулзалтыг зохион байгуулах Үндэсний зөвлөл, түүний дэргэд дэд ажлын зургаан хэсэг байгуулагдан ажиллаж байгаа билээ. Эдгээр ажлын хэсгийн нэгийг ахалж буй Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн “Манай дэд ажлын хэсэг хурлын агуулга, баримт бичиг гаргана. Тэнд Монгол Улс өөрийн гэсэн байр сууриа тусгах ёстой” хэмээв. АСЕМ-ийн сурталчилгаа хариуцсан ажлын хэсгийн ахлагч А.Ганбаатар “Ажлууд товлосон хугацаандаа дуусна гэж найдаж байна” хэмээн ярьсан.

АСЕМ-ийн уулзалтын үеэр дэлхийн 51 орны төр, засгийн тэргүүд манайд цуглаж, чуулах юм. Иймд тэдний тав тухыг хангах нийт 43 зочид буудал ажиллах бөгөөд буудлын ажилтнуудад зориулсан вакумжуулсан сургалт зохион байгуулахад төрийн зүгээс дэмжлэх үзүүлэхээр болсон. Олон улсын мэргэжлийн тогооч, менежерүүд ирж явуулах тус сургалтын зардлыг төрөөс бүрэн даах юм. Түүнчлэн 43 зочид буудлын 34-ийнх нь үйлчилгээ, үзэмжийг сайжруулахад нийт 197 тэрбум 384 сая төгрөгийн санхүүжилтийг хөнгөлөлттэй зээлээр буюу 3-5 жилийн хугацаатай

жилийн ес хүртэлх хувийн хүүтэй зээл олгох ажээ. Энэ нь нэг аж ахуйн нэгжид 30 тэрбум төгрөгийн зээл олгоно гэсэн үг.

АСЕМ-ийн 11 дэх удаагийн уулзалтад зориулсан www.asem11.mn албан ёсны вэб сайтыг ашиглалтад оруулсан бөгөөд нэвтрэхэд хялбар, цөөхөн цэстэй, мэдээллээр баялаг байхуйцаар хийсэн гэж буй. Тухайлбал, Монгол Улс гэх тусгай цэсэнд Монголд ирэх зочдоод нь үйлчлэх унаа хөсөг зэргээс эхлээд үйлчилгээний газруудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг оруулахаар төлөвлөжээ. Мөн тус цахим хуудсаар дамжуулан олон нийтэд АСЕМ-ийн уулзалтын талаар мэдээлэл өгөхөөс гадна оролцогчдын бүртгэх юм байна. Энэ талаар МҮОНРТ-ийн Ерөнхий захирал Ц.Оюундарь “www.asem11.mn цахим хуудас нь Монголын төдийгүй олон орны иргэд, сэтгүүлчид болоод уулзалтад оролцогчдын “Ширээний ном” болно” хэмээн онцлов.

Уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд албан ёсны лого шалгаруулах уралдаанд нийт 22 оролцогчийн 35 бүтээл ирснээс Монголын Урчуудын эвлэлийн хорооны уран бүтээлч С.Алтантуяагийн бүтээл шалгарсан. Ийнхүү түүний зохиосон логог 2016 оны АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалт болон бусад 10 гаруй салбар хуралдааны үеэр албан ёсоор ашиглах аж. Лого нь монгол гэрийн тооно болох дэлхийн бөмбөрцгөөр “АСЕМ-

ийн уулзалтад дэлхий нийтээрээ ач холбогдол өгч, анзаарч байна” гэсэн санааг илэрхийлжээ. “Е” үсэг үүсгэж байгаа гурван зураас нь гэрийн бүслүүр буюу өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагаар үргэлжилж байдаг гэх утгатай. Мөн логоны дэвсгэр өнгийг мөнх тэнгэр, энх тайвныг бэлэгдэж хөх өнгөөр хийж, улаан өнгийг мандан бадрахыг бэлгэдэн оруулжээ. Түүнчлэн улаан, хөх өнгө нь Монгол Улсын төрийн далбааны өнгөтэй таарч байгааг зохион бүтээгч дурьдлаа.

Одоогоос долоон жилийн өмнө АСЕМ-ийн гишүүнээр элсэж байсан манай улс энэ удаад уг уулзалтыг даргалах үүрэг хүлээн бэлтгэл ажлаа ийнхүү базааж байна.

Манай улсын Ерөнхийлөгч “Энэхүү дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах эрхийг авна гэдэг бол Монгол Улсын нэр хүнд өндөр түвшинд хүрснийг харуулж байна” хэмээн удаа дараа онцолсон. Үүнийг дагаад өндөр хариуцлагатай тулгарч буй. АСЕМ нь дан ганц улс төрийн хүрээг хамардаггүй. Уг уулзалтаар иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийнхэн өөрийн цар хүрээгээ тэлж, гишүүн орнуудын адил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах суваг нээгддэг. Тиймээс зөвхөн төр, засгийнхан гэлтгүй бизнесийнхэн болоод иргэд “АСЕМ-11”-ийг чухалчлах учиртай. ■





ТАВАНТОЛГОЙ

Эргүүлэг

Б. Энхцэцэг

Ард түмний тархиар наадаж, олон талд талцуулж буй Тавантолгойн асуудал өдгөө наашаа ч үгүй, цаашаа ч үгүй ацан шалаанд орчихов. Гэхдээ хэний гарт өгч, хэдэн төгрөг авах вэ гэдэг маргаан Тавантолгойг тойглосоор сунжирч байна. Зарим нэг нь яарах хэрэгтэй гэж байхад нөгөө хэсэг нь яарах хэрэггүй гэж иргэдийн толгойг яах учраа олохгүй болтол эргүүлж буй. С.Ганбаатар гишүүн “Ард иргэдэд тодорхой мэдээлэл өгөхгүйгээр нүүрс үнс боллоо гэх мэтээр яаруулж, Тавантолгойг явуулах гэж байна” гэж үзэж байна.

Тавантолгойн нийт нөөцийн дөрвөн хувийг эзэмшдэг “Энержи Ресурс” компани Хятадын Шинхуа, Японы Сүмитомо компанитай хамтран консорциум байгуулан Засгийн газраас зарласан тендэрт ялсан. Товчхондоо, “Энержи Ресурс”-ийн хувьд Шинхуа нь төмөр замтай түнш, Сүмитото нь маркетингийн түнш. Энэхүү консорциумтай Монгол Улсын Засгийн газар Хамтын ажиллагаа, Хөрөнгө оруулалт, Төмөр зам гэсэн гурван төрлийн гэрээ байгуулах ёстой байсан ч УИХ-ын дарга З.Энхболд түгшүүр төрүүлэм мэдэгдэл хийж, УИХ-аар хэлэлцүүлэхээр болсон. Тус гэрээг

дөрвөн удаа зүсээ хувиргаж орж ирсэн нь “но”-г нь илтгэж буй нэг жишээ гэж үзэж буй хэсэг бий. “Эхнийх дээр Засгийн газар гарын үсэг зурсан бол гэмт хэрэг болох байлаа” гэж УИХ-ын даргын хуулийн бодлогын зөвлөх А.Гансүх хэлсэн.

Ингээд л гэнэт нойрноосоо сэрсэн мэт УИХ-н гишүүн бүр санал бодлоо хэлж, тоож эхэллээ, Тавантолгойг. УИХ-ын дарга З.Энхболд “Байгуулахаар төлөвлөж байгаа эдгээр гэрээ, хэлэлцээрийн төслийг харахад Монгол Улсын үндэсний эрх ашгийг хангаж чадаагүй. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын үүрэг тодорхой хугацаатай байгаа бол нөгөө талын үүрэг нь хугацаагүй, зорилтын шинж чанартай, зорилт биелэгдээгүй тохиолдолд хүлээх хариуцлага байхгүй байна” гэсэн.

Тавантолгойн ордын Хөрөнгө оруулалтын гэрээг УИХ-ын чуулганаар оруулж хэлэлцүүлэх эсэх дүгнэлтийг гаргах зорилготой ажлын хэсэг хүртэл байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг “Өнгөрсөн гурван жилийн хугацаанд Тавантолгойн асуудал УИХ-руу нэг ч удаа орж ирээгүй. Өнөөдрийн миний ажлаж байгаа ажлын хэсгийнхэн 15

хоногийн өмнө Тавантолгойн талаарх эхний материалаа авсан. 76 гишүүнээс хамгийн их мэдээлэлтэй байгаа нь би болоод байна. Бусад гишүүнд мэдэхгүй зүйл нэлээд байгаа. Тиймээс энэ гэрээ энэ чигтээ явах боломжгүй” гэж эхний дүгнэлтээ гаргасны дараа хэлсэн. Гэхдээ нэг асуулт байна. Монголын гурван сая иргэнийг төлөөлөн суугаа УИХ-н гишүүд энэ орны хувь заяатай холбоотой асуудлын талаар сайн мэдэхгүй, мэдээгүй, сонирхож үзээгүй өдий хүрсэн нь хэний буруу вэ.

Зөвлөх А.Гансүх хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл гэрээ сунгагдах боломжтой нь энэ гэрээ хязгааргүй хугацаатай ч байх боломжтойг харуулж байна гэсэн. Үүнийг хамгийн ноцтой гэрээний заалт гээд байгаа. Мөн Засгийн газар гэрээг цуцалбал, консорциумд гэрээний үлдсэн хугацаанд хийсэн хөрөнгө оруулалт дээр олох байсан ашгийн 20 хувийн өгөөжийг жил бүрээр тооцож өгнө гэсэн нөхцөл байгааг хэлсэн. Энэ тал дээр MCS группын ерөнхийлөгч Ж.Оджаргал “Хөрөнгө оруулагч дөрвөн тэрбум ам.доллар оруулаад дуустал гэнэт нэг сайд нь гарч ирээд гэрээг цуцална гэвэл бид яах вэ” гэсэн юм. Оюутолгойн гэрээг жишээлбэл, гэрээг цуцалсан тохиолдолд олох байсан



ашгийн 29 хувийг манай Засгийн газар төлнө. Ийм заалт гэрээнд тусгагдахгүй бол Монголд хэн ч хөрөнгө оруулахгүй. Учир нь иймэрхүү заалтыг хөгжиж буй манайд байтугай, хөгжингүй орнуудад ч түгээмэл хэрэглэдэг.

Үүний зэрэгцээ консорциумын Монгол талын оролцогч “Энержи Ресурс” компанийг нийтдээ нэг тэрбум 23 сая ам.долларын өртэй гэх асуудлыг хурцаар тавьж, сөхөн ярилцаж буй. Харин энэ тухайд Ж.Оджаргал “Хөрөнгө босгох үүднээс гадаадад бүртгүүлсэн “Mongolian Mining Corporation” компани олон улсад бонд хэлбэрээр гаргасан 600 сая ам.доллар тус компани дээр үлдэх өр. “ММС” өөрөө төлнө. “Энержи Ресурс”-тай хамаагүй гэсэн. Тэрбээр мөн хэлэхдээ “Бид больчихож болно. Бидэнд хохиролтой л доо. Гэхдээ улсад л илүү хохиролтой” гэж буй.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн 14.1 зүйлд татварын дөрвөн төрлийг тогтворжуулсан заалт байгаа. Үүнд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Агаарын бохирдлын хураамж, Гаалийн хураамж, Аж ахуй нэгжийн орлогын албан татвар орж буй. Нүүрсний үнийг 80 ам.доллар байлаа гэж тооцоход, дээрх дөрвөн төрлийн татвар болон бусад төрлийн татвар хэлбэрээр улсын төсөвт доод тал нь жилдээ 202 сая ам.доллар төвлөрөхөөр байгаа аж. Энержи Ресурсын хувилбараар бол улс ямар нэг эрсдэл үүрэхгүйгээр хил дээр борлуулж байгаа үнээс татвар авна. Гэхдээ гэрээ ёсоор менежментийг

консорциум бүрэн хариуцахаар байгаа. Үүнийг нөгөө талаас төрийн оролцоог хааж, хамаг эрх мэдлээ консорциум өөр дээрээ төвлөрүүлэх гэж байна гэж харж байна. С.Ганбаатар гишүүн энэ талаар “Өөрөө ухна, өөрөө зөөнө, өөрийнхөө үйлдвэрт өгөх гэж байна” гэж тайлбарлаж буй. Тэгвэл Тавантолгойн ордод хувь эзэмшлээ гэж бодоё. Оюутолгой шиг 34 хувь эзэмшлээ гэхэд тэр хэмжээгээр бид хөрөнгө оруулалт босгож, хөрөнгө оруулагч талтай зардлаа хуваах болно. Өдгөө Оюутолгой дээр үүнээс үүдэлтэй асуудлууд гарчихаад л гацаад байгаа. “Монгол улсын хуулинд байгаа бүх татвар, хамтран ажилласны төлбөр авна. Бид Оюутолгойн гэрээг яг ийм л байсан бол гэж өчнөөн жил харамсч ярьсан. Одоо тэгвэл тэр мөрөөдлийн гэрээг Тавантолгой дээр хийчихлээ” хэмээн Ард санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг хэлж байгаа

Хэн нь чадах вэ

Тавантолгойг 2010 оноос эдийн засгийн эргэлтэд оруулах ажил эхэлсэн. Эл орд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Австралийн ЖОРК стандартаар үнэлбэл 7.4 тэрбум тонн коксжих нүүрсийн нөөцтэй. Нүүрсний үнийг хамгийн багадаа 50 ам.доллар гэж тооцоолбол 250 тэрбум ам.долларын борлуулалтыг ирэх 50 жилд хийхээр байна гэж Д.Жаргалсайхан эдийн засагч саяхан нэгэн нийтлэлдээ бичсэн. Харин Л.Эрдэнэчимэг гишүүний хэлж байгаагаар одоогийн хувилбараар гэрээг батлаад явбал бүх ашгаа нийлүүлээд Тавантолгойгоос 20 хувийг авахтай үгүйтэй байгаа аж. Харин МУ-ын сайд М.Энхсайхан тэргүүтэй төслийг хариуцаж буй хүмүүсийн тооцооллоор нүүрсний үнийг 70 ам.доллараар бодоход Засгийн газар, хөрөнгө оруулагч хоёр 78:22 гэсэн харьцаагаар орлогоо хувааж байгааг саяхан олонд тайлагнасан.

Яг одоо УИХ дээр Тавантолгойн ордыг “Энержи Ресурс” тэргүүтэй консорциумд өгөхөөс илүүтэй “Эрдэнэс Тавантолгой”-гоор удирдуулбал илүү өгөөжтэй гэх хувилбар ч нэлээд газар авч байгаа. Дахиад тэндэр ч зарлах юм шиг санал явж буй. УИХ-ын гишүүн Х.Баттулга “Энержи ресурсын хувилбараар явбал 20 гэр бүл тасартлаа баяжина.

Эрдэнэс Тавантолгойн хувилбараар явбал 20 жилийн дотор Монгол хөгжинө” гэж дүгнэсэн. УИХ гишүүн Л.Эрдэнэчимэг “Өөр өөрөөр тайлбарлаад толгой эргүүлээд байгаа болохоос яг харьцуулаад харвал “Эрдэнэс Тавантолгой” уг төсөлд орж ажилласан нөхцөлд л ашигтай байгаа. Одоогийн зурагдах гэж байгаа гэрээ бол Монголыг худалдах гэж байгаа нь шууд харагдана” гэсэн юм.

Төрийн хувь эзэмшлийг амжилттай удирдаж буй компаниуд бусад улсад байдаг. Тухайлбал, Сингапурт Тимасек, Хятадад Хөрөнгө оруулалтын корпораци зэрэг төрийн өмчит, зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаг хүчирхэг компаниуд бий. Гэхдээ тэд бүгд улс төрөөс хараат бусаар үйл ажиллагаагаа зохиомжилсон байдаг. Манайх шиг улс төрийн ертөнцөөс хамааралгүй явж чаддаггүй орны хувьд “Эрдэнэс Тавантолгой” компани уг төслийг хэрэгжүүлдэг дээрээ тулбал, ахиад л улс төржүүлээд, олон ашиг сонирхол зөрчилдөхгүй гэсэн баталгаа байхгүй. Сайхан санаа гэхдээ төр өөрийнхөө гарыг өөрөө ардаа хүлж, баглаагүй цагт бүтэхгүй хувилбар. Яагаад “Шинхуа” “Эрдэнэс Тавантолгой”-той хамтрах тухай ярьж байсан атлаа Энержи Ресурсын үүдийг тогшиж орж ирсэн бэ. Учир нь Эрдэнэс Тавантолгой төр хэмээх муу менежертэй.

“УИХ, Тавантолгой дээр ямар нэг хувийн шалтгаан байхгүй. Том төслийг явуулахын тулд энэ чиглэлээр УИХ-ын даргатай уулзаж, ярилцаж байгаа. Цаашдаа асуудлыг шийднэ” хэмээн Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлсэн. Гэхдээ л Тавантолгойн асуудлыг хэзээ УИХ хэлэлцэх нь тодорхойгүй байсаар л байна. Төрийн оролцоог хэт хазаарласан гэрээ учир сайжруулаад батлая гэсэн хэсэг бүлгээс илүүтэй бүр унагая гэсэн хэсэг давамгайлж байгаа нь ажиглагдаж буй. Монголын эдийн засгийн талтай тэнцэх асар их мөнгөний тухай Та бид ярьж байна. Нүүрс үнс болдоггүй юм аа гэхэд, бид Тавантолгойн асуудлаа хурдан шийдэхгүй аваас олон улсад эзлэх байр суурь жижгэрч, Хятадыг гаталж, гурав дахь зах зээлд гарах мөрөөдөл биднээс алсарсаар байх нь дамжиггүй. Ядуу байх хэцүү. Баян байх бүүр хэцүү юм. ■

Тавантолгойг яаж хөдөлгөвөл Монголд ашигтай байх вэ?



Т.Наран /Монголын нүүрсний ассоциацийн гүйцэтгэх захирал/:

-Олон улсын зах зээл дээрх нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн өрсөлдөөн, үнийн уналт зэрэг зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд концерциумтай хамгийн сүүлд байгуулсан энэ гэрээ хамгийн үр дүнтэй хувилбар. Одоогийн өргөн бариад байгаа гэрээнд УИХ өөрчлөлт оруулах байх. Гэхдээ ямар ч өөрчлөлт хийсэн эцсийн хувилбар энэ гэрээг дээрдүүлнэ гэж бодохгүй байна. Энэ гэрээг явуулахгүй орхивол Тавантолгой ямар ч байдлаар ойрын 10 жилдээ эдийн засгийн эргэлтэд орохгүй энэ хэвээр байна. Уг гэрээ хамгийн ашигтай хувилбар. Үүнээс дээр хувилбар байхгүй.



Н.Алгаа /Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал/:

-Тавантолгойг хурдан хөдөлгөх хэрэгтэй. Нүүрсний чанарыг дээшлүүлж, өндөр боловсруулалт хийж хөдөлгөх хэрэгтэй. Нийлүүлэлт тогтмол, сайн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байж үнийн хувьд өрсөлдөх чадвартай байна. Төмөр замаа тавих, нүүрсээ баяжуулах хэрэгтэй болно. Ийм байдлаар цаг алдалгүй хөдөлгөж байх хэрэгтэй. Төрөөс зөвшөөрлийг нь гаргаж, хөрөнгө оруулалтад түшиглэж хөдөлгөх хэрэгтэй.



Б.Галбадрах /ХУД-ийн X дугаар хорооны иргэн/:

-Томоохон орд болон төслийг тухайлбал, Тавантолгойг хувийн хэвшлийн үндэсний томоохон компанид даатгах хэрэгтэй. Төр зөвхөн бодлогоо гаргах нь зүйтэй. Монголд MCS шиг 10 том компани тус тусдаа нэг нэг төсөл хариуцан хэрэгжүүлвэл улсын эдийн засаг уналтад орохгүйгээс гадна үүний цаана маш олон ажлын байр бий болно.



Б.Цэцэгмаа /Баянзүрх дүүргийн III хорооны иргэн/:

-Гэрээгээ ард түмэндээ хэрэгтэй байдлаар байгуулах хэрэгтэй. Гаднын хөрөнгө оруулагчдыг зах зээлээс хэт их шахах хэрэггүй. Хэрэв ингэвэл тэд Монголд хөрөнгө оруулахаа байна. Одоо ярьж буй "ард түмний эрх ашгийг хөндсөн, ногдол ашиг нь ард түмэнд ирэхгүй" ийм байдлаар гэрээ хийж болохгүй. Гэрээгээ сайн хийж, Тавантолгойг хөдөлгөн эдийн засгаа сайжруулах хэрэгтэй байна. Энэ хүрээнд хөндлөнгийн шинжээчид, мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах хэрэгтэй. Улстөрчид мэргэжлийн хүмүүс биш болохоор гэрээнд хөнгөн хандах байдал ажиглагдаж байна. ■

ARD ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

Хөрөнгө оруулалттай компаниуд:



Ердийн даатгал



Техник Технологийн
Дээд сургууль

Техникийн дээд
боловсрол, Коосэн



Брокер, дилер, андеррайтер,
хөрөнгө оруулалтын зөвлөх



Вэб сайт, маркетинг,
брэндинг



Санхүүгийн цогц
үйлчилгээ



Үл хөдлөх хөрөнгө



Урт хугацаат хадгаламж



Санхүүгийн программ
хангамж



Бичил санхүү

Хүчтэй. Хамтдаа.



ТҮҮХ

Бүх цаг үеийн хамгийн хүчирхэг эдийн засагтай гүрнүүд

Б.Энхмөнх

Сүүлийн үед АНУ-ын хүч суларч байгаа талаар ярих болсон. Америкчууд өөрсдийн дэлхийд эзлэх байр суурьтаа санаа зовж буй нь дамжиггүй. Учир нь хэдхэн жилийн өмнө тохиосон санхүүгийн хямралаас бүрэн ангижраагүй байгаагийн зэрэгцээ иргэдийнх нь цалин сүүлийн 20 жилд өсөөгүй, түүнчлэн томоохон өрсөлдөгч гэж болох 1.3 тэрбум хүн амтай, хязгааргүй боломж олгох томоохон зах зээл бүхий БНХАУ-ын эдийн засаг өдөр ирэх тусам тэлж байна. Харин түүхийг эргэн сөхвөл АНУ-ын эдийн засаг харьцангуй хүчирхэг байсан нь харагдана.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн хүчирхэг эдийн засагтай их гүрнүүд мөн дэлхийн эдийн засгийн нийт бүтээгдэхүүний хамгийн их хувийг үйлдвэрлэдэг орнууд ерөнхийдөө хамгийн их хүн амтай эсвэл хамгийн

том газар нутагтай байх ажээ. Мөн хүчирхэг эдийн засагтай орнуудын чухал нууц нь аж үйлдвэржилт юм. Дөнгөж 300 гаруй жилийн өмнө дэлхийн эдийн засаг хөдөө аж ахуйд тулгуурлаж гол баялгийг бүтээдэг байв.

Ингээд хамгийн хүчирхэг эдийн засгууд хэмээн түүхэнд мөнхлөгдсөн таван гүрнийг онцльё.

Ромын Эзэнт гүрэн / МЭ 100 он/

Ром жижиг улсаас дэлхийн эзэнт гүрний хэмжээнд хэдхэн зууны дотор хүрсэн. Эртний Карфагентай хийсэн Пунийн дайн тэднийг их гүрний статусаа улам бататгахад чухал нөлөө үзүүлсэн гэдэг. Уг дайны үеэр Ромын эзэнт гүрэн Газар дундын тэнгисийг эрхшээлдээ оруулснаар эдийн засгийн асар идэвхтэй гэгдэж байсан Египт зэрэг улсад худалдаагаа өргөжүүлжээ. Эдийн

засгийн өсөлтийн хамгийн чухал нэг хэсэг бол худалдаа. Тухайн үед ромчууд энэ тал дээр хэнийг ч дагуулахгүй чадвартай байсан аж. Мөн тэд санхүүгийн маш нарийн тогтолцоотой байсан төдийгүй банкны тэмдэглэл болон зээлийн олон төрлийг ашигладаг байсан аж. Түүнчлэн худалдаачид болон наймаачид холын зайг туулан үнэт метал тээвэрлэдэг байсныг судалгаагаар нотолсон байдаг.

Хятадын Сүн гүрэн /МЭ 1200 он/

Хятадад хөдөө аж ахуй Ойрхи Дорнодыг бодвол хожуу нэвтэрсэн аж. Хэдий ийм ч тэд үр өгөөжийг нь овжин ашигласнаар дэлхийн түүхэнд байгаагүй гайхамшигт соёл иргэншлийг МЭ 1200-гаад оны үед бий болгож чаджээ. Зарим түүхч, эдийн засагч дэлхийн хамгийн анхны аж үйлдвэрийн



Эртний Персийн нийслэл Персеполис: Өндөр хөгжилтэй гэгдэж байсан Персүүд хүртэл ромчуудын эдийн засгийн ноёрхлыг зогсоож чадаагүй.

хувьсгал Англид бус Хятадад үүссэн гэж ч маргалддаг. Япон болон Хятадын эрдэмтдийн хийсэн судалгаагаар тухайн үеийн Хятадын эдийн засаг хүн ам нь өсөхийн хэрээр улам өргөжиж байжээ.

Энэтхэгийн Их Могол улс /МЭ 1700 он/

Энэтхэг нь дэлхийн хамгийн эртний соёл иргэншлүүдийн нэг бөгөөд тэнд олон эзэнт гүрэн сэхэж,сөхөрч байсан түүхтэй. Гэхдээ тус гүрнүүдээс эдийн засгийн хувьд хамгийн хүчирхэг байсан нь 16-р зуунаас 19-р зуун хүртэл буюу Их Британийн колончлол тогтох хүртэл оршин тогтносон Их Могол улс юм. Түүхч Ангус Маддисоны хэлснээр Их Могол улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн тухайн үеийн Англи болон Францтай тэнцэхүйц байсан ч нийгмийн эрх баригч анги давхаргын тансаг амьдралын хэв маяг Европын нийгмээс хэт давсан байсан гэжээ.

Тухайн үед Энэтхэгт очсон Европын худалдаачид Их Моголын цайз,цэцэрлэг, уран зохиол болон уран зургийг яах аргагүй биширдэг байсан гэлцдэг

бөгөөд Энэтхэгийн ард түмэн алтнаас бусад барууны бараа таваарыг огт сонирхдоггүй байсан аж. Ийм ч учраас тэдний эрэлтийг хангах үүднээс барууны колончлогчид Америк тивийн үнэт металлыг цөллөсөн ч гэж ярьдаг. Харин Британийн эзэнт гүрний аж үйлдвэржилт улам хүчээ авснаар Их Могол улс 19-р зуунд албан ёсоор Британийн колон улс болсон юм.

Британийн Эзэнт гүрэн / МЭ 1870 он/

Эдийн засагчдын хувьд дэлхийн түүхэн явцын ДНБ-ийг тооцож судлахад нотолгоо баримт маш багатай байдаг. Харин Британийн эзэнт гүрэн татвар болон бусад бүртгэлийг дэлгэрэнгүй хийж үлдээсэн нь судалгааны ажлуудыг баримтжуулах чухал түлхэц болсон гэдэг. Мөн Британи нь дэлхийн эдийн засгийг ноёрхол бий болгоход хамгийн их хүн амтай улс байх шаардлагагүй гэдгийг нотолсон анхны гүрэн юм. Британийн гол давуу тал аж үйлдвэрийн хувьсгалаас үүдэлтэй шинэ техник технологи мөн колони улсуудаас

авдаг байсан ашигт оршиж байжээ. Британийн Эзэнт гүрний оргил үед тэдний нийт бүтээгдэхүүний зургаагаас илүү хувийг тэдний колони улсууд бүрдүүлж байсан аж.

АНУ / МЭ 1950 он/

Дэлхийн II дайны эцэс гэхэд АНУ дэлхийн эдийн засгийн нийт бүтээгдэхүүний тал хувийг үйлдвэрлэж байлаа. Хэдий тийм боловч энэхүү “амжилт” түр зуурынх байсан юм. Учир нь тухайн үед бусад хүчирхэг гүрэн Дэлхийн II дайнаас бүрэн сэргэж амжаагүй байжээ. АНУ 19-р зууны сүүлээр хүн амын хурдацтай өсөлт, байгалийн асар их баялаг болон бизнес эрхлэгчдэдээ түшиглэн дэлхийн тэргүүлэх эдийн засаг болж чадсан аж. Гэвч өнгөрсөн зуунд тэд ийн давамгайлж байсан гол шалтгаан нь дайн. Харин өнөөдөр АНУ-ын хүч суларч байгаа нь дотоодын өсөлт суларч байгаагаас бус харин бусад улс гүрэн тэднийг гүйцэж эхэлж байгаатай холбоотой аж. ■

Эх Сурвалж: fortune.com

Банкны салбараар дамжуулан гадаад хөрөнгийн урсгал татах боломжууд

Л.Гангэрэл /Эдийн засагч/

Сүүлийн саруудад гадаадын хөрөнгө оруулалтын урсгал эрс татарч, манай улсын экспортын голлох нэрийн бүтээгдэхүүнүүд болох зэс, нүүрс, төмрийн хүдрийн дэлхийн зах зээл дээрх үнэ эрчимтэй унасан. Үүнтэй холбоотойгоор гадаад хөрөнгийн урсгалыг татах боломжуудыг судалж, хайж байна.

Бусад салбартай харьцуулахад хөгжлийн хувьд дэлхийн жишигт дөхөж очсон, сүүлийн үед батлагдсан хууль тогтоомжуудаар гадаадаас хөрөнгө оруулалт татах хууль эрх зүйн тааламжтай нөхцөл бүрдсэн гэж болох банкны салбараар дамжуулан гадаад хөрөнгийн урсгал татах боломжууд хэр байгаа талаар ярилцъя.

Юуны өмнө банкны салбарын нөхцөл байдал 2015 оны эцэст ямар байх вэ гэдгийг авч үзье.

Одоогийн байдлаар дотоодын нийт 13, гадаадын таван банк төлөөлөгчийн газрын эрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Банкны салбар санхүүгийн салбарынхаа 95 хувийг эзэлж байгаа бөгөөд санхүүгийн салбарын ДНБ 818.5 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь Монгол Улсын ДНБ-ий 5.3 хувийг эзэлж байна. Банкуудын нийт актив хөрөнгө 22.6 их наяд, нийт хадгаламж 7.3 их наяд, нийт зээл 12.4 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн 92.8 хувь нь хэвийн, 2.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 5.0 хувь нь чанаргүй зээл тус тус эзэлж байна. Хамгийн сүүлд Монголбанкны ерөнхийлөгчийн 2015 оны дөрөвдүгээр сарын 17-ны өдрийн тушаалаар банкуудын хувь нийлүүлсэн

хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөгт хүргэх шийдвэр гарсан бөгөөд 2017 оны арванхоёрдугаар сарын 31 гэхэд энэхүү шаардлагыг бүх банк биелүүлэх үүрэгтэй болсон.

Гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор УИХ болон Монголбанкнаас дараах хоёр чухал шийдвэрийг гаргаад байгаа бөгөөд эдгээр нь банкны салбараар дамжуулан гадаадын хөрөнгө оруулалт татахад онцгой үүрэг гүйцэтгэхээр байна. Үүнд:

а) Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т “Баталгаа гаргуулагч нь хийх гадаад зээллэгтэйгээ тэнцүү хэмжээгээр өөрийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасыг барьцаалсан тохиолдолд тухайн зээллэгийн нийт дүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болох бөгөөд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн зөрүүгээс үүсэх эрсдэлийг баталгаа гаргуулагч этгээд хариуцахаар баталгааны гэрээнд тусгана”

б) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны хоёрдугаар сарын 19-ний А-35 тоот тушаалаар “Банкны олон улсын зах зээл дээрээс гурав жил болон түүнээс дээш урт хугацаатай бонд болон зээл хэлбэрээр татсан гадаад эх үүсвэрийг банкны заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх”

Банкны салбараар дамжуулан дараах гурван хэлбэрээр гадаад хөрөнгийн урсгалыг татах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1) Банкууд өөрсдөө гадаад зээллэг, бонд босгох



2) Банкууд гадаадын хөрөнгийн бирж дээр IPO хийх

3) Гадаадын банкуудын одоогийн статусыг дээшлүүлж салбарын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож, улмаар гадаад зээллэгийн санхүүжилт хийлгүүлэх

Дээрх хэлбэрүүдээр дамжуулан гадаад хөрөнгийн урсгал татах нь

Нийт банкны системээр авч үзвэл 2015 оны нэгдүгээр улирлын байдлаар банкууд нийтдээ 2.1 их наяд төгрөгийн Засгийн газрын үнэт цаас эзэмшиж байна. Үүнийг ам.долларт хөрвүүлэн авч үзвэл нэг тэрбум орчим ам.долларын гадаад зээллэг болон бондыг Засгийн газрын баталгаатайгаар гадаадын санхүүгийн зах зээл дээрээс босгох боломж харагдаж байна. Үүний эхлэл болгож Худалдаа хөгжлийн банк 400 сая ам.долларын бонд босгох асуудал ид яригдаж байна. Түүнчлэн Төрийн банк гадаадын зах зээл дээрээс 300 сая ам.долларын бонд босгоход нь баталгаа гаргаж өгөх Засгийн газрын шийдвэр гарсан. Гэхдээ банкны системийн хувьд таван том гэж нэрлэгддэг ХААН, ХХБ, Голомт, ХАС болон Төрийн банкны хувьд гадаадад бонд гаргах болон зээллэг авах боломжтой. Бусад дунд болон жижиг банкны хувьд тэдгээрийн ихэнх нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зээлийн рейтинг тогтоолуулаагүй, гадаадын аудитын компаниар аудит хийлгээгүй, нийт актив хөрөнгийн хэмжээ нь гадаад зээллэг болон бонд босгоход харьцангуй бага зэрэг шалтгааны улмаас гадаад зах зээл дээр бонд гаргах болон зээллэг

босгох бараг боломжгүй.

Гадаадын хөрөнгө оруулалтын урсгал татах хоёр дахь хэлбэрийн хувьд манай томоохон банкууд тухайлбал, ХААН, Голомт банк Лондон болон Сингапурын Хөрөнгийн бирж дээр IPO гаргах асуудал 2009 оны үеэс эхлээд хүчтэй яригдаж байсан. Ер нь Төрийн банкнаас бусад дөрвөн том банкны хувьд гадаад болон дотоодын хөрөнгийн биржид IPO гаргах бүрэн бололцоотой.

Төрийн банкны хувьд нэгдүгээрт, төрийн өмчит, хоёрдугаарт, цаашид хувьчлах эсэх асуудал тодорхойгүй байгаа тул энэ талаар ярихад эрт байна. Гэхдээ манай улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, ялангуяа, гадаад өрийн асуудал хүндрэлтэй байгаа, дөрвөн том банкны олон улсын үнэлгээний байгууллагуудын хийсэн үнэлгээ нь доогуур байгаа зэрэг

хүчин зүйлийн улмаас тэдгээрийн хувьд гадаадын хөрөнгийн биржид IPO гаргах нь тийм ч тохиромжтой биш байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын урсгал татах гурав дахь хэлбэрийн хувьд гэвэл гадаадын банкууд салбарын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Монголбанкаас авах хүсэлтэй байгаагаа шууд болон шууд бус байдлаар илэрхийлсээр байгаа.

Одоогийн байдлаар “Bank of China” албан ёсоор салбараа нээх хүсэлтээ Монголбанкинд өгөөд байгаа юм. Монгол Улсын Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд гадаадын банкууд өөрийн төлөөлөгчийн газраараа дамжуулан зээлийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч манай улстай ойролцоо орон байрлах салбараараа дамжуулан зээл олголт хийж байгаа. Тухайлбал, “Bank of China” Монголд төлөөлөгчийн газрын үйл ажиллагаагаа эхлүүлсний дараа

2.5 тэрбум орчим ам.долларын зээлийн өргөдөл, хүсэлт хүлээн аваад байгаагаа мэдээлж байсан.

Эдгээр гадаадын банкуудын хувьд, Европын Сэргээн босголт, хөгжлийн банкнаас бусад нь зээлээ ам.доллараар олгох нөхцлийг ихэвчлэн тавьдаг.

Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны хувьд Сангийн яам, Монголбанкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зөвхөн ам.доллар гэлтгүй монгол төгрөгөөр зээл гаргах үйл ажиллагаа явуулж байна. Дээрх гадаадын банкуудын зээл нь дотоодын арилжааны банкуудтай харьцуулахад хүү нь бага, хугацаа нь урт байдаг.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, банкны салбараар дамжуулан гадаадын хөрөнгийн урсгал оруулж ирэх дээрх гурван хэлбэр нь боломжит хувилбар тул бодитойгоор оруулж болно гэсэн хэрэг биш гэдгийг хэлэх нь зүйтэй. ■

MARKET ЗӨВЛӨГӨӨ

Оюутолгойн ордын өгөөжийг бид хэрхэн хүртэх ёстой вэ?

Г. Мөнх-Эрдэнэ /Хөрөнгө оруулалтын шинжээч, Гaүли YЦK/

Ерөнхий сайд дөрөвдүгээр сарын 5-нд ард түмэндээ хандаж хийсэн мэдэгдэлдээ “Оюутолгойн асуудлаар үндсэндээ тохиролцсон. Одоо техникийн асуудал үлдлээ. Удахгүй албан ёсоор хоёр тал мэдэгдэл хийнэ. Далд уурхайн санхүүжилт хийгдэхэд ойрхон байна” гэсэн. Маргааш нь Нью-Йоркийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Turquoise Hill Resource” компанийн хувьцааны ханш 11 хувиар өсөв. Тус компани нь “Оюу толгой” төслийн 66 хувийг эзэмшдэг. Өөр том ордод хөрөнгө оруулалт хийгээгүй энэ компанийн хувьд Оюутолгойн төсөл хэр зэрэг амжилттай хэрэгжинэ хувьцааны ханш төдий чинээ өсөх юм. Төсөл амжилттай хэрэгжинэ гэдэг нь Оюутолгойн нөөцийг ашиглана гэсэн үг. Тэгвэл бид баялгийнхаа өгөөжийг хэрхэн хүртэх вэ гэх асуултын хариу нь “Turquoise Hill Resource”-ийн

хувьцаа.

Төслийн амжилтанд юу нөлөөлөх вэ?

Мэдээж хэрэг зэсийн орд учир зэсийн үнийн өсөлт, уналт хувьцааны ханшид нөлөөлөх суурь хүчин зүйл болно. 2012 он хүртэл хувьцааны болон зэсийн ханш нягт хамааралтай явж ирсэн (график 1). Харин 2011 оны сүүл, 2012 оны эхний хагаст зэсийн ханш болон хувьцааны ханшийн хамаарал алдагдсан болохыг график 1 харуулж байна. Зэсийн ханш тогтвортой өсөлттэй байхад хувьцааны ханш хурдацтай унасаар байлаа. Өөрөөр хэлбэл, хувьцааны ханшид зэсийн үнээс гадна нөлөөлөгч өөр хүчин зүйл байна гэсэн үг. Тэр нь Монголын улс төрийн эрсдэл юм.

- 2012 онд УИХ-ын сонгууль болов. Оюутолгойн гэрээг анх батлахад УИХ-аар хэлэлцүүлж баталсан.

Тэгэхээр намуудын эрх ашиг ямар нэгэн балансад хүрч батлагдсан гэсэн үг. Тэгэхээр сонгуулийн дараа одоогийн УИХ, Засгийн газар нь солигдох уу? Солигдвол эрх ашгийн баланс алдагдах уу? Алдагдвал “Оюу толгой” төслийг гацаах уу? гэсэн олон асуултад хариулт авахад хүндрэл учруулж тодорхой бус байдал үүсгэж байгаа юм.

- Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг баривчлав. Энэ нь мөн л улс төрийн тодорхой бус байдлыг бий болгосон.
- Гадаадын хөрөнгө оруулалтыг үргээсэн хууль баталлаа. Энэ нь олон улсын Монголд итгэх итгэлийг бууруулав.

Дээрх шалтгаануудын улмаас 2012 оны эхний хагаст хувьцааны ханш хүчтэй унасан гэж хэлж болно. Харин хоёрдугаар хагасаас хувьцааны ханш зэсийн үнэтэй уялдаж эхлэв. Үр дүнд нь улс төрийн эрсдэл ханшид шингэсэн



Графикийн тайлбар: Шар нь зэсийн ханш, хар нь хувьцаан ханш

учир хувьцааны ханш бодит ханшаас бага үнэлэгдэхэд хүргэж байгаа юм. Улс төрийн эрсдлийн нөлөөг графикт улаан шугамаар хэрээслэсэн тал байгааг үзүүлэв. Улс төрийн эрсдэл үгүй болвол хувьцааны ханш зах зээлийн бодит ханшид дөхнө.

Далд уурхайн санхүүжилт эхлэхэд ойрхон байна

2013 оны долоодугаар сард Оюутолгойн далд уурхайн санхүүжилтийг зогсоосон. Хувьцааны ханш дараах хоёр хоногт нь 30 хувиар унав. Харин өнөөдөр буюу хоёр жилийн дараа санхүүжилтийн асуудалд хоёр тал тохиролцож төсөл урагшлахад ойрхон байгааг эх сурвалжууд мэдээлж байна. Өөрөөр хэлбэл, хувьцааны үнэ бодит үнэ рүү дөхөж эхэллээ.

Өнгөрсөн дөрөвдүгээр сарын 5-ны Ерөнхий сайдын мэдэгдлийн дараа хувьцааны ханш 11 хувиар өссөн бол мэдэгдлээс хойш нэг сар хагасын хугацаанд ханш 33 хувиар өслөө.

Оюутолгойн далд уурхайн санхүүжилтийн асуудлыг тун удахгүй шийдэх гэж буйг олон улсын мэдээллийн агентлагууд мэдээлсээр байна. Ерөнхий сайд ч “Блүүмбэрг ТВ Монголиа”-д өгсөн ярилцлагадаа далд уурхайн санхүүжилт шийдэгдэж байгааг дахин дурьдав.


Ханшийн өсөлт ханасан уу? Урт хугацаанд ханш хэд хүрэх вэ?

2013 оны есдүгээр сараас Оюутолгойгоос экспорт хийж эхэлсэн. Өнгөрсөн 2014 онд 1.6 тэрбум ам.долларын экспорт хийж, анх удаа ашигтай ажиллаж эхэллээ. Энэ бол зөвхөн ил уурхайн экспорт. Тэгвэл далд уурхайг 2019 онд ашиглалтад оруулбал экспорт их хэмжээгээр нэмэгдэнэ. Үүнийг дагаад хувьцааны ханш ч өснө. Компани тус төслийн хөрөнгө оруулалт нөхөх

Оюу толгойн 66%-ийг эзэмшигч “Turquoise Hill Resources” компанийн хувьцааны ханш



эх сурвалж Saxo Trader



эх сурвалж Saxo Trader

хугацааг өсөн жил гэж тооцоолсон. Тодруулбал, урт хугацаанд төсөл амжилттай хэрэгжихийн хэрээр ханш өсөх юм. Гэвч одоогийн нөхцөл байдалд ханшийн өсөлтийн энерги хэрхэхийг хэлэхэд хэцүү ч далд уурхайн бүтээн байгуулалт хийгдэж, ашиглалтад орж, улмаар олборлолт, экспорт хийн үйл ажиллагаа жигдрэх үед, мөн зэсийн ханш өнөөгийн түвшинд буюу 6000 ам.доллар орчимд хэлбэлзэх үед ханш хамгийн багадаа 15 ам.доллар, зэсийн ханш 9000 ам.долларт хүрвэл 25 ам.долларт хүрч өсөх боломжтой гэж үзэж байна. Харин дахин хямрал болж зэсийн үнэ 2700 ам.долларт хүрч унавал хувьцааны ханш дагаад унана.

Дүгнэлт

“Монгол иргэнд ногдох “Оюу толгой” төслийн өгөөж бага байна” гэж буй энэ үед хөрөнгийн зах зээл, хувьцаа зэргийг ойлгодог байснаар зэс-алтны том ордоосоо өгөөж хүртэх боломж байгааг харуулахыг зорьлоо.

Засгийн газрын тогтворгүй байдал, Оюутолгойн далд уурхайн санхүүжилтийг зогсоосон нь эдийн засгийн хүндрэл өнөөгийн түвшинд хүрэхэд онцгой нөлөө үзүүлсэн гэж өргөн олноороо дүгнэж буй. Гэсэн хэдий ч энэ үйл явдал тус компанийн хувьцааг маш хямдаар худалдан авах боломж олгож буй хэрэг болж байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Харин том дүр зургаар нь харвал, цаашид олон тооны ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах нь гарцаагүй. Тэр бүрт гадаадын хөрөнгө оруулагчид орж ирнэ. Харин тэрхүү хөрөнгө оруулагчид гадаадын биржид хувьцаагаа арилжааалдаг байх магадлал өндөр. Тодруулбал, бид хөрөнгийн зах зээл, хувьцааг одооноос судалж, ойлгодог болох хэрэгтэй. Мөн ирээдүйд өөрийн хөрөнгийг хэр зэрэг өсгөж чадах вэ гэдэг нь улс орон өөрийн баялгийг хэрхэн үр ашигтай зарцуулж чадах вэ гэх асуулттай чухал холбоотой юм. ■



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



QSDC
БИД ТАНЫ БИЗНЕСИЙН АМЖИЛТАД
ХӨРӨНГӨ ОРУУЛНА

Ханган нийлүүлэгчдийн хөгжил, чанарын төв нь хувийн хэвшлийн төлөөллийн санаачилгаар АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аас хэрэгжүүлж буй “Бизнесийг дэмжих санаачилга” төслийн дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулагдсан бизнес хөгжлийн байгууллага юм. Бидний зорилго дотоодын компаниудад борлуулалтаа нэмэгдүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг даван туулах, өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг хангахад нь техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тэдний өрсөлдөх чадварыг сайжруулахад оршино.

ХНХЧТ нь *Техникийн туслалцааны сангаараа дамжуулан дотоодын ЖДҮ-д тулгарч буй:*

- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- ISO, HACCP зэрэг олон улсын чанарын удирдлагын систем нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах;
- Шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх;

зэрэг зорилгоо биелүүлэхэд нь санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлж байна.

ХНХЧТ-ийн “Ханган нийлүүлэгчийг хөгжүүлэх” хөтөлбөр нь:

- нэг талаас өөрийн ханган нийлүүлэгчдийн үйлчилгээний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтэй худалдан авагч томоохон аж ахуйн нэгжүүд,
- нөгөө талаас өөрийн бизнесийг өргөжүүлэхээр эрмэлзэж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйлчилдэг.

**ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

**ЧАНАРЫН УДИРДАГАЙН
ХӨТӨЛБӨР**

ХНХЧТ нь компанийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон улсын шилдэг туршлагад суурилсан чанарын удирдлагын сургалтуудыг санал болгож байна. Манай байгууллага нь Лондонд төвтэй “Орчны эрүүл мэндийн итгэмжлэгдсэн институт”-ийн олон улсын гэрчилгээтэй дараах сургалтуудыг зохион байгуулж байна:

- Хүнсний аюулгүй байдал ба аюулын шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (HACCP);
- Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал.

Түүнчлэн бид “Зургаан Сигма – Ногоон бүст мэргэжилтэн бэлтгэх” сургалтыг түншлэгч байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

Холбоо барих хаяг:
Экспрес цамхаг, 12 дугаар давхар,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: (976) 11-321375
Факс: (976) 11-327825
Вэб хуудас: www.qsdc.mn

**БИД ТАНЫ БИЗНЕСИЙН
АМЖИЛТАД ХӨРӨНГӨ
ОРУУЛНА**




Б.Энхмөнх



"НЭГЭНТ СЭТГЭЖ БОДОЖ БАЙГААГААС ХОЙШ ТОМ СЭТГЭ"

ДОНАЛД ТРАМП (ТРАМП ЭНТЕРТАЙНМЭНТ-ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ)




"ИННОВАЦИ НЬ УДИРДАГЧ БОЛОН ДАГАЛДАГЧИЙН ЯЛГААГ ХАРУУЛДАГ"

СТИВ ЖОБС (*APPLE INC*-ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ)




"СҮҮ БИЛЭГТЭН НЭГ ХУВЬ УРАМ ЗОРИГ, ЕРӨН ЕСӨН ХУВЬ ХӨДӨЛМӨРИЙН ҮР ДҮНД ТӨРДӨГ"

ТОМАС ЭДИСОН (ЗОХИОН БҮТЭЭГЧ, БИЗНЕСМЭН)




"ДЭЛХИЙ МАШ ХУРДАЦТАЙ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙНА. ТОМ НЬ ЖИЖИГЭЭ ДИЙЛДЭГ ҮЕ ӨНГӨРСӨН. ХАРИН ХУРДАН НЬ УДААНАА ЯЛДАГ ЦАГ ИРЖЭЭ"

РУПЕРТ МЕРДОК (*NEWS CORPORATION*-ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ)



ТОМ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ НЬ ЖИЖИГ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭЭС ИЛҮҮ ХЯЛБАР БАЙДАГ"

СЕРГЕЙ БРИН (*GOOGLE*-ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ):



"АЛХАЖ СУРАХЫН ТУЛД ОРОЛДОЖ, УНАЖ БАЙЖ СУРДАГ"

РИЧАРД БРЭНСОН (*VIRGIN GROUP*-ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ):

Хэнри Форд (Форд Моторс-Үүсгэн байгуулагч):

"Бүтэлгүйтэл нь ердөө л илүү ухаалгаар дахин эхлэх боломж юм"

.Бэрти Чарльз Форбес (Форбес-Үүсгэн байгуулагч): "Хэрвээ та бизнесээ удирдахгүй бол бизнес таныг өөрөө хөөх болно"

Уоррен Баффетт (Беркшир Хатауэй-Гүйцэтгэх Захирал):

"Нэр төрийг 20 жилийн хүч хөдөлмөрөөр олж авдаг бол үүнийг үгүй хийхэд таван минут л хангалттай. Хэрэв үүнийг ойлгож чадсан бол та юмийг өөрөөр хийж эхлэх болно"

Билл Гейтс (Майкрософт-Үүсгэн байгуулагч):

"Амжилтыг магтах нь сайн боловч алдаанаас олох сургамж илүү чухал юм"

Марк Цукерберг (Фэйсбүүк-Үүсгэн байгуулагч):

"Хүмүүс хэн гэдгээ илэрхийлэхийг хүсдэг. Урьд нь ч тийм байсан"

Арианна Хаффингтон (Хаффингтон Пост-Үүсгэн байгуулагч):

"Та айж байсан ч хийхийг мөрөөддөг зүйлээ хийх ёстой"

Жефф Безос (Амазон-Үүсгэн байгуулагч):

"Хэрэв та үйлчлүүлэгчдэд эерэг сэтгэгдэл төрүүлвэл тэд энэ тухай дамжуулан хэлдэг. Үг гэдэг маш хүчтэй зүйл."

Сет Годин ("Squidoo"-Үүсгэн байгуулагч):

"Буруу байх нь юу ч хийхгүй байснаас хавьгүй бага уршигтай"

Зиг Зиглар (Зохиолч, худалдаачин):

"Хэрвээ та бусдын хүсэж байгаа зүйлийг авахад тусалбал та амьдралаас хүссэн бүх зүйлээ авч чадна"

Уолт Дисней (Уолт Дисней-Үүсгэн байгуулагч):

"Хэрэв та мөрөөдөж чадаж байвал та түүнийг хийж чадна"

Питер Шутц ("Porsche-Гүйцэтгэх Захирал"):

"Хүнийг ухамсарт нь үндэслэж ажилд ав, харин дараагаар нь түүний чадварыг сайжруул"

Марк Киубан (Даллас Маверикс багийн эзэн):

"Хэн нэг нь таны ажлыг булаахын тулд 24 цаг ажиллаж байгаа мэт ажил." ■

И.Сэр-Од: Хямралтай үед илүү санаачилга, идэвхтэй байх хэрэгтэй

Ц.Элбэг

Монголын бизнес мэдээллийн сан төслийн хэрэгжүүлэгч И.Сэр-Одтой ярилцлаа.

“Mongolian Business Database” –ийг байгуулах болсон шалтгаан юу вэ. Энэ гадаад улсад байдаг жишиг үү эсвэл шинэ санаачлага уу?

-Юуны өмнө Монголын Бизнесийн Зөвлөлийн тогтмол булан танай сэтгүүл дээр нээгдэж, анхны ярилцагч болж байгаадаа маш их баяртай байна. Монголд бизнес, хөрөнгө оруулалтын орчин, нөхцөл байдал хүнд байгаа нь бодитой харагдаж мэдрэгдэж байна. Гэхдээ бид бүх зүйлийг харлуулж ойлгоод, түүнд итгэл үнэмшлээ, алдаж зүгээр суугаад баймааргүй байна. Нөхцөл байдлыг зэрэгээр харж эдийн засгийн хямралтай энэ үед илүү идэвх санаачлагатай баймаар санагддаг. Олон улсын гэж тооцогддог Францын SUEZ, Японы SMBC, Мицуй, Герман, Францын Schneider Electric эсвэл Ramada, Shangri La зэрэг компаниуд оффис, үйл ажиллагаагаа нээж байна гэдэг нь тэд нааштай хандлагыг харж, ач холбогдол өгч байгаагийн илрэл шүү дээ. Өөрөөр хэлбэл, бизнесийн ерөнхий харилцаа идэвхгүй болсон энэ “завтай” үеийг ашиглаад төлөвлөж байсан бизнестээ ул суурьтай бэлдэх нь зөв байх.

Канадын бизнес датабэйз, Америкийн бизнес датабэйз гэх зэрэг мэдээллийн сан байдаг л даа. Тэдгээр нь гол төлөв компаниудын мэдээллийн жагсаалт байдаг. Бид мэдээллийн санг үүсгэхдээ арай өвөрмөц буюу Монголд үйл ажиллагаа явуулж байгаа, Монголд бараа бүтээгдэхүүн үйлчилгээгээр борлуулах болон Монголоос худалдан авах сонирхолтой гадаадын компаниуд хоорондоо харилцаж байх талбар нь байна гэж төлөвлөж энэхүү төсөл хэрэгжиж

эхэлсэн. Ерөнхийдөө Монголд чиглэсэн бүхий л компани, бизнес эрхлэгчдийн бүртгэл болж өргөжиж байгаа. Өөрөөр хэлбэл, хэн ч, хаанаас ч, хэзээ ч бүртгүүлж, бизнесийн холбогдох мэдээллийг тогтмол авч байх бололцоотой мэдээллийн сан бий болж байна. Одоогийн байдлаар 1500 орчим компани бүртгэлтэй байна.

-Энэ платформыг ашиглаад компаниуд гадаадын болон дотоодын компанитай харилцаа тогтоож буй жишээ байна уу?

-Компаниуд хоорондоо харилцахыг бид хянах шаардлагагүй л дээ. Угаасаа бизнесийн харилцаа нууц байдаг. Гэхдээ нэг компани нөгөө рүүгээ онлайн аар хандсан анхны мессэжийн хувь нь бидэнд харагдах байдлаар ирдэг. Энэхүү сайтын талаарх мэдээлэл нэлээд өргөн хэмжээнд хүмүүст хүрч эхэлж байгаа гэж ойлгож байна. Саяхан Польш улсаас “Танай сайт дээр байгаа тендерийн зарыг олж үзлээ. Манайх зүүн болон төв европын хамгийн том кабель үйлдвэрлэгч. Тендерийн дэлгэрэнгүй мэдээлэл Монгол хэл дээр байна, англи дээр олж өгч болох уу” гэж хандсан. Энэ бол бидний хүсэж, зорьж байгаа ажлын нэг хэсэг юм.

-Аль улсаас хамгийн их хандалттай байна вэ?

-Хоёр хөршөөс гадна Америк, Сингапур, Англи, Япон сүүлийн үед их дээгүүр гарч ирж байна. Хонгконг, Бразил, Турк, Польш, Чех улс дараа нь багтаж байгаа. Тэдний хувьд бараа бүтээгдэхүүнээ Монголд зарах сонирхолтой, түүний тулд эхлээд түнштэй болох шаардлагатай байгаа учраас гол төлөв дистрибьютер хайсан компаниуд нэлээд их байна. Нэг сонирхолтой зүйлийг хэлэхэд Бразилаас хандалт байнга дээгүүр гардаг юм. Хаа холын Бразилаас яагаад Монголыг сонирхдог байна гээд үзэхээр жишээ нь, 2015 онд Венесуэль, Бразил зэрэг улсуудын эдийн засаг тэг түвшинд байна гэсэн урьдчилсан таамаг гарсантай



холбогдуулан тэнд байгаа бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид бусад орны зах зээлийг судалж байгаа хэрэг.

-Монголын бизнес мэдээллийн сан гэдэг энэ вэбсайтын өөрийнх нь бий болгож буй боломж, алсын хараа нь юу вэ?

-Өнөөдөр хэчнээн үгүйсгэх гээд чадахгүй бодит үнэн бол бид уул уурхай, байгалийн баялагт тулгуурласан эдийн засагтай байна. Гэхдээ энэ салбараас бий болох ашиг, орлого бусад бизнесийн салбараа ивээн тэтгэж хөгжүүлж байх зайлшгүй шаардлагатай. Товчхондоо, бид бусад бизнесийн салбарыг идэвхжүүлэхэд гол анхаарал хандуулж зорьж байгаа. Өнөөдөр баялгийг бүтээдэг бизнесмэнүүдийн харилцаа сулрахтай зэрэгцээд нийгмийг ерөнхийдөө ийм байдалд оруулсан улс төрийн хандлага хаашаа чиглэхээр байна, Засгийн газар ямар зоримог, үр дүнтэй шийдвэр гаргах вэ гэж хүлээсэн идэвхгүй хэлбэрт оржээ. Бизнес хөдөлгөөнд орж, бизнесийн харилцаа идэвхжих нь энэ бүхнээс гарах цорын ганц шийдэл гэдэг нь гарцаагүй үнэн. Үүнд хувь нэмрээ оруулах зорилготой байна.

Энэ төсөл нь зөвхөн онлайн талбар биш. Бид бизнес эрхлэгчдийг бодитоор уулзан танилцаж бизнесийн ажил хэргээ өргөжүүлэхэд нь нэмэр тус болох зорилготой. Тодорхой ажлууд хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, МҮХАҮТ-тай хамтран сар бүр “Бизнес-с-бизнес” нэртэй уулзалт арга хэмжээ зохион байгуулж эхэлсэн. Уулзалт тогтмол байснаараа эхний удаад нэрийн хуудсаа солилцож танилцах, хоёр дахь удаадаа бизнесийн санаагаа хуваалцаж, дараа дараагийн уулзалтаараа илүү нарийн мэдээллээ солилцох, гэрээ хэлэлцээр байгуулагдах түвшинд хүрдэг. Энэ бол бизнесийн харилцаа хөгжсөн барууны орнуудын нийтлэг жишиг. ■



СУДАЛГАА

Маркетингийн сэтгэл судлалын тухайд

Б.Оюунчимэг

/СЭЗДС-ийн зөвлөх профессор, сэтгэл судлалын ухааны доктор (Ph.D)/

Маркетинг нь “Market” хэмээх англи үгнээс үүдэлтэй бөгөөд эрэлт, хэрэгцээ, хэрэглээг зохицуулахуй гэсэн утгатай. Энэхүү ойлголт зах зээлийн харилцааг даган хэдэн жилийн өмнөөс монгол хэлний үгсийн санд цоо шинээр орж ирсэн үг. Маркетинг нь зах зээл, борлуулалт, үнэ ханш, дэлгүүр, худалдаа гэсэн олон зүйлийн талаарх цогц ойлголт юм. Хүний эрэлт, хэрэгцээг хангах, байгууллагын болон хувь хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулах ухаан ч гэж түүнийг ойлгож болно.

Маркетинг нь эдийн засаг, статистик, менежмент, гоо зүй, ёс зүй, сэтгэл судлал зэрэг хэд хэдэн шинжлэх ухааны уулзвар дээр хөгжиж байна. Эрэлт, хэрэгцээг хангах объект нь хүн. Өөрөөр хэлбэл, хүн л төрөл бүрийн

үйл ажиллагааныхаа үр дүнд эрэлт, хэрэгцээг барагдуулдаг. Эрэлт, хэрэгцээг хангуулагч, хэрэглэгч нь бас хүн. Ийнхүү маркетингийн эх сурвалж нь гагцхүү сэтгэцийн өөр өөрийн онцлогтой хүмүүс юм. Маркетингийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд түүнд оролцогч хүмүүсийн сэтгэл зүйн онцлогийг судлах, үйл ажиллагаандаа харгалзах шаардлагатай болдог.

Дэлхийн улс орнуудад зах зээл хөгжих, даяарших, хүний сэтгэл зүйн хүчин зүйлсийн ач холбогдлыг ойлгох, харилцаа, үйл ажиллагаандаа харгалзаж үзэх шаардлага нэмэгдэхийн хэрээр маркетингийн харилцаанд оролцогчдын сэтгэл зүйн онцлогийг бүхий л талаас нь судлах хэрэгцээ улам бүр ихсэж байгаа нь маркетингийг

сэтгэл судлалын шинжлэх ухаантай улам бүр холбож байна.

Маркетингийн үйл ажиллагааг үр дүнд хүргэх үндэс нь түүнийг эрхлэгчид болох маркетеруудын хувь хүний болон үйл ажиллагааны сэтгэл зүйн онцлог, маркетингийн үйл ажиллагаанд татагдан оролцогчид болох хэрэглэгчид (үйлчлүүлэгч, худалдан авагч)-ийн нийгэм-сэтгэл зүйн хийгээд харилцааны сэтгэл зүйн онцлогийг судлах, танин мэдэх, маркетингийн үйл ажиллагаанд харгалзах явдал юм.

“Зах зээл” хэмээх нийгмийн шинэ тогтолцоо, түүний хөгжил дэвшил, монголчуудын ухамсарт гарсан чанарын өөрчлөлт, соёлын түвшингийн дээшлэлт, хүмүүсийн хэрэглээний өсөлт, олон талт байдал зэрэг нь маркетеруудаас сэтгэл

судлалын өргөн мэдлэг, мэргэжлийн үр чадвар, дадлага, туршлага, ёс суртахууны соёлыг зүй ёсоор шаардсаар. Маркетерууд хэрэглэгчдийнхээ сэтгэл зүйн онцлогийг судлаад зогсохгүй өдөр тутмын үйл ажиллагаандаа үр өгөөжтэй ашиглах арга барил эзэмших нь тун чухал байгаа юм.

Маркетер нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг урьдчилан мэдэх, бизнесийн эрсдэлийг багасгах, борлуулалт бүрийн ашгийг тодорхойлох, илүү оновчтой шийдвэр гаргах зорилгоор зах зээлийг судлах, танин мэдэх, үйлдвэрлэх, хуваарилах, худалдан авагчид хүргэх эдийн засгийн урсгалыг удирдах, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах, эрэлт, нийлүүлэлтийг уялдуулан зохицуулахын тулд зах зээлийн хариу үйлчлэлийг судлах, шаардлагатай мэдээллийг байнга тодорхойлох, цуглуулах, задлан шинжлэх, үр дүнг нь тооцох замаар маркетингийн судалгаа тогтмол явуулах зэрэг үйл ажиллагаа бүрийг сэтгэл судлалын шинжлэх ухаанч мэдлэгт тулгуурлан явуулснаар улс орны эдийн засгийн хөгжил, маркетингийн үйл ажиллагааны ахиц дэвшилд бодит хувь нэмэр оруулна.

Маркетинг олон төрөлтэй. Тэдгээрийн нэг нь хувь хүний маркетинг. Хэрэглэгч хэн болох, хаана, хэрхэн амьдардаг, нийгэмд ямар байр суурь эзэлдэг, ямар үнэтэй, аль бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, ямар үйлчилгээ хийлгэж чадахыг хувь хүний маркетинг судалдаг. Хувь хүний маркетинг нь хүний нийгэмд эзлэх байр суурь, зан төлөвийг бүрдүүлэх, хэвээр хадгалах, улмаар өөрчлөхөд чиглэгдсэн үйл ажиллагаа. Хувь хүний маркетингийн үүрэг хэрэглэгчдийн сэтгэц, зан төлөвийн онцлогийг судлах, эерэг шинжүүд бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сөрөг муу чанаруудыг өөрчлөн засахад туслахад оршино.

Хэрэглэгчид гэдэг нь хувийн хэрэгцээнд зориулж бараа бүтээгдэхүүн худалдан авдаг, үйлчлүүлдэг хувь хүн, айл өрх, байгууллага юм. Хэрэглэгчид нас, хүйс, нийгмийн байдал, мэдлэг, боловсрол, хэрэгцээ, таашаал, ажил алба, ахуй амьдрал, орлого, хүсэл, сонирхлоороо ялгаатай байдаг. Зах зээлийн хэрэглэгчдийг хүүхдүүд, насанд хүрсэн залуус, дунд насныхан, настайчууд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хотын, хөдөөгийн хэрэглэгч гэж бүлэглэн хуваадаг. Бүлэг



бүр өөр өөрийн онцлогтой. Жишээ нь, насанд хүрсэн залуу хэрэглэгчид болох 18-25 насны ганц бие залуус, оюутан сурагчид, залуу гэр бүлүүд шинэ бараа бүтээгдэхүүнийг хэрэглэж үзэх дүр хүсэл ихтэй, мөнгө хурааж хадгалахыг бараг боддоггүй, бараа бүтээгдэхүүний гадаад байдал, үзэмжийг илүүтэй анхаардаг, яс чанарыг нь төдийлөн хардаггүй, ганган чамин загвар хийцтэй, өнгөлөг тод хувцас хунар, гар утас, компьютер, зургийн аппарат, хуурцаг худалдаж авах болон үс, зүсээ засуулж янзлуулахад ихэнх мөнгөө зарцуулдаг, уйдамтгай, шинэ соргог юманд дурламтгай, сонирхсон бараа бүтээгдэхүүнийг даруй өөрийн болгохыг хичээдэг онцлогтой. Залуу хэрэглэгчид бараа бүтээгдэхүүнийг төвөггүй сонгодог бол ахимаг насныхан удаан бодож, чамгүй нягталж байж худалдан авах шийдвэр гаргадаг. Тэд хэрэглэж хэвшсэн бүтээгдэхүүнээ солих дургүй, нэлээд болгоомжломтгой, заримдаа хэт болгоомжлох нь ч бий.

Хэрэглэгчид шинэ бараа бүтээгдэхүүнд хандах, хүлээн авах, туршин үзэх байдлаараа ч ялгагддаг. Үүнд:

- Шинэ барааг дор нь хүлээж авдаг, аз турших, эрсдэл хүлээхийг төдийлөн тоодоггүй. Ийм хэрэглэгчид тун бага хувьтай байдаг;
- Шинэ бараа бүтээгдэхүүнийг бусдаас харьцангуй эрт хүлээн авдаг ч болгоомжтой ханддаг;
- Шинэ барааг хянамгай хүлээн авдаг, нийтийн жишгийг дагадаг;
- Шинэ бараа бүтээгдэхүүнд

итгэл тааруу, нэлээд удаавтар хүлээн авдаг;

- Хуучныг баримталдаг, шинэ бараанд тун сэжигтэй ханддаг, бүр хэвшил болсны дараа хүлээж авдаг;
- Хэрэглэгчдэд гадаад болон дотоод хүчин зүйлс нөлөөлдөг. Гадаадад нь соёлын болон нийгмийн, дотоодод нь сэтгэл зүйн болон хувийн ялгааны хүчин зүйлсийг оруулдаг. Сэтгэл зүйн хүчин зүйлс нь сэдэл, шалтгаацил, ойлгоц, мэдрэмж, хандлага буюу итгэл үнэмшил бол хувийн ялгааны хүчин зүйлс нь нас, хүйс, ажил эрхлэлт, амьдралын хэв маяг, эдийн засгийн байдал, зан төлөвийн онцлог юм.

Хүнд янз бүрийн хэрэгцээ байнга бий болж байдаг. Хамгийн ихээр гачигдаж байгаа хэрэгцээг эхлээд хангадаг. Үүнтэй зэрэгцэн дараачийн хэрэгцээ гарч ирдэг. Энэ нь шалтгаацил юм. Хүн өдөр бүр маш олон өдөөгчтэй тааралдаж, тэдгээрийг шүүн тунгаах, тухайн цаг мөчид өөрт нь хэрэгцээтэй байгаа өдөөгчийг илүүтэй мэдэрч, хүсэн хүлээж байгаа өдөөгчид өртөмтгий байдаг бол бусдаас содон өдөөгчийг амархан ажигладаг. Маркетингийн менежерүүд шүүн тунгаах шинжтэй өдөөгчийг хэрэглэгчдийн анхаарлыг татах хэрэгсэл болгон ашиглах чадвар эзэмших хэрэгтэй.

Маркетеруудын мэргэжлийн нийтлэг болон хувийн өвөрмөц онцлог, шинж чанаруудыг судлах, танин мэдэх, ойлгож ухаарах, ажил мэргэжилдээ ашиглах боломжийг маркетингийн сэтгэл судлал

олгодог. Маркетер хэд хэдэн зүйлийг нэг зэрэг хийхийн тулд доод тал нь хоёр үйлдлийг автоматаар хийх чадвар эзэмшсэн байх ёстойг сэтгэл судлаачид тогтоожээ. Анхаарлаа оновчтой төвлөрүүлэх, хуваарилах, шилжүүлэх, хэд хэдэн объектод зэрэг анхаарал хандуулах зэрэг мэргэжлийн шаардлагыг маркетингийн мэргэжилтнүүдэд тавьдаг. Бараа бүтээгдэхүүний борлуулалт, ажил үйлчилгээний цар хүрээний өсөлт маркетеруудын үйл ажиллагаа, харилцаанаас шууд хамаардаг.

Хэрэглэгч бүтээгдэхүүний талаар тодруулга авахаар утастахад анхааралгүй, хайхрамжгүй хандах, бүтээгдэхүүн худалдан авахаар ирэхэд нь үл ойшоох, басамжлан харилцах нь маркетингийн үйл ажиллагаанд хортойгоор нөлөөлнө. Маркетер нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, үнэ, орчин нөхцөл, мэдээлэл, сурталчилгааг хэрэглэгч хэрхэн хүлээн авч, яаж хандаж байгааг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, үйл ажиллагаандаа харгалзан ашиглаж байх шаардлагатай. Үүнд маркетингийн сэтгэл судлалын мэдлэг тусална.

Зах зээлийн маркетингийн нэг хэсэг нь зар сурталчилгаа юм. Зар сурталчилгаа нь хэрэглэгчдийн хэрэгцээг илүү үр ашигтай, оновчтой хангах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тасралтгүй борлуулах, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, нэр төрөл, хэрэглэх хугацаа, ашиглах журам, хэрэглээний талаар хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэх зорилготой маркетингийн үйл ажиллагаа юм. Ер нь сурталчилна гэдэг нь хэрэглэгчдийн сэтгэц (оюун ухаан, сэтгэл)-д нөлөөлөх, тухайлбал, мэдрэмж, илгэл үнэмшил төрүүлэх, сэтгэлийг нь хөдөлгөж бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ татах явдал юм.

Хүнд таашаал төрүүлэх зар сурталчилгаа, бараа бүтээгдэхүүн борлуулах зар сурталчилгаа хоорондоо ялгаатай. Бараа бүтээгдэхүүнийг сонирхуулах, худалдан авах хүсэл төрүүлэх хэрэгцээт бараа, үйлчилгээг эрж олох, шилж сонгох, сонгосон бараа, үйлчилгээг ашигтай, хэрэгтэй, чанартай, давуу талтай зүйл болохыг ойлгуулах замаар худалдан авах шийдвэр гаргахад нь туслах, үнийг

бодитой мэдээлэх, өөрчилсөн шалтгааныг үндэслэлтэй тайлбарлах, буруу ташаа төсөөллийг залруулах, айдас болгоомжлолыг сарниулах, зөвхөн зэрэг мэдрэмж төрүүлэх, сэтгэлийг сайн сайхнаар хөдөлгөхүйц хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлсэн хариуцлагатай, сэтгэл судлалын мэдлэгт тулгуурсан зар сурталчилгаа явуулах, зар сурталчилгаанд ёс суртахуунлаг хандах шаардлагатай байна.

Хүн нийт мэдээллийн 70-80 хувийг нүдээрээ хүлээн авдаг, нүдээр харж үзсэн зүйлдээ илүү итгэдэг. Үнэр нь нейромаркетингийн хүчирхэг зэвсэг

Үйлчилгээ нь биет биш, холимог үйлдэлтэй, үнэ цэнэ нь худалдагч, үйлчлүүлэгч хоёрын харилцаанаас хамаардаг, үйлчлүүлэгч нь хайх, турших, итгэх үйлдэл хийж байдаг тул ажил үйлчилгээний зар сурталчилгааг үйлчилгээ эрхэлж буй байгууллага, хүмүүсийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, танин мэдэхүйн мэдээлэл, мэдрэмж хурцлах, сэтгэл хөдөлгөх мэдээлэл гэсэн дараалалтай явуулах нь зүйтэй. Манайд худалдаа арилжааны зар сурталчилгаа илүү дэлгэрч байгаа ч алдаа дутагдал ихтэй байна. Жишээ нь, олон бараа бүтээгдэхүүний үнийг чамгүй хувиар хямдруулна гэсэн зар сурталчилгаа үргэлж явуулдаг ч үнэн хэрэгтээ цөөхөн барааны үнийг багахан хувиар хямдруулдаг.

Бараа бүтээгдэхүүн худалдан авахад барааны шинж чанар, эрүүл мэндэд нөлөөлөх байдал, хийц загвар, үнэ, сав, баглаа боодол, чанарын тэмдэг, баталгаат хугацаа, барааны өрөлт, худалдагчийн харилцах болон хүн татах чадвар, хэрэглэгчийн хувийн онцлогууд болох бусдыг дуурайх, дагах, бусдад таалагдах, ганган дэгжин харагдах, анхаарлыг татах, нэр хүндтэй байх

хүсэл, эрмэлзэл, хийц загварын талаарх үнэлэмж, таашаал нөлөөлдөг.

Хэрэглэгчдийн анхаарлыг татах, бараа бүтээгдэхүүнд хандуулах хэрэгсэл болох цочроогч буюу маркетингийн өдөөлт хүчтэй байхын хэрээр хүн түүнийг илүүтэй анхаарч, татагддаг. Маркетингийн өдөөлтийг хэрэглэгч хэрхэн мэдрэж, танин мэдэж, хүлээн авч, хариу үйлдэл үзүүлж байгааг судалдаг нейромаркетингийн сэтгэл судлал хэмээх салбар бий болоод байгаа.

Хүний харах, үнэрлэх, сонсох, амтлах, хүрэлцэх мэдрэхүй худалдан авах шийдвэр гаргах үйл явцад хэрхэн нөлөөлөхийг нейромаркетингийн сэтгэл судлал судалдаг.

Маркетингийн өдөөлтийн өнгө, үнэр, хэлбэр, хэмжээ, байрлал (нүдэнд өртөхүйц түвшинд байх), шинэлэг байдал анхаарч тусгах, мэдрэх, хүлээн авах, тогтооход чухал үүрэгтэй.

Хүн нийт мэдээллийн 70-80 хувийг нүдээрээ хүлээн авдаг, нүдээр харж үзсэн зүйлдээ илүү итгэдэг. Үнэр нь нейромаркетингийн хүчирхэг зэвсэг. Тааламжтай үнэр хүний сэтгэл санааг тайвшруулаад зогсохгүй урам зориг, эрч хүч өгдөг бол тааламжгүй үнэр сөрөг муу сэтгэгдэл төрүүлдэг.

Бараа бүтээгдэхүүний чанар чансаа, ая тух, ашиг тусыг магтахад хэрэглэгчид таатай төсөөлөл төрдөг, төсөөллөө хэр үнэн болохыг шалгахыг хүсдэг, улмаар бараа бүтээгдэхүүнийг худалдан авдаг. Сайхныг мэдрэх, таатай сэтгэгдэл төрүүлэх нэг арга бол сайхан амтыг мэдрүүлэх явдал юм. Иймээс ч бараа бүтээгдэхүүн борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг компаниуд хэрэглэгчдийг амттай кофе, ундаа, чихрээр дайлдаг.

Өнгө нь хүний сэтгэл санаанд янз бүрээр нөлөөлдөг.

Хар өнгө гэрлийн 65 хувийг өөртөө шингээж, гэрэл гэгээ багатай мэт мэдрэмж төрүүлж, хүний сэтгэлийг аягүйцүүлдэг бол ногоон өнгө тайвшруулж амраадаг.

Худалдааны танхимд бараа өрж байрлуулахдаа дэвсгэр өнгийг зөв сонгох нь тун чухал. Барааны тухай хүмүүсийн ойлголт, өнгө хоёрын хооронд сэтгэл зүйн тодорхой холбоо бий болсон байдаг тул сүү, сүүн бүтээгдэхүүнийг цагаан тавиур дээр тавих, өвлийн хувцасыг цэнхэр, мөнгөлөг өнгийн өлгүүрт өлгөх нь зохистой. ■

Хяналт ба зөрчлийн ГИНЖИН ХЭЛХЭЭ



Д. Авирмэд /МУИС, Бизнесийн сургуулийн багш, Доктор(Ph)/
Б.Болор /МУИС, Бизнесийн сургуулийн багш, Магистр/

Манай улсад аудит үүсч бий болсоор тодорхой хугацаа өнгөрч өнөөдөр олон улсын нийтлэг жишиг, хэв маягийг олжээ. Гэсэн ч төрийн аудитын тогтолцоонд шийдвэрлэх асуудал багагүй байна. Тухайлбал, аудит зарим талаар үр дүнтэй байж чадахгүйгээс төсвийн хөрөнгийн зүй бус зарцуулалт бий болж аудитын үйл ажиллагааны үнэлэмж буурах зэрэг сөрөг үр нөлөө байна.

Аудит нь санхүүгийн мэдээллийг зөвхөн үнэн зөв эсэхийг баталгаажуулдаг. Энэ нь хэрэглэгчдэд үйл ажиллагаагаа үр ашигтай явуулах, зөв шийдвэр гаргахад нь туслах зорилготой. Аудитын дүгнэлт нь байгууллага, хувь хүний нэр хүнд, өсөлт, бууралтад нөлөөлөхүйц байдаг. Иргэд олон нийтийн зүгээс аудитын байгууллагын ажлын дүнг үнэн зөв гэж итгэдэг нь энэ ажлын хариуцлагыг илэрхийлнэ.

Манай практикт хяналтын бие даасан хэлбэр болох аудитын тогтолцоо 1997 онд Аудитын тухай хууль батлагдсанаар анх бий болсон.

Хяналтын тогтолцоонд хараат бус хөндлөнгийн хяналтын хэлбэрийг төрийн зохицуулалтын нэг хэрэгсэл, зайлшгүй байх төрийн институци хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага зах зээлийн орнуудад түгээмэл. Монгол Улсын төрийн санхүүгийн хяналтын байгууллага 1922 онд Засгийн газрын дэргэд “хянан байцаах хэлтэс” гэж байгуулагдсан бол “Төрийн аудитын тухай хууль” 2003 онд батлагдсан нь хяналтын тогтолцоог шинэ шатанд гаргах бодит алхам болсон билээ.


Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай зэрэг 40 гаруй хууль, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдсон заавар, дүрэм, журмууд Монгол Улсад үйлчилж байгаагаас харахад өнөөдөр төрийн аудитын тогтолцоонд хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн гэж хэлж болохоор. Гэвч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй, үр нөлөө төдийлөн сайн биш байгааг үгүйсгэх боломжгүй.

Орон нутаг дахь төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийгдэж буй аудитын өнөөгийн байдал (баруун бүсийн аймгуудын жишээгээр)

Монгол улсын хэмжээнд төрийн аудитыг хэрэгжүүлэх дээд байгууллага нь “Үндсэний аудитын газар” юм. Тус байгууллага зорилгоо “Улс нийтийн хөрөнгө нөөцийг сайтар бүртгэж ашиглаж байгаа эсэх талаарх хараат бус баталгаа, мэдээлэл, зөвлөгөөгөөр хууль тогтоох байгууллагыг хангах...” гэж тодорхойлжээ. Үндэсний аудитын газрын эрх, үүрэг нь энэхүү зорилготой уялдаж тодорхойлогдох учиртай. Гэтэл хуульд зааснаар Үндэсний аудитын газар нь “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх... бүрэн эрхтэй. Энэхүү заалт нь аудит гэсэн нэр томъёо, холбогдох хуулийн зарим заалтуудтай утга, агуулгын хувьд зөрчилтэй байгаа юм. Жишээлбэл, хуульд зааснаар “төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийж, дүгнэлт тайлан бичих ба нөөцийн ашиглалт, хуулийн хэрэгжилт, санхүүгийн тайлангийн мэдээллийн үнэн зөв байдлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргахыг илэрхийлсэн байна. Тухайлбал, Санхүүгийн тайлангийн аудит нь аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулна” гэжээ. Энэ нь мөн олон улсын түвшинд мөрддөг актуудад ч тусгалаа олсон байдаг зэрэг баримтаас харахад энэ төрлийн аудитад “акт тавих” үүрэг байхгүй. Түүнчлэн акт торгууль тавих энэхүү зохицуулалт нь аудитын утгыг алдагдуулах, үйл ажиллагааг гажуудуулахаас гадна төсвийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулах, хяналтыг үр ашиггүй болгох зэрэг олон сөрөг үр дагавар, үр нөлөө бий болгосоор байна.

Хууль болон дүрэм журамд зааснаар төрийн аудитын

орон нутаг дахь салбар байгууллагууд аудитыг тогтсон хугацаанд тогтмол хийж иржээ (Дүрслэл 1).




Эх сурвалж: Орон нутаг дахь төрийн аудитын салбар байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, мэдээллээс

Баруун бүсийн аймгуудад хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтын тоо өсөлттэй байгаа нь төрийн аудит тасралтгүй хэрэгжиж буйг харуулах боловч нөгөө талаас эрсдэлд суурилсан аудитыг хэрэгжүүлдэггүй, бүх байгууллагыг давтан шалгалтад хамруулдаг болохыг харуулж байна. Төрийн аудитын байгууллага аудитын мөрөөр шалгагдагч байгууллагад акт тавих, зөвлөмж бичих, албан шаардлага хүргүүлэх хэлбэрээр эргэх холбоо үүсгэдэг.


Аудитын шалгалтаар тавьсан актын тоо өсөх хандлагатай байгаа нь аудитаар илэрсэн алдаа зөрчил нэмэгдсэнийг илэрхийлнэ. Үүнд аудитын шалгалтанд хамрагдсан байгууллагуудын тооны өсөлт нөлөөлсөн байж болох ч зөрчил илэрсээр байгаа нь аудитын шалгалтын үр дүн, үр нөлөө хангалтгүй, түүнчлэн үйлчлүүлэгч /төсвийн/ байгууллагуудын санхүүгийн тайлан бэлтгэх ажиллагаа холбогдох стандартын дагуу хийгдэж чадахгүй байгааг харуулж байна (Дүрслэл 2, Дүрслэл 3).



Тавьсан актын дүн /сая төгрөгөөр/




Аудитаар илэрсэн нийт төлбөр, зөрчлийн дүн



Эх сурвалж: Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын мэдээлэл


Сүүлийн таван жилийн нийт дүнгээр баруун бүсийн аймгуудын хэмжээнд 503-578 сая төгрөгийн акт торгууль тавигдсан ба бүх хугацаанд 85-аас дээш хувийн биелэлттэй байна. Судалгаанд дурдсан онуудад баруун бүсийн хэмжээгээр нийт 1895.7-4246.3 сая төгрөгийн зөрчил илэрч байжээ. Зөрчлийн мөнгөн дүн буураагүй, тогтмол илэрсээр байсан нь төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналт хангалтгүй зэрэг үзэгдлээс гадна аудитын үр дүн, үр нөлөө хангалтгүй байгааг илтгэнэ. Судалгаанд хамрагдсан онуудад баруун бүсийн аймгуудын хэмжээгээр нийт 1709.4-3707 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн бөгөөд тэдгээрийн биелэлт 75.4-100 хувь байна. Энэ нь аудитын шалгалтын үр дүнг илэрхийлэх үзүүлэлт гэж хэлж болох ч хүргүүлсэн албан шаардлага, акт торгууль нь холбогдох албан тушаалтанд хамаарах нэг ч тохиолдол байхгүй. Зөвхөн байгууллага төсвийн хөрөнгөөр төлсөн байгаа юм (Дүрслэл 5).

Зөрчлийг арилгахаар өгсөн албан шаардлагын дүн /сая төгрөгөөр/




Аудитаар илэрсэн зөрчлийг арилгахаар өгсөн албан шаардлагын тоог аймаг тус бүрээр авч үзэхэд дунджаар 240 орчим шаардлага хүргүүлсэн, эдгээр нь аймаг тус бүрийн хувьд харилцан адилгүй, харьцангуй бөгөөд илэрсэн зөрчил, тавьсан актын мөнгөн дүн, өгсөн албан шаардлагын тоо нь шууд хамааралтай байсан. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд хийдэг ажлуудын нэг нь зөвлөмж өгөх үйлчилгээ байдаг. Энэ нь төрийн аудитын практикт зөвлөмж өгөх үйлчилгээг орхигдуулахгүй хэрэгжүүлж буйг илтгэнэ (Дүрслэл 6).

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгахаар өгсөн албан шаардлагын тоо



Аудитаар өгсөн зөвлөмжийн тоо



Эх сурвалж: Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын мэдээлэл

Гэсэн хэдий ч баруун бүсийн аймгуудын хувьд аудитаар өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилтийн тоо мөн л тасралтгүй

өссөн байгаа нь аудиторчуудын ажлыг үнэлж дүгнэхдээ өгсөн зөвлөмж, тавьсан акт, албан шаардлагын тоог үндэслэдэг, аудитын байгууллагууд өгсөн зөвлөмжийнхөө биелэлтийн явцад тогтмол хяналт тавьж чаддаггүйтэй холбоотой гэж үзэж байна.

Аудиторуудын хэлж буйгаар орон нутагт санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах бэрхшээл тулгардаг байна. Төсвийн байгууллагуудын хувьд дотоод хяналтын систем төдийлөн хөгжиж чадаагүй байгаа нь хөндлөнгийн аудитын шалгалтыг бүрэн биелүүлэх боломжгүйд хүргэхээс гадна аудитын ажлын цар хүрээ болон ачааллыг ихээр нэмэгдүүлдэг. Цаг хугацаа, хүний нөөц, хөрөнгө санхүүгийн хүрэлцээ муутайгаас ажлын явц удааширдаг, энэ нь нэг аудиторт ногдох ажлын ачааллыг нэмэгдүүлж аудитаар хөндөх асуудлыг дутуу хамруулахад нөлөөлдөг.

Аудитын сэдвийн цар хүрээнд шалгалтанд хамрагдах байгууллагууд алслагдсан сумдад байдаг нь зардал мөнгөний хувьд хүндрэлтэй байдаг. Санхүүгийн тайлангийн аудитад иж бүрэн шинжилгээ хийх зэрэг тусгай эксперт ажиллуулах боломж бага, аудитор шинжээчид багаар ажиллаж чадахгүйгээс ажлын туршлага хуримтлагдахгүй байх. Аудитаар илэрдэг нийтлэг алдаа зөрчлүүдийг санхүүгийн тайлангийн аудитаар ангилан судлахад наад захын дансны

харилцааг буруу хийх зэрэг дутагдал дахин давтагдсаар байдаг. Зардлын зүйл анги хооронд шилжүүлсэн зөрчил санхүүгийн тайлангийн үе бүрд илэрдэг зэрэг нийтлэг сөрөг хүчин зүйл байдаг хэмээн дурьджээ.

Түүнчлэн аудиторуудын үйл ажиллагаанд холбогдох албан тушаалтнууд, шалгагдагч байгууллагын ажилтнуудын өгсөн үнэлгээ, саналыг нэгтгэн дүгнэхэд аудитаар илэрсэн зөрчлүүдийн зарим нь төрийн захиргааны болон санхүүгийн байгууллагын шалгалтаар өгсөн зөвлөмж, шийдвэртэй зөрчилдөх, аудиторуудын өгсөн зарим зөвлөмжийг свэр талдаа буюу тухайн хөрсөн дээр хэрэгжүүлэх боломжгүй байдаг гэсэн хариулт зонхилж байсан.

Мөн аудит нь зөвлөн туслагч биш, шалгаж акт тавьдаг, утга агуулга давхацсан эсвэл хамааралгүй хэт олон албан шаардлага өгдөг нь нягтлан бодогчдын ажлын ачааллыг нэмэгдүүлдэг, дарамт үүсгэдэг, удаан хугацааны туршид бэлдэж шалгуулсан ажил нь үр дүнгээ өгдөггүй зэрэг санал шүүмжийг өгсөн байна.

Шалгагдагч талын хүсдэг зүйл нь мэргэжлийн зөвлөгөө авах, алдаагаа давтахгүй засах, тусламж авах, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төсвийн байгууллагын онцлог, нөхцөл байдлыг ойлгож харгалзан үзэх зэрэг хүлээлттэй байдаг байна.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Орон нутаг дахь төрийн аудитын салбар байгууллагуудын баруун бүсийн аймгуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгээс харахад алдаа зөрчлүүд давтагдсаар байгаа ба энэ нь төсвийн байгууллагуудын нягтлан бодогчдын мэдлэг чадвар дутмаг, ажлын хариуцлага сул, дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй зэргээс шалтгаалдаг.

Нэг объектод давтан шалгалтыг тогтмол хийж байгаа нь аудиторуудын ажлын ачааллыг нэмэгдүүлсээр байгаа мөртлөө зөрчил дутагдлыг бууруулах арга хэрэгсэл болж чадахгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, акт төлбөрийг барагдуулахад холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй, зөвхөн байгууллагын төсвөөс төлдөг нь эргээд дараагийн шалгалтаар зардлын зүйл анги хооронд шилжүүлсэн гэсэн зөрчил болж харагддаг гэх мэтээр зөрчлийн гинжин хэлхээ үүсдэг, эцэстээ төсвийн хөрөнгийн зүй бус зарцуулалтын нэг хэлбэр болдог.

Аудиторуудын ажлыг илрүүлсэн зөрчил, тавьсан акт, төлбөрийн тоо, хэмжээг шалгуур үзүүлэлт болгон авч үздэг нь аудитын үйл ажилгааны үр дүн, үр нөлөөг бууруулж, шалгагдагч тал аудитад итгэх итгэлийг бууруулах хандлагыг бий болгож байна. Ийнхүү төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын гаргасан тоон мэдээлэлд хийсэн судалгаагаар санхүүгийн тайлангийн аудитын практикт шийдвэрлэвэл зохих асуудлууд оршсоор, шийдлээ хүлээсээр байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын практикт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга зам

Аудитын үндсэн үүрэг нь хараат бус байдлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх явдал байдаг. Манайд хэдийгээр төрийн аудитын хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн боловч тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөө зарим талаар хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа юм. Энэ нь төрийн аудитын тухай хуулийн үзэл санаа болох төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашигтай үр нөлөөтэй байдлыг хангах чиглэлтэй зөрчилдөж байна. Мөн үйлчлүүлэгч /шалгагдагч/ талын хүлээлт, эрэлт хэрэгцээнд тулгуурладаггүй, эрсдэлд суурилсан аудитыг хэрэгжүүлдэггүй зэрэг дутагдалтай тал ажиглагдлаа.

Төсвийн байгууллагад тогтмол илэрсээр байгаа дээрх зөрчлүүдийг багасгах, арилгахад аудитын зөвлөгөө өгөх үйлчилгээний ач холбогдлыг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Үүнийг шийдвэрлэх нэг арга зам нь аудиторуудын зүгээс өгсөн зөвлөмж, тэдгээрийн хэрэгжилт, зөвлөмжийн агуулгад мэргэжлийн дүгнэлт өгөх замаар ажлыг үнэлдэг системийг тогтоох нь зүйтэй.

Түүнчлэн орон нутаг, бүс нутгийн онцлог, аудитын талаарх онолын ойлголтын зөрүү, практик хэрэглээ, аудиторуудын мэдлэг, туршлага, мэргэжлийн үр чадвар, ажлын ачаалал зэрэг олон хүчин зүйлийн нөлөөллийг нарийвчлан судалж шийдвэрлэх шаардлага судлаач, мэргэжилтнүүдийн өмнө тавигдаж байна. ■

Бирдүүдээс яаж сална даа

А.Амарсайхан

Тээр жил баахан ухаантнууд гарч ирээд “чөлөөт эдийн засаг” хэмээгчээр замнавал Монгол Улс хөгжлийн манлайд хүрч, монголчууд бид элбэг хангалуун, сайн сайхан амьдарна хэмээн хашгирсан. Ард түмэн ч дагаж хошгирсон.

Гэвч тэр хашгираан биелсэнгүй. Монгол Улс чөлөөт эдийн засгийн зам гэгчийг даган хорь гаруй жил шогслоо. Өнөөх элбэг хангалуун, сайн сайхан амьдрал нь ирсэнгүйгээр барахгүй ард түмний амьжиргаа улам дордлоо. Төр засагтгарч суусан хэдхэн этгээд бирд болтлоо баяжсан атал ард түмэн өлөн ээлмүүн, хоосон ядуу сууцгааж байна.

Бирд гэж хэнийг хэлнэ вэ

Бирд гэхээр идээд идээд цаддаггүй, өөрийн тогоонд насандаа баршгүй их хоол овоолж өмхийрүүлсэн хэрнээ хүний тогоо руу өнгөлзөөд байдаг, хязгааргүй шуналтай адгийн мүүхай амьтан байдаг тухай үлгэрт гардаг. Тэр жил биднийг хошгируулсаар байж засгийн эрхэнд гарсан залуус одоо бирдүүд болцгоосон гэхээс өөр үг олддоггүй нь. Тэд яг л бирд шиг аашилж, ханаж цадахаа мэдэхгүй идэж ууцгааж байна.

Зүгээр ч идэж ууцгаахгүй байнгын хэрүү уруул, зодоон нүдээн болно. Олон бирд нэг дээвэр дор багтахгүй нам, бүлэг, фракц гэгчид хуваагдан, хөнжилдөө хөлөө жийлцэн тэмцэлдэж байна. Бирдүүдийн хэрүүл тэмцлийн хөлд Монгол Улс үрэгдэн сүйрч буй нь эмгэнэлтэй. Монголын ард түмэн, Монголын эдийн засаг бирдүүдийн дайны хөлд гишгэгдэн нуран унаж

байгаа нь яалт ч үгүй үнэн баримт.

Бирдүүдийн засаглал

Бирдүүд хөх, улаан, ногоон, улбар гээд өнгө өнгийн намд хуваагдан засгийн эрхийн төлөө тэмцэнэ. Засгийн эрхэнд гарахдаа сонгууль хэмээгч жүжиг тавина. Түүнд нь хөрөнгө мөнгөтэй бирдүүд өөрсдөө л ялах боломжтой. Жүжгийн дүрмийг тэд өөрсдөө зохиож, үзэгдэл бүрийг нь найруулан тавьж байдаг учир бэл бэнчингүй энгийн иргэн сонгуульд гарах ямар ч үндэслэлгүй.

Нэг өнгийн бирдүүд засгийн эрхэнд гарвал өмнө засаг барьж байсан өөр өнгийн бирдүүдийнхээ хэлсэн бүхнийг үгүйсгэж, эхэлсэн бүхнийг нураана. Энэ үйлдэл нь улс орон, энгийн иргэдэд өгүүлж барамгүй хор хохирол авчирдаг нь гачлантай.

Иргэн Гомбо үйлдвэр байгуулаад ажлаа арайхийж жигдрүүлж байтал Засгийн газар унаад шинэ сайдтай болчихно. Өнөөх сайд нь өмнөх сайдынхаа өгсөн зөвшөөрлийг хүчингүй болгоно. Дахиад л баахан тусгай зөвшөөрөл, бичиг сачиг нэхэх нь байж боломгүй. Өмнөх засгийн бирдүүдтэй холбоо сүлбээтэй гэж хардах энүүхэнд. Нэг л мэдэхэд хөөрхий Гомбын үйлдвэр хаагдсан байна.

Хорлон сүйтгэл

Нэг намын бирдүүд гаднынхантай хамтраад, ямар нэгэн үйлдвэр, уурхай байгуулах гэвэл нөгөө нам фракцын бирдүүд ёс юм шиг заавал хорлон сүйтгэнэ. Сэтгүүлчдийг хөлслөөд “Монголын баялгийг мөлжиж, идэж,



хоосруулах гэж байна” хэмээн бичүүлнэ. Иргэний хөдөлгөөн, ардын фронтыг байгуулаад жагсаал цуглаан хийж бөөн дуулиан тарьдаг нь өшөө хүрмээр.

Ерэн хэдэн онд Эгийн гол дээр усан цахилгаан станц барихаар хэдэн нөхөр гаднын нэгэн улстай хамтран төсөл эхлүүлж байсан. Гэтэл өөр хэдэн бирд гарч ирээд өөр улстай хамтарвал ашигтай гэж чанга хашгирч дуулиан болгож билээ. Бөөн хэрүүл маргаан болсны эцэст өнөөх төсөл хаагдсан. Үр дүнд нь Монгол Улс өнөөг хүртэл цахилгааны гачаалтай, хойд хөршөөс өндөр үнэтэй цахилгаан авдаг хэвээр.

Хэсэг бирдүүд нь төмөр зам барих гэнэ. Нөгөө хэд нь царигийн маргаан босгож ажлыг нь чагтлана. Эцэст нь бирдүүд ч өөрсдөө хохирно, Монгол Улс, Монголын ард түмэн бүр ч их хохирно.

Мухар сүсгийн номлол



Шог зургийг А.Амарсайхан



Бирдүүд “чөлөөт эдийн засаг” гэгч номлолыг нүдээ анин дагаж, мухар сүсгээ болгодог. Энэ онолыг номлогчид нь өөрийн орны эдийн засгаа хэзээ ч чөлөөтэй нээлттэй байлгадаггүй. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гаднаас орох гэвэл АНУ асар өндөр татвар ногдуулж өөрийн фермерүүдээ хамгаалаастай. Япон руу гаднаас үхрийн мах оруулах гэхэд гучин хэдэн хувийн татвар тавих жишээтэй. Тэгсэн хэрнээ мулгуу монгол бирдүүдийн толгойг “Эдийн засаг чөлөөтэй байх ёстой” гэсэн номлолоор мунхруулна.

“Хөдөө аж ахуйн түүхий эд, ноос ноолуур, арьс ширний экспортын татварыг тэглэ. Үгүй бол зээл өгөхгүй” гэж тэд бидэнд дарамт үзүүлсэн. Үр дүнд нь Монгол Улс юу хожив оо? Далан жилийн туршид бүтээж байгуулсан дотоодын аж үйлдвэр нь хоёр гуравхан жилийн дотор балгас болтлоо сүйрсэн.

Цаашдаа яах вэ

Туранхай бор залуучууд байхдаа тэднээс бидэнд амласан үг нь соронзон хальсанд бичээстэй, видео аудио хэлбэрээр хадгалаастай хэвээр байна. Тэд одоо арьсандаа багтахгүй болтлоо таргалсан булиабүдүүн бирдүүд болчихоод “Монгол Улсаа хөгжүүлнэ. Ард түмнээ жаргаана” гэх өнөөх хоосон үгээ хэлээстэй хэвээр.


Бирдүүдийн ард хөгшин авга ах Сэм, өмнөдийн эрэн бар, умардын цагаан баавгай гээд гаднын янз бүрийн хүчин зогсож байдаг гэж ард түмэн хардаж эхэлсэн. Энэ нь яах аргагүй үнэний ортой мэт. Монголоо гэсэн сэтгэлтэй монгол хүн байсан юм гэхэд аль хэдийнээ уурхайгаа босгоод, үйлдвэрээ бариад, төмөр замаа тавиад гуравхан сая иргэний амьдралыг дор нь өөд татчихмаар. Гэтэл бие биенээ унагааж, хэрүүл тэмцэл хийн, он

жилүүдийг барсаар суух нь сэжигтэй.

Бирдүүдийг яаж зогсоох вэ гэдэг нь асуудалтай. Дараагийн сонгуулиар бирдүүдээс сална гэх горьдлого үгүй нь аймшигтай. Тэд сонгуулийн хар хайрцаг гэгчийг оруулж ирсэн. Интернэтэд холбогдоогүй, унтраатай байхад нь хүртэл доторх мэдээллийг нь хулгайлж авч болохоор компьютерийг үйлдвэрлэж болдог тухай баримтууд саяхан дэлгэгдсэн. Тэрхүү цахим хар хайрцагны мэдээлэлд зайнаас нэвтрэх боломжгүй гэдэгт итгэж яагаад ч боломгүй.

Бид хорин хэдэн жил харлаа. Улаан ч бай, хөх ч бай, улбар ч бай бирдүүд ялгаагүй. Тэд Монгол орноо хэзээ ч хөгжүүлэхгүй гэдэг нь харагдсаар, мэдрэгдсээр л. Бирдүүдээс яаж салах вэ? Цаашдаа бид яах вэ? Ингэж харж суусаар сүйрэх үү? гэж хий дэмий асуух л үлдэж байна. ■

Made in Poland



Polska



ПОЛЬШ “АМТ”

Польш улс Европын хобооны 28 орноос Монгол Улстай худалдаа хийж буй орнуудын эхний гуравт багтдаг. Өнгөрсөн оны эхний гурван улирлаас харвал тус улсаас Монголыг чиглэх экспорт 27 сая еврогоор хэмжигдэж байв. Үүний 90 хувийг хүнс, гоо сайхан, цахилгаан барааны экспорт эзэлдэг байна. Ирээдүйн хөгжил хэрхэх бол.

Польш улс Европын холбоонд 10 жилийн өмнө нэгдсэнээс хойш тус улсын хүнсний бүтээгдэхүүний экспорт 5 тэрбум еврогоос 2013 онд бараг 20 тэрбум евро болон гурав дахин нэмэгдсэн. Ямар төрлийн бэтээгдэхүүн энэхүү амжилтанд нөлөөлсөн юм бол?

Польшийн хүнсний салбар өргөн цар хүрээтэй түүхий болон боловсруулсан бүтээгдэхүүнийг санал болгодог. Сүүлийн үед боловсруулсан бүтээгдэхүүнийг илүүтэй сонирхох болсон ч мах, ногоо, жимс, сүүн бүтээгдэхүүн, үр тариа болон өндөг нь Польш улсын экспортын хамгийн эрэлттэй бүтээгдэхүүнүүд аж.


Польшийн бүтээгдэхүүнүүд боломжийн үнэ ба өндөр чанараараа алдартай бөгөөд энэ нь уг бүтээгдэхүүнүүдэд гадаадын зах зээл дээр өрсөлдөх чадвартай болгож өгдөг аж. Польшийн хүнсний салбар Европын холбооны нийт борлуулалтын хэмжээний 15 хувьтай тэнцдэг, мөн Польшийн бараг 24 хүртэл хувийг бүрдүүлдэг.

Польш улс Европын холбооны жимс болон хүнсний ногооны зах зээлийн тэргүүлэгч юм. Тус улс 2013 онд жимсний экспортоос 715 сая евро, мөн хүнсний ногооны экспортоос 580 сая еврогийн ашигийг олжээ. Тухайн жил нийт 3,3 сая тонн жимс мөн 4,4 сая тонн хүнсний ногоо хурааснаас 674 мянган тонн хүнсний ногоо мөн 1,488 тонн жимсийг экспортолсон байна. Польшийн ямар бүтээгдэхүүн хамгийн алдартай вэ? Тус улс нь алим боловсруулалт болон экспортоор дэлхийд тэргүүлэгч юм. Польшид ургаж байгаа бүх алимны гуравны нэг нь бусад

Тус улсын эрэлттэй жимс болон хүнсний ногооноос дурдвал бөөрөлзгөнө ба үхрийн нүд (Польш улс дэлхийн үхрийн нүдний 50 хувь мөн бөөрөлзгөний 20 хувийг хангадаг), гүээлзгэнэ, нэрс, интоор, сонгино, байцаа, улаан лооль болон лууван зэрэг байдаг. Мөн тус улс нь дэлхийд мөөг үйлдвэрлэлтээр тэргүүлдэг.

Польшийн хүнсний 87 хувь нь Европын холбооны орнуудруу экспортологддог. ОХУ, Норвеги болон япон зэрэг бусад улсруу мөн экспортодог аж. Польшийн хүнсний экспортын нийт ашиг 2013 онд ойролцоогоор 20 тэрбум евро байжээ.

СОНИРХОЖ



Хэрэв та Польшийн хүнсний салбарын компаниудтай холбогдож, тэдний экспортлох бүтээгдэхүүний талаар сонирхож байгаа бол доорх хаягаар холбогдоно уу:

Trade and Investment Promotion Section
1, Ritan Lu, Jianguomenwai,
100600 Beijing, Peoples Republic of China

ph: +86-10-65321888 fax: +86-10-65324958
e-mail: beijing@mg.gov.pl
www.beijing.mfa.gov.pl

Made in Poland



Эдийн засгийн шинжилгээ таамгаас үзэхэд Туркменистан улсын экспорт улам нэмэгдэх төлөвтэй байна. Польш улс туркмен барааны импортоор Европтоо тэргүүлэгч юм. Тус улсаас түлш болон нэхмэл бараа бүтээгдэхүүнийг түлхүү импортолдог аж. Түүнчлэн Польшийн Туркменистан улс руу хийх экспортын хэмжээ нэмэгдэж байна. Тавилга, механик болон цахилгаан тоног төхөөрөмж, эмийн болон хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн зэрэг барааг Туркменистан улс Польш улсаас импортолдог. Блумберг болон Европын холбоо 2013 онд Польш улсыг Төв болон Зүүн Европын улсуудаас хөрөнгө оруулалт татах хамгийн таатай нөхцөлтэй орноор нэрлэсэн. Мөн дэлхийн эдийн засгийн хямралын үеэр Польшийн зах зээл харьцангуй тогтвортой байсан. Ингээд Польшийн хүнсний салбар тус улсын эдийн засагт ямар ач холбогдолтой байдгийг үзэцгээе.

Польшийн үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2013 онд тус улсын хүнсний салбар дангаараа 358 мянган хүнийг ажлын байраар хангаж, тус улсын нийт ажилчдын 14,5 хувийг бүрдүүлж байсан аж. 2013 онд нийт 22 тэрбум еврогийн худалдаа хийж Польшийн борлуулсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 16.6 хувийг эзэлж байжээ.

Урьдчилсан таамгаар цаашдын ирээдүй бүр ч эерэг байх хандлагтай байна. 2014 онд Польш улсаас АНУ руу гахайн мах экспортлох гурав дахин нэмэгдэж 42 сая еврогийн агиштай ажиллах орлоготой болсон. Улмаар Польш улс АНУ-ын гахайн махны гурав дахь том экспортлогч болжээ. Тун удахгүй АНУ Европоос авах үхрийн махны экспортыг сэргээх гэж байна. Мөн таамаглаж буйгаар 2015 онд АНУ-ын зах зээлд цөцгийн тос, бяслаг зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүн эрэлттэй байх аж. Европын холбооны 2014 оны эхний гурван улирлыгажигад Польшийн сүүн бүтээгдэхүүний ач болбогдол нэмэгдсэнийг харж болно. Сүүн бүтээгдэхүүн болон мах нь Польшийн хүнсний салбарын хамгийн гол экспортын бүтээгдэхүүн юм.

Европын холбооны 2014 оны эхний гурван улирлыгажигад Польшийн сүүн бүтээгдэхүүний ач болбогдол нэмэгдсэнийг харж болно. Сүүн бүтээгдэхүүн болон мах нь Польшийн хүнсний салбарын хамгийн гол

Махны салбар Польш улсын ДНБ-ий 1.5 хувийг эзэлдэг бөгөөд нэг сая гаруй ажлын байрыг бий болгодог. "Jbb", "Sokafyw S.A", "LmeatLukyw S.A." болон "PKM Duda" зэрэг компани энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй бөгөөд эдгээр компаниуд Европын холбооны зах зээлээс гадна Япон, Арабын Нэгдсэн Эмират, АНУ, ОХУ болон Африкийн улсуудруу бүтээгдэхүүнээ экспортлодог аж.

1928 онд байгуулагдсан "Mlekovita" мөн 30 жилийн түүхтэй "Mlekpól" нь Польшийн сүү, сүүн бүтээгдэхүүний гол үйлдвэрлэгч юм. Тус хоёр компани аль аль нь дотоодын болон гадаадын зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн.

Польш улс Европын холбоонд 10 жилийн өмнө нэгдсэнээс хойш тус улсын хүнсний бүтээгдэхүүний экспорт таван тэрбум еврогоос 2013 онд 20 орчим тэрбум евро болон гурав дахин нэмэгдсэн.



Хэрэв та Польшийн хүнсний салбарын компаниудтай холбогдож, тэдний экспортлох бүтээгдэхүүний талаар сонирхож байгаа бол доорх хаягаар холбогдоно уу:

Баку хотод байрлах Польшийн Элчин сайдын яам
2 Kichik Gala, Icheri Sheher (Old City)
Baku, AZ-1000, Azerbaijan

Утас: +994 (12) 492 01 14
Утас: +994 (12)497 52 81; 497 47 08
Факс +994 (12) 492 02 14

baku.amb.sekretariat@msz.gov.pl
http://www.baku.msz.gov.pl



Project co-financed by the European Union from European Regional Development Fund.